

Хятад дахь

СЭТГҮҮЛ

**ЗҮЙН ОГЦОМ
УХРАЛТ**

@Badmundo

RSF Хил Хязгааргүй
Сурвалжлагчид

Агуулга

Өмнөх үг	3
Мэдээлэл олж авахад учрах саад нэмэгдсээр байна	4
1 - БЭЭЖИН СЭТГҮҮЛ ЗҮЙТЭЙ ХЭРХЭН ДАЙН ЗАРЛАВ	6
• Нам хэвлэл мэдээллийн эсрэг эрх мэдлээ бататгасан нь	8
Улаан шугам татсан нь	8
Үзэл суртлын хэмжээлшгүй хяналт дор	11
Мөрдөн тагнах ажиллагааг сөрөхөөр сурвалжлагчид шинийг эрэлхийлнэ	14
• Онилох бай нь сэтгүүлчид болов	18
Хараат бус сэтгүүл зүй мөхлийн замдаа	19
Шинжааны хэвлэл мэдээлэл бүслэлтэд орсон нь	22
Гадаадын сурвалжлагчид хүсээгүй гэрч болсон нь	24
2 - ХОНКОНГ: ОГЦОМ УНАЛТАД ОРСОН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ	26
• Хараат бус хэвлэл мэдээллийн эсрэг дарангуйлал	28
“Үндэсний аюулгүй байдал” бүхнээс дээгүүр	28
Ад үзэгдсэн сэтгүүлчид	32
Apple Daily задран нурсан нь	35
• Хорин жилийн турш уруудан доройтсон хэвлэлийн эрх чөлөө	37
Доройтлын цаг тооллыг урьдчилан таамагласан нь	37
Сурвалжлагчид бие махбодийн хүчирхийлэлд өртсөн нь	40
Кэрри Ламын салаа утгатай үгс	42
3 - МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ НЬ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОГДОХ ҮЕ	46
• Олон нийтийн санаа бодлыг хянах санаархал	48
Ковид-19: Эрх чөлөөний тэсрэлт тэр дороо хүчинд автан дарагдав	48
Хятадын интернэт орчин мөрдөн тагналт дор	51
Эсэргүүцэх олон арга бий	55
• Сэтгүүл зүйг хориглосон нийгмийн алсын хараа	58
Бээжингийн зохиосон хэвлэл мэдээллийн загварыг амжилттай гадагш гаргав	58
“Хятадын түүх”-ийг албадан тулгасан нь	62
Ардчилсан орнууд суртал ухуулгын эсрэг тэмцэл өрнүүлсэн нь	66
4 - RSF-ИЙН УРИАЛГА, ЗӨВЛӨМЖ	68
Хятадын эрх баригчдад хандсан уриалга	70
Засгийн газрууд, институциудад хандсан уриалга	70
Сэтгүүлчдэд хандсан зөвлөмж	71
Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийтлэлчид, нийгмийн сүлжээнийхэнд хандсан зөвлөмж	72
RSF сэтгүүлчдийн аюулгүй байдлын нөөц платформ байршуулав	74
RSF-ийн тайлан: Дэлхийд хэвлэл мэдээллийн шинэ дэг журам тогтоох	75
Хятадын санаархал	76
Тайлбар толь	80
Бадиуцаогийн зурсан нүүр хуудасны зураг	

Өмнөх үг



Кристоф Делуар
Ерөнхий нарийн
бичгийн дарга

Буруу замаар эрчтэй давхиж буй нь

Шинэ мянганы эхэнд, эдийн засгийн урьдчилан тооцоолоогүй асар хурдтай өсөлтийн үе тохиож, Ху Жинтао дарга болон Коммунист намын зүгээс эрх чөлөөг эргэлзээгүй баталгаажуулсан үед, Хятадын хэвлэл мэдээлэл боломжийн хэрээрээ эрэн сурвалжилга, яриа хэлэлцээ хийж байв. Хятадын сэтгүүлчид, ялангуяа авлига, нийгмийн эрүүл мэндийн дуулиантай явдлыг бүх талаар эрэн сурвалжилснаар эх орон нэгтнүүддээ улс орныхоо хөгжлийн талаар ойлголт өгөөд зогсохгүй тогтолцооны гажуудлыг засах, тэгш бус байдлыг арилгах чиглэлээр төрийн аппаратад шахалт үзүүлж байсан.

Мэдээж, нийгэм, улс төрийн тогтолцооны гол цөм бүрхэг хэвээр байсан нь тодорхой ч сэтгүүл зүйн үйл ажиллагааны цар хүрээ бага багаар асуудал бүрийг сөхөж, ялангуяа тулгамдсан асуудлыг хөндөх найдвар төрүүлж байсан. Төв рүүгээ тэмүүлдэг эргүүлэг адил Хятадад эрх чөлөөг захаас нь төв рүү чиглүүлж нухчин дарах хэрэгтэй болсон.

Төрийн эрхийг 2013 оноос хойш барьж буй Ши Жинпин дарга хэсэгхэн нээлттэй байдлыг ул мөргүй арилгаж, мэдээллийг чөлөөтэй авах нь гэмт хэрэг, мэдээлэл өгөх нь хүнд гэмт хэрэгт тооцогддог байсан Маоизмын үеийн хэвлэл мэдээллийн соёлыг сэргээсэн юм. Хамгийн олон сэтгүүлчийг хорьсон Хятад улс 2021 оны RSF-ийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 180 орноос 177-д буюу сэтгүүл зүй нь улс төрийн суртал ухуулга болсон Хойд Солонгосоос хоёрхон байрын өмнө жагссан юм.

Хятадын сэтгүүлчдээс тус улсын даргын “Бодол” хэмээх бодлого, үзэл санааны баримт бичгийн мэдлэгийн шалгалт авах, нийгмийн сүлжээнд үлдээсэн ул мөрийг нь нягтлан шалгасны үндсэн дээр тэдний хэвлэлийн итгэмжлэлийн хугацааг сунгадаг болсон. Зах замбараагүй хяналт шалгалт явуулж буй эрх баригчид ойрын хугацаанд хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийг хориглох ажлыг төлөвлөж байна. Энэ бол аймшиг. Нэгэн үе хэвлэлийн эрх чөлөөний түүчээ байсан, өдгөө үндэсний аюулгүй байдлаар шалтаглан цагдан хорих явдал гаарч буй Хонконгийг энэ дарангуйлал тойрсонгүй.

Эрх баригчид санаа зорилгоо биелүүлэхийн тулд санхүүгийн болоод технологийн үлэмж нөөц зориулж буй нь Хятад дахь сэтгүүл зүйн энэ огцом ухралтыг илүү аюултай болгож байна. “Их галт хана” хэмээх интернэтийг цагдан хянах систем нь Хятадын нэг тэрбум интернэт хэрэглэгчийг ертөнцөөс тусгаарлаж буй бол үй түмэн цагдан хянагчид хор хөнөөлтэй агуулгын араас мөшгөн, хувь мессэжүүдийг нягтлан шалгадаг. Ойрын ирээдүйд царай таних, хиймэл оюун ухаанд суурилсан мөрдөн тагнах технологи болоод нийгмийн үнэлгээний систем газар авснаар сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлал хийсвэр ойлголт болж үлдэх аюул тулгарна.

2019 онд нийтлэгдсэн “Дэлхийд хэвлэл мэдээллийн шинэ дэг журам тогтоох Хятадын санаархал” нэртэй тайланд Бээжингээс сэтгүүл зүйн сөрөг хүчний үүргийг таслан зогсоож, түүнийг төрийн суртал ухуулгын хэрэгсэл болгохын тулд асар их хэмжээний мөнгө зарцуулж байгаа талаар мэдээлсэн юм. Хятадын хэрэгжүүлж эхэлсэн “Бүс ба зам” нэртэй олон улсын эдийн засгийн хөгжлийн төсөлд 139 улс орон (дэлхийн хүн амын гуравны хоёр) хамрагдсан бөгөөд эрх баригчдад хүсэл зорилгоо гүйцэлдүүлэх бүхий л боломжийг олгоод байна.

Хятад улс буруу замаар үргэлжлүүлэн эрчтэй давхиж аваас тус улсын иргэд эх оронд нь хэзээ нэгэн цагт хэвлэлийн эрх чөлөө тогтноно гэх итгэлээ алдаж, Бээжингийн эрх баригчдын дотооддоо болон хилийн чанадад сөрөг хэв загвараа тулгах гэсэн санаа зорилго биелэх болно.

Гэвч мэдээллийн хяналт эцэст нь уг системийг өөрийг нь сүйрүүлэх боломжтой бөгөөд шинэчлэл хийхээс цааргалснаар суртал ухуулгаар дамжуулан олон нийтийг дайчлах ажлыг үр дүнгүй болох магадлалтай. Ерөнхийдөө, Хятадын болон гадаадын сэтгүүлчдийн сэтгүүл зүйн эрэн сурвалжилга далд зүйлийг ихээхэн хэмжээгээр илчилж магад.

Тиймээ, ингэх боломжтой.



© Safeguard Defenders

Мэдээлэл олж авахад учрах саад нэмэгдсээр байна

• Их галт хана (Great Firewall)

Хятад дахь интернэтийн цагдан хяналтын аппаратыг “Их галт хана” гэх бөгөөд компьютерын галт ханын гүйцэтгэх түүний үүргийг Хятадын Их цагаан хэрэмтэй адилтгадаг. Зохисгүй хэмээн тооцогдох сайтуудыг блоклож, мэдээлэл солилцоог хянах чадамжтай уг системийг нураах асар төвөгтэй.

• Интернэтийн сониуч нүд

Хятадын цахим хэлэлцүүлгийн бүлгүүдийг нарийн хянадаг ба админууд нь нийтэлсэн агуулгынхаа төлөө эрүүгийн хариуцлага хүлээдэг. Түүнчлэн, цагдаагийн “Троян морь” (Trojan horse)-ны үүрэг гүйцэтгэх болсон WeChat нийгмийн сүлжээнд эрх баригчид нэвтрэн орж, хувь хүмүүсийн харилцан яриаг албан ёсны учир шалтгаангүйгээр тандахаас гадна шүүхэд нотлох баримт болгон ашиглах нь түгээмэл болсон.

• Эрх баригчдын троллуудын арми

Нийтэлсэн пост бүрдээ хагас юань (АНУ-ын найман цент)-ийн төлбөр авдаг “50 центийн арми” гэх сайн дурын суртал ухуулагчид эрх баригчдыг дэмжсэн сэтгэгдлээр интернэтийг булдаг бол “Бяцхан ягаанууд” хэмээх троллуудын арми дотоод, гадаадын нийгмийн сүлжээнд засгийн газрыг шүүмжилсэн хүмүүсийг дарамталдаг. Саяхан энэ үйл ажиллагаанд барууны сэтгүүлчдийн ажлыг гутаах зорилготой хуурамч бүртгэл хаяг бүхий гадны нөлөөлөгчид хүч нэмсэн.

• Байршлыг тагнах үйл ажиллагаа

Мушгин гуйвуулсан нэр бүхий эрх баригчдын уг ажиллагааг 2012 онд терроризм, авлигатай тэмцэх нэрийдлээр явуулж эхэлсэн. Энэ ажиллагаан дор гэрийн хорио мэт таслан хорих арга хэмжээ авахаас илүүтэйгээр дэглэмийн “хар шорон”-нд ганцаарчлан хорьдог. Хуулиар хамгаалагдах эрхийг зөрчсөн энэ харгис хэрцгий, хүнлэг бус харьцааг ихэвчлэн эрүүдэн шүүлттэй хавсарч гүйцэтгэдэг ба ийм аргаар хараат бус сэтгүүлчдийг бие махбодь, сэтгэл санааны хувьд нухчин дарж байна.

• Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (Хонконг)

Хонконгд өрнөсөн ардчиллыг дэмжигчдийн жагсаалыг таслан зогсоох зорилгоор Бээжингийн эрх баригчид 2020 оны 6 дугаар сарын 30-нд Үндэсний аюулгүй байдлын тухай хууль баталсан. Зориуд бүрхэг бичвэр бүхий, юм бүхнийг хамаатуулсан уг хуулийг “террорист үйл ажиллагаа явуулах”, “салан тусгаарлах үйл ажиллагаа явуулах”, “хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах”, “гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах” хэрэгтэй тэмцэх нэрийдлээр хараат бус дуу хоолойг боомилоход ашиглаж байна. Хятадын газар нутагт эдгээр дөрвөн төрлийн гэмт хэрэг үйлдвэл цаазын ялтай ба уг хуулийг сэтгүүлчдийн эсрэг тогтмол ашигладаг.

• Үдийн цайнд урих

Цагдан хяналт, суртал ухуулгын асуудал хариуцсан албаны “үдийн цай”-ны гэм зэмгүй урилганы цаана заль мэх нуугддаг ба энэ нь Хятадын сэтгүүлчид, гадаадын сурвалжлагчдыг айлган сүрдүүлэх арга хэрэгсэл болсон. Ийм уулзалтын үеэр сэтгүүлчдэд найрсаг сургаал айлддаг ба энэ нь тэднийг баривчлах, хөөн гаргахын өмнөх сүүлийн сануулга дохио болдог.

• Ши-гийн сургаалиар улс орноо хүчирхэгжүүлье” гар утасны програм

2019 оны аравдугаар сараас хойш Хятадын сэтгүүлчдийг хэвлэл мэдээллийн итгэмжлэл шинээр олгох, сунгахын тулд “Ши-гийн сургаалиар улс орноо хүчирхэгжүүлье” ухаалаг гар утасны програм суулгахыг албадсан. Үүгээр дамжуулан гадны этгээдүүд тушаал биелүүлэх, урьдчилан мэдэгдэлгүй хэрэглэгчдийн хувийн мэдээллийг цуглуулах боломжтой болсноор сэтгүүлчид, тэдний эх сурвалжууд аюулд өртөх болов.

• Намын өдөр тутмын зааварчилгаа

Хятадын олон нийтийн, хувийн аль нь ч бай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, интернэтийн компаниуд эмзэгт тооцогдох асуудлыг, тэр дундаа Түвд, Шинжаан, Хонконг, Тайвань, авлига, нийгмийн эмх замбараагүй байдал, тэрс үзэлтнүүдийн талаар хөндөхдөө Хятадын Коммунист намын зааварчилгааг дагаж мөрдөх үүрэгтэй. Тус намын суртал ухуулгын хэлтэс 14 яамны үйл ажиллагаанд хяналт тавьдаг бөгөөд онцлох сэдвийн жагсаалтыг, хөндөхийг хориглосон сэдвийн жагсаалтын хамтаар ХМХ-үүдэд өдөр тутам хүргүүлдэг.

• Телевизээр дамжуулан гэм буруугаа хүчээр хүлээхийг албадах нь

Цагдан хоригдсон сэтгүүлчдийг сэжиглэгдэж буй гэмт хэргээ төв телевизээр дамжуулан хүлээхийг албадаж байгаа нь хүний эрхэм чанарын эсрэг үйлдэл бөгөөд Хятадын үндсэн хуулиар баталгаажсан гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугийд тооцох зарчмын эсрэг үйлдэл юм. Аюулгүй байдлын хамгаалагчид (Safeguard Defenders) ТББ-ын мэдээлснээр, 2013 оноос хойш Хятадын төв сувгуудаар дамжуулан хамгийн багадаа 93 хохирогчийг, тэр дундаа 30 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг шүүх хурал болохоос өмнө гэм бурууг албадан хүлээлгэсэн.

1 БЭЭЖИҮН СЭТГҮҮЛ ЗҮЙТЭЙ ХЭРХЭН ДАЙН ЗАРЛАВ

- Үзэл суртлын туршилт, цагдан хяналт, сүрдүүлэг дарамт: 2013 оны эхэн үед Ши Жиньпин дарга эрх барьсан цагаас эхлэн Хятадын Коммунист нам сэтгүүлчдийг хянах үйл ажиллагааг эрс чангатгасан юм. Ямар сэдэв байхаас үл шалтгаалан албан ёсны өгүүлэмжээс зөрүүтэй мэдээ сурвалжилга бэлтгэсэн хэнийг боловч үндэсний эв нэгдэлд харшилсан хэргээр буруутгана.
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хориглож, хориотой мэдээлэл нийтэлснээр эрүүл ахуйн шаардлага хангаагүй шоронд олон жил хоригдоход хүрэх, улмаар харгис хэрцгий, хүнлэг бус харьцааны улмаас амь насаа алдахад хүргэнэ. Гэвч үүнийг хэд хэдэн сэтгүүлч, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) сөрөн зогссоор буй бөгөөд аюул заналаас үл хамааран нийтэлж, нэвтрүүлсээр байна.

Нам хэвлэл мэдээллийн эсрэг эрх мэдлээ бататгасан нь



#MeToo хөдөлгөөн, Хятад Тайваний харилцаа, Түвд Хонконгийн эсэргүүцэл: цагдан хяналтад өртөөгүй сэдэв тун цөөн.

© Noel Celis / AFP

© Lobsang Wangyal

/ AFP © Makoto Lin /

Ерөнхийлөгчийн алба (Тайвань)

Улаан шугам татсан нь

“2021 оны 7 дугаар сарын 23 • Хэнань болон бусад мужийг дайрсан аадар борооны талаар нийтэлж, нэвтрүүлэхдээ гамшигийн дараах нөхөн сэргээх арга хэмжээнд төвлөрнө үү. Цогцосны зураг зөвшөөрөлгүйгээр нийтлэхгүй байх, хэт гунигтай өнгө аястай мэдээлэхгүй байх, өнгөрсөн үйл явдлуудыг сөхөхгүй байх, тэдгээртэй холбохгүй байх. Хор хохирол, эд хөрөнгийн хохирлын талаарх тоо баримтыг зөвхөн албаны эх сурвалжаас авах. • Жэн Шуаны татвараас зайлсхийсэн хэргийн талаар бүү мэдээл. • Өнөө өглөө Төрийн зөвлөл Ковид-19-ийн гарал үүслийн судалгааны талаар хэвлэлийн бага хурал хийнэ. Бүү мэдээл.”

2021 оны 7 дугаар сарын 23-нд хэвлэл мэдээллийнхэнд илгээсэн дээрх [санамжийг](#) China Digital Times цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) ил гаргасан. Уг санамжид сэтгүүлчдэд тухайн сард төв Хятадыг дайран өнгөрсөн үерийн үр дагаврыг багасгах (үүний улмаас дор хаяж 302 хүн амь нас аа алдаж, 50 хүн ор сураггүй алга болж, хэдэн зуун мянган хүн орох оронгүй болсон), учир шалтгааныг нь эрэн сурвалжлахгүй байх, хор хохирлын талаар асуухгүй байхыг үүрэг болгосон. Түүнчлэн, Хятадын нэрт жүжигчин Жэн Шуаны татвараас зайлсхийсэн дуулиантай хэрэг (түүнд 46 сая ам.долларын торгууль ногдуулсан), Хятадын засгийн газар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Ковид-19 цар тахлын гарал үүслийг судлах төслийг нураасан хэргийг сөхөхгүй байхыг шаардсан. Хятадын Коммунист намын суртал ухуулгын хэлтсээс өдөр бүр ийм зааварчилгааг Хятадын бүх хэвлэл мэдээлэлд өгдөг бөгөөд эдгээрийг заавал дагаж мөрдөх үүрэгтэй, эс тэгвэл шийтгэл хүлээнэ.

Сүүлийн жилүүдэд сэтгүүлчдийн бичихийг хориглосон буюу “улаан шугам” татсан сэдвүүдийн тоо эрс нэмэгджээ. Сэтгүүлчид Түвд, Тайвань, Хонконг, Шинжаан, авлига, нийгмийн эмх замбараагүй байдал, тэрс үзэлтнүүд гэх мэт эмзэгт тооцогдох сэдвийг хөндөхдөө албан ёсны өгүүлэмжийг заавал дагаж мөрдөх үүрэгтэй. Үүнээс гадна Хятадын үндсэн хуулийн 35 дугаар зүйлээр баталгаажсан “үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө”-г илт зөрчин, сэтгүүлчдийг нийтлэлээ сонгох, боловсруулахдаа намын удирдамжийг дагахыг албадсан.

Цагдан хяналтаас мултрах сэдэв гэж үгүй

Байгалийн гамшгаас өгсүүлэн #MeToo хөдөлгөөн, оюутнуудын бэлгийн амьдралаас өгсүүлэн санхүү, эдийн засгийн бодлого, тэр бүү хэл Ковид-19 хямралын үеэр эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг үнэлэн сайшаах гэхчлэн цагдан хяналтаас мултраагүй сэдэв маш цөөн. 2020 оны 4 дүгээр сард Хятадын хэвлэл мэдээллийн төслийн судалгааны төвийн захирал **Дэвид Бандурски** Вашингтон Пост сонинд өгсөн ярилцлагадаа Хятадын Коммунист намын удирдлага сэтгүүл зүйг “дэглэмийн тогтвортой байдалд заналхийлж байна гэж үздэг” хэмээн мэдэгдсэн.



© Philip Fong / AFP

Өнөө цагт сэтгүүлчид гагцхүү эрх баригчдын шийдвэрлэж байгаа хэргүүдийг эрэн сурвалжлах эрхтэй болсноор тэдний шинэ мэдээлэл түгээх боломж хаагдсан. 2015 онд сэтгүүлч **Чай Жингийн** Хятадын агаарын бохирдлын асуудлыг бүтэн жилийн хугацаанд судалж мэдсэний үр дүнд бүтээсэн “Бүрхүүл доторх хот” баримтат кино нээлтээ хийснээс хойш долоо хоногийн дараа Хятадын видео платформоос устгагдсан.

2021 оны 3 дугаар сард Эрүүгийн хуульд Хятадын түүхэн үйл явдлын тухай албан ёсны өгүүллийг үгүйсгэсэн аливаа яриа хэлэлцүүлгийг хориглох заалт оруулсан. Хоёрхон сарын дараа улс төрийн тоймч, сэтгүүлч асан **Цю Зиминг** “баатрууд болон амиа золиослогчдын нэр хүндэд халдсан” хэргээр найман сарын [хорих ял авсан](#). Тэрээр 2020 оны зургадугаар сард Хятад, Энэтхэгийн цэргүүдийн хооронд гарсан хилийн ширүүн мөргөлдөөний үеэр Хятадын дэглэмийн ил тод байдлын талаар асуудал дэвшүүлж байв.

Олон ургальч үзэл, нээлттэй байдлын төгсгөл

Нийтлэг итгэл үнэмшлээс ялгаатай нь цагдан хяналт Хятадад үргэлж ийм хүчтэй байсангүй. 1990-ээд оны сүүлээс, ялангуяа Ху Жинтао 2003-2013 онд БНХАУ-ын даргаар хоёр удаа сонгогдон ажиллаж байх үед Хятадын хэвлэл мэдээллийнхэн улс орны эдийн засгийн хөгжлийг дагалдсан хэсэгхэн эрх чөлөөний үр шимийг хүртэж байсан. Тухайн үед хараат бус өнгө аясаараа нэрд гарч, авлига, хөдөөгийн ядуурал зэрэг дэвшилтэт сэдвээр нийтэлж байсан Гуанжоу хотын алдарт **Өмнө зүгийн долоо хоног тутмын сонин** (Хятадаар: Нанфан Жоумо) тэргүүтэй хэд хэдэн хэвлэл мэдээлэл эрэн сурвалжлах сэтгүүл зүй, олон ургальч үзэл санааг нээлттэй болгож эхэлсэн.

Хятадын **Эдийн засгийн сонин** эрэн сурвалжлах сэтгүүлч **Ван Кэчин**, түүний багийнхан 2001 онд "ДОХ-ын тосгон" зэрэг авлига, нийгмийн эрүүл мэндийн дуулианыг илчилснээр амьдрахын тулд цусаа худалдсан хөдөөгийн 2 сая оршин суугч ХДХВ/ДОХ-ын халдвар авсныг дэлхий нийтээр мэдсэн. Тэд мөн 2003 онд SARS (Амьсгалын замын цочмог хам шинж) өвчний дэгдэлтийг ил болгож, улмаар Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ асуудлаар мэдээлж, шүүмжлэл өрнүүлж байв.

Эрэн сурвалжлах сэтгүүлчид “мөхөж буй төрөл зүйл” болох нь

Ши Жиньпин дарга 2013 оны 3 дугаар сард засгийн эрхэнд гарснаар нээлттэй байдал үгүй болсон. Хачирхалтай нь, даргын гэр бүл соёлын хувьсгалын үеэр хэлмэгдсэн ч тэрээр Маоизмын үеийн лугаа адил хэвлэл мэдээллийн соёлыг дахин сэргээсэн. “Цахим цуурхал”-ыг дарах нэрийдлээр, үүнийг улмаар аль ч “бүдүүлэг” агуулгыг намнах арга хэмжээ болгон өргөжүүлсэн шинэ дарга төд удалгүй мэргэжлийн хэвлэл мэдээллийг атгахын хажуугаар мэргэжлийн бус сэтгүүлчид, блог хөтлөгчдийг хүчээр дарах ажиллагааг удирдан чиглүүлэв.

Засгийн газраас эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эсрэг явуулж буй “дайн”-ы улмаас редакторууд цагдан хяналтад өртөх, ХМХ, редакторуудыг хэрэгт татах эрсдэлээс болгоомжлон, цаг зав, нөөц хөрөнгөө нөр их хүч хөдөлмөр шаардсан эрэн сурвалжлах үйл ажиллагаанд зориулахаас зайлсхийх болсон. Гуанжоугийн Сун Ятсений нэрэмжит их сургуулийн хийсэн судалгааг АНУ-д төвтэй Фрийдом Хаус төрийн бус байгууллага эш татжээ. Уг судалгаагаар 2011-2017 онд Хятадад эрэн сурвалжлах сэтгүүлчдийн тоо 58 хувиар буурсан байна. Ийнхүү огцом буурсан явдлын талаар 2013-2014 онд нэг жилийн турш цагдан хоригдсон Сычуань мужийн сэтгүүлч Лю Ху 2019 онд Нью Йорк Таймс сонинд өгсөн ярилцлагадаа эрэн сурвалжлах сэтгүүлчдийг “мөхөж буй төрөл зүйл”-тэй адилтгасан. Бодит байдал дээр, ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл Синьхуа суртал ухуулгын агентлагийн албан ёсны мэдээнд тулгуурлан нийтэлж, нэвтрүүлэхдээ сэтгэл хангалуун байдаг.

АНХААРЛЫН ТӨВД

Хэвлэл мэдээллийн амыг барих “Халаасны гэмт хэрэг”

Хятадын эрх баригчид сэтгүүлчдийг дуугүй болгох үүднээс тэднийг “тагнуул хийх”, “хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах”, “хэрүүл зарга үүсгэж, маргаан дэгдээх” зэрэг гурван төрлийн “халаасны гэмт хэрэг”-т буруутгадаг. Сүүлийн нэр томъёог Хятадын хуулийн мэргэжилтнүүд бараг бүх үйлдэлд хамаатуулж болох маш өргөн хүрээнд тодорхойлсон гэмт хэргийг тайлбарлахдаа ашигладаг.

Тагнуул хийх

- **Тодорхойлолт:** Хятадын хуулиар төрийн нууцыг “улсын аюулгүй байдал, ашиг сонирхлыг хөндсөн асуудал” хэмээн тодорхойлсон бөгөөд маш өргөн хүрээний нууцын жагсаалтыг гаргасан. Эдгээрт үйлдвэрлэлийн мэдээлэл, намын удирдагчдын төрсөн огноо ч багтаж болно. Энэ жагсаалт бүрэн гүйцэд биш бөгөөд эрх баригчид цагдан хянахыг хүссэн мэдээллийг төрийн нууцад хамаатуулах боломжтой.
- **Хуулийн үндэслэл:** Хятадын Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйл; Төрийн нууцыг хамгаалах тухай хууль
- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих (“төрийн нууцыг хууль бусаар задруулсан хэн боловч [...] улсын гадна”, “гадаадад төрийн нууц задруулсан” гэдгээр илүү мэддэг), бүх насаар хорих (“тагнуул хийх”).
- **Нэмэлт мэдээлэл:** Төрийн нууц задруулсан хэргийн шүүх хурал хаалттай болдог тул дипломатууд, сэтгүүлчид оролцох боломжгүй.
- **Энэ хэргээр хоригдож буй сэтгүүлчдийн тоо:** Дор хаяж найм.
- **Гол бай:** Австралийн бизнес мэдээний хөтлөгч **Чэн Лэй**, Австралийн улс төрийн тоймч **Ян Хэнжун** нарын [Хятад гаралтай гадаадын сэтгүүлчид](#) 2020, 2019 онд тус тус баривчлагдсан. Шведийн нийтлэлч **Гуй Минхайг** 2015 оноос хойш цагдан хорьж байгаа ба 2020 онд түүнд 10 жилийн хорих ял оноосон.

Хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах

- **Тодорхойлолт:** “Улсын доторх улс төрийн эрх мэдлийг унагаах, социалист тогтолцоог нураах зорилгоор хорлон сүйтгэх үйл ажиллагаа зохион байгуулсан, хуйвалдсан, ажилласан хэн боловч”, “худал цуу тараах, гутаан доромжлох буюу бусад аргаар улсын доторх улс төрийн эрх мэдлийг унагаах, социалист тогтолцоог нураахыг өдөөн хатгасан хэн боловч.”
- **Хуулийн үндэслэл:** Хятадын Эрүүгийн хуулийн 105 дугаар зүйл.
- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих (“хорлон сүйтгэх үйл ажиллагаа”), “5-аас дээш жил шоронд хорих” (“төрийн эрх мэдлийн эсрэг хорлон сүйтгэх үйл ажиллагаанд өдөөн хатгах”).
- **Нэмэлт мэдээлэл:** Хуулиар хорлон сүйтгэх үйлдлийг гэмт хэрэг гэж үзэхэд нотлох баримт шаардлагагүй байдаг. “Хорлон сүйтгэх үйл ажиллагаа” явуулсан хэрэгт буруутгагдсан хүмүүсийг өмгөөлөгч, ойр дотны хүмүүстэй нь уулзуулдаггүй.
- **Энэ хэргээр хоригдож буй сэтгүүлчдийн тоо:** Дор хаяж 13.
- **Гол бай:** Ковид-19 цар тахлын талаар мэдээлсний төлөө 2020 оны нэгдүгээр сарын 31-нээс хойш [хоригдож буй Гую Чиаан](#) зэрэг улс төрийн тоймчид, Хятадын Коммунист намын эрх бүхий албан тушаалтныг авлигын хэрэгт буруутгасны дараа 2017 онд [найман жилийн хорих ял](#) авсан **Ву Ган**.

Хэрүүл зарга үүсгэж, маргаан дэгдээх

- **Тодорхойлолт:** “хэрүүл зарга үүсгэж, маргаан дэгдээнээр нийгмийн дэг журмыг зөрчсөн хэн боловч”, “хэрүүл зарга үүсгэж, маргаан дэгдээх” гэдгээр илүү мэддэг.
- **Хуулийн үндэслэл:** Хятадын Эрүүгийн хуулийн 293 дугаар зүйл.
- **Ялын дээд хэмжээ:** Таван жилийн хорих ял (давтан үйлдэлд 10 жил).
- **Нэмэлт мэдээлэл:** Хуульд “нийгмийн дэг журам зөрчих” гэсэн нэр томъёог тодорхойлоогүй. 2013 онд хуулийн цар хүрээг өргөжүүлж, интернэтэд нийтлэгдсэн контентийг хамруулсан нь дэглэмийг эсэргүүцсэн мэдээлэл нийтлэхийг таслан зогсоох зорилгоор “халаасны гэмт хэрэг”-т тооцох болсон.
- **Энэ хэргээр хоригдож буй сэтгүүлчдийн тоо:** Хамгийн багадаа 9.
- **Гол бай:** **Цай Вэй**, **Чэн Мэй** нарын мэргэжлийн бус сэтгүүлчид Ковид-19-ийн дэгдэлттэй холбоотой хориотой мэдээ хуваалцсаныхаа төлөө 2020 оны наймдугаар сард [15 сарын хорих ял](#) шийтгүүлсэн. **Лю Янли** Хятадын удирдагчдын талаар цахим нийтлэл бичсэнийхээ төлөө 2020 оны дөрөвдүгээр сард [дөрвөн жилийн хорих ял](#) сонссон. RSF-ийн Хэвлэлийн эрх чөлөөний 2021 оны шагнал хүртсэн **Жан Жан** Уханьд гарсан Ковид-19 халдварын эхэн үеийг мэдээлж сурвалжилсныхаа төлөө 2020 оны 12 дугаар сард [дөрвөн жилийн хорих ял](#) авсан.



2016 оны хоёрдугаар сард Ши дарга хянан шалгалтаар явж байх үед тус улсын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийг түүнийг халуун дотноор угтахыг “урьсан.”

© Ma Zhancheng / AP

Үзэл суртлын хэмжээлшгүй хяналт дор

Хятадад сэтгүүлчдийн үүргийг Хятадын Коммунист нам (ХКН)-ын албан хаагчдад зориулсан [суртал ухуулгын гарын авлага](#)д заасан байдаг. Уг гарын авлагын агуулгыг 2007 онд Wikileaks нийтэлсэн, мөн ХКН-ын Төв хорооны Тамгын газраас гаргасан дотоод санамж бичигт оруулсан. Хожим “9 тоот баримт бичиг” нэрээр танигдсан дээрх гарын авлагыг *Дойче Велле* (*Deutsche Welle*)-ийн сурвалжлагч **Гао Ю** 2013 онд олон нийтэд ил болгосныхоо төлөө “гадаадад төрийн нууц задруулсан” хэргээр таван жил [гэрийн хорионд байх](#) шийтгэл амссан.

Суртал ухуулгын гарын авлагад сэтгүүлчдийг “Үе үеийн шинэ социалист ард түмнийг төлөвшүүлэх” төрийн арга хэрэгсэл хэмээн илэрхий тодорхойлсон байдаг. Сэтгүүлчдийг “магтан сайшаах, асуудал бэрхшээлийг илчлэхдээ тэнцвэртэй байдлыг хангах” шаардлагатай гэж заасан нь өөрийгөө бүрэн цагдан хянахыг илэрхийлэх “euphemism” буюу “гоё үг” юм. “9 тоот баримт бичиг”-т “сэтгүүл зүйн барууны үзэл санаа” нь “хэвлэл мэдээлэл, нийтлэлийн тогтолцоо намын сахилга батад захирагдана гэсэн Хятадын зарчим”-ын эсрэг гэж үздэг.

2016 онд Ши Жиньпин ХКН-аас хэвлэл мэдээллийг хянах ажиллагааг чангатгах зорилгоор хэвлэл мэдээллийн томоохон шинэчлэлийг эхлүүлсэн. Тэрээр тус улсын гурван гол хэвлэл мэдээллийн хэрэгсэл (CCTV, *Ардын өдрийн сонин*, Синьхуа мэдээллийн агентлаг) дээр хяналт үзлэг хийх үеэрээ сэтгүүлчдийг “ээрэг”-ээр нийтэлж, нэвтрүүлэхэд анхаарснаар намын удирдлагыг дагаж, “хүсэл зорилго, санал санаачилгыг нь дамжуулах, эрх мэдэл, эв нэгдлийг нь хамгаалах”-ыг даалгасан. Өөрөөр хэлбэл, албан ёсны суртал ухуулгад нийцүүл гэсэн үг. Төрийн мэдлийн хэвлэл мэдээлэл хязгааргүй үнэнч шударга байх шаардлагыг дагаж, “намаар овоглох” ёстой хэмээн Ши Жиньпин үздэг.



© Simon Song / South China Morning Post

Хувийн блог хөтлөх хориотой

Жилийн дараа л гэхэд сэтгүүлчид, редакторууд нийтлэхийг хориглосон өгүүллээ хуваалцдаг байсан хувийн блог хөтлөх эрхгүй болсон. Мөн нийгмийн сүлжээгээр түгсэн мэдээллийг эрх баригчдын “баталгаажуулаагүй” тохиолдолд эш татахыг хорьсон. Хятадад үйл ажиллагаа явуулдаг гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүртэл цахимаар мэдээлэл чөлөөтэй нийтлэх боломжгүй болсон. Мэдээллийн шинж чанартай аливаа нийтлэлийг цахимд байршуулахаас өмнө төрийн захиргаанаас зөвшөөрөл авна.

Өдгөө албан ёсны, тэр бүү хэл Бүх Хятадын сэтгүүлчдийн эвлэлээс гаргаж байгаа мэдэгдлүүдэд “сэтгүүлчид” гэдэг үгийн оронд “хэвлэл мэдээллийн ажилтнууд” гэдэг нэр томъёог түлхүү хэрэглэх болсон.

“Үзэл санаа” гэгдэх Ши-гийн сургааль

2021 оны 10 дугаар сарын 8-нд Төрийн зөвлөлийн агентлаг болох Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо төрийн мэдлийн бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг “мэдээ, тэр дундаа гадаадын байгууллагуудаас гаргасан мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэвтрүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй” байхаар заасан хуулийн төсөл санал болгосон. Хэрэв ийм хууль батлагдвал одоо үйлчилж буй хязгаарлалтыг чангатгаж, эрх баригчдын хэвлэл мэдээллийн орчин дахь эрх мэдлийг бататгах, үлдэж буй хараат бус дуу хоолойг боомилох эрсдэл дагуулна.

Энэ үйл явдлаас долоо хоногийн дараа Хэвлэл мэдээлэл, нийтлэлийн асуудлаарх ерөнхий захиргаанаас мэргэжлийн сэтгүүлчид удахгүй жил болгон Ши Жиньпиний “Үзэл санаа” нэртэй сургаальд төвлөрсөн “тасралтгүй сургалт”-д доод тал нь 90 цаг суух үүрэг хүлээх талаар мэдэгдсэн. Сэтгүүлчдийн сургалтад оролцсон байдал, тэдний нийгмийн сүлжээнд үлдээсэн ул мөрийг хэвлэл мэдээллийн итгэмжлэлийг нь сунгахад харгалзана.

Ши Жиньпин даргын шийдвэрээр ХКН, түүний удирдагчдад үнэнч байх нь сэтгүүлчээр ажиллах гол нөхцөл болсон. “Ши-гийн үзэл санаа улс орныг хүчирхэгжүүлнэ” тандах програм гар утсандаа суулгахыг албадснаар сэтгүүлчдийг суртал ухуулгын бүрэн хяналтад авсан.



Энэ сэтгүүлч болон түүний хамтран зүтгэгчдэд “намын хүсэл зориг, санал санаачилгыг уламжлан дамжуулж, нэр төр, нэгдмэл байдлыг нь хамгаалах”-ыг тушаасан.

© Nicolas Asfour / AFP

АНХААРЛЫН ТӨВД



© Reuters

Сэтгүүлчдийг тагнуулын програм суулгахыг албадсан нь

“Ши-гийн үзэл санаа улс орныг хүчирхэгжүүлнэ” үзэл суртлын програмын хүчээр эрх мэдэлтнүүд сэтгүүлчид тэдний номлолд хэр үнэнч байгааг шалгах, мөн ухаалаг утсан дээрх контентийг тагнах боломжтой болсон.

2019 оны 10 дугаар сараас Хятадын сэтгүүлчид хэвлэл мэдээллийн итгэмжлэл шинээр авах, хугацааг сунгуулахын тулд Хятадын Коммунист нам (ХКН) болон Ши Жиньпин даргын номлолд үнэнч эсэхээ шалгуулах үүрэгтэй болсон. Энэ шалгалтыг зөвхөн [“Ши-гийн үзэл санаа улс орныг хүчирхэгжүүлнэ”](#) ухаалаг утасны програмаар дамжуулан өгөх ба заавал утсандаа суулгах шаардлагатай болсон.

Цахим худалдааны аварга Алибаба группын ХКН-д зориулан бүтээсэн уг програмыг хэрэглэгчдэд мэдэгдэхгүйгээр хувийн мэдээллийг нь цуглуулах боломжтой талаар Германы кибер аюулгүй байдлын Cure 53 фирм илчилсэн. Бусад онцлог шинжийн дотор файлуудыг өөрчлөх, програм татах, дуудлага хийх, төхөөрөмжийн микрофоныг асаах хүчин чадалтай.

Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) байгууллага сэтгүүлчдийг тэдний болон эх сурвалжийнх нь аюулгүй байдлыг эрсдэлд оруулж болзошгүй энэ програмыг татаж авахаас зайлсхийхийг маш шаргуу зөвлөж байна. Уг програмыг татаж авах зайлшгүй шаардлага тулгарсан бол аливаа эмзэг мэдээлэл хадгалагдаагүй зөвхөн энэ зориулалтаар ашиглах тусгай төхөөрөмж хэрэглэхийг зөвлөж байна.

Мөрдөн тагнах ажиллагааг сөрөхөөр сурвалжлагчид шинийг эрэлхийлнэ

Хятадад дарангуйлал ихсэх тусам сэтгүүлчид эрх баригчдын анхаарлыг татахгүйгээр эрэн сурвалжлагч арга хэрэглэхээс өөр аргагүйд хүрч байна. 2019 онд **Исобель Йунг** тэргүүтэй олон улсын мэдээллийн VICE News цахим хуудасны багийнхан Шинжаан дахь Уйгур угсаатны хэлмэгдүүлэлтийн тухай далд камер ашиглан бичлэг хийхдээ жуулчдын дүр эсгэсэн. Гэвч энэ арга хэмжээ хязгаарлагдмал, учир нь, дээрх бичлэгийг цахимд байршуулсны дараа сэтгүүлч Хятад руу буцаж очиход хэтэрхий эрсдэлтэй байсан.


Шанхайд Үндэсний олон нийтийн радиогийн сурвалжлагч асан **Фрэнк Лангфитт** 2011-2016 онд ярилцлага өгсний хариуд таксигаар үнэгүй хүргэх үйлчилгээ үзүүлж байснаар дүрд тоглох арга техникийг нэг алхам ахиулсан. Тэрээр сэтгүүлч гэдгээ нуудаггүй байсан ба үйлчлүүлэгчдийн зөвшөөрлөөр бичлэг хийдэг байсан.

Хятадад үйл явдал дээрээс сурвалжлахыг хориглосон сэтгүүлчид мөн нээлттэй мэдээллийн эх сурвалжтай ажилладаг. Тийнхүү *Ассошиэйтэд Пресс* агентлагийн сурвалжлагч **Янань Ван**, *Foreign Policy* сэтгүүлийн ерөнхий редакторын орлогч **Жеймс Палмер**, Францын *Le Monde* сонин дүрс бичлэгийн тасаг Хятадын төрийн худалдан авах ажиллагаа, хиймэл дагуулаас авсан гэрэл зураг, нийгмийн сүлжээнд нийтлэгдсэн зургийг нягтлан шалгах замаар алсын зайнаас Шинжаан дахь Уйгур угсаатныг хэлмэгдүүлэх ажиллагааг эрэн сурвалжилсан.

Нью-Йоркт төвтэй BuzzFeed News сэтгүүлийн Бээжин дэх товчооны захирал асан, сэтгүүлч **Мега Ражагопалан**, түүний хамтран зүтгэгчид **Алисон Киллинг**, **Кристо Бушек** нар сансрын хиймэл дагуулаас авсан зураг ашиглан уйгурчуудыг үй олноор цагдан хорьсон явдал бодит болохыг нотолсныхоо төлөө [2021 оны Пулитцерийн шагнал](#) хүртжээ.

Харилцан яриа өрнүүлэх хөшүүрэг: Үндэсний олон нийтийн радиогийн Шанхай дахь сурвалжлагч Фрэнк Лангфитт 2011-2016 онд харилцан яриа өрнүүлэх өвөрмөц санаа хэрэгжүүлсэн

© Kuan Yang



Нийгмийн сүлжээ, нийтэд ил болсон мэдээ баримт, хиймэл дагуулаас авсан гэрэл зураг: Үйл явдлын талбарт нэвтрэхийг хориглосон тохиолдолд сэтгүүлчид эрэн сурвалжлахын тулд нийтийн мэдээллийг ашигладаг.

© Teh Eng Koon / AFP

Эх сурвалж хамгаалах

Сэтгүүлчдийн хувийн мэдээлэл, эх сурвалжийг хамгаалах нь мөн томоохон асуудал болоод байна. Бээжин дэх *Вашингтон Пост* сонин туслах асан **Жан Жиэ** цагдаа нарт баригдахгүйн тулд хүний эрхийн төлөө тэмцэгчидтэй холбогдохдоо урьдчилгаа төлбөрт сим карт, хуучин утас зэргийг ашиглаж байсан тухайгаа 2017 онд ярьсан.

"Америкийн дуу хоолой" радиогийн Түвдийн мэдээ бэлтгэдэг, цөлөгдсөн сэтгүүлч **Жалцан Чодак** WeChat, Хятадын бусад бичил блогээр дамжуулан эх сурвалжуудтайгаа ярихдаа эрх баригчдад танигдахгүйн тулд дуу хоолойны өнгө өөрчлөх програм байнга ашигладаг байсан тухайгаа 2021 оны 3 дугаар сард ярьсан.

WeChat нь дэлхий даяар тархан суурьшсан Түвд хүмүүсийн, ялангуяа сэтгүүлчдийн хамгийн өргөн хэрэглэдэг мессежийн програм боловч тэд мэдээллээ алдах эрсдэлээс болгоомжлон хэд хэдэн гар утас хэрэглэж, өөр хоорондоо кодлосон хэлээр харьцдаг. Ингэснээр, тагнах ажиллагаанд өртөх эрсдэлийг бууруулахад дөхөмтэй ч үүнээс бүрэн хамгаалж чадахгүй гэж гадаад дахь Түвдийн хэвлэл мэдээллээр 2021 онд нийтлэгдсэн судалгааны бүтээлд нэрийг нь нууцалсан сэтгүүлч [учирласан](#).

Үг хэллэгт анхаарах нь

Хятадын сэтгүүлчид хориотой мэдээлэл нийтэлснээр шоронд орж болзошгүй. Гуанжоу хотод *Өмнө зүгийн их хотын өдөр тутмын сонин*, *Өмнө зүгийн долоо хоног тутмын мэдээ*, *Янчэн үдшийн мэдээ* зэрэг томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Хятадын хуулийн мэргэжилтнүүдэд хандан, эрэн сурвалжилга хийх явцад нь учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, үг хэллэгээ сонгоход нь зөвлөхийг [уриалсан](#). Нэрээ нууцлахыг хүссэн нэгэн хуульч "Хуулийн хүрээнд асуудлыг хэрхэн зөв тодорхойлохоо бид мэднэ. Албан ёсны суртал ухуулгыг сөрөхийн тулд албан ёсны үг хэллэг ашигладаг" гэжээ.

Сэтгүүлчид өөрсдийгөө эрсдэлд оруулахгүйгээр олон нийтэд мэдээлэхийн тулд үг хэллэгтээ янз бүрийн аргаар анхаарч байна. Тухайлбал, албан тушаалтнуудын нэр цохон дурдахгүй байх, Засгийн газрыг эерэг талаас нь харуулах, санал дэвшүүлэх маягаар шүүмжлэл өрнүүлэх гэх мэт арга хэрэглэж байна.

Ямар ч үнээр хамаагүй хэвлэн нийтлэх

Цагдан хяналттай тулгарснаар сэтгүүлчид цуглуулсан мэдээллээ нийтлэхийн тулд далд арга хэрэглэхээс аргагүйд хүрдэг. Хятадын сэтгүүлчид өгүүллийг нь дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэхээс татгалзсан тохиолдолд гадаадын хэвлэл мэдээлэлд хандах нь бий. Австралид амьдардаг Хятадын сэтгүүлч **Вики Сю** уйгурчуудыг хэлмэгдүүлэх ажиллагааны талаар 2019 онд *Нью Йорк Таймс* сонинд нийтлүүлж байсан. Үүний улмаас түүнийг сүрдүүлэн заналхийлэхийн зэрэгцээ 2021 оны дөрөвдүгээр сард улс орон даяар нэр сүрийг нь гутаах аян өрнүүлсэн.

Нийгмийн хэвлэл мэдээллээр дамжуулан нэрээ нууцлан нийтлэх нь цагдан хяналтад өртсөн үед сэтгүүлчдийн харилцааны эцсийн арга болж байна. Эрэн сурвалжлах сэтгүүлч **Хуан Сюэчиний** ойр дотны хүмүүс энэ аргыг хэрэглэсэн. Түүнийг 2021 оны 9 дүгээр сард [баривчилсны](#) дараа нөхцөл байдлынх нь талаар мэдээлэхдээ тэд #FreeXueBing хаштаг ашиглан Твиттер, Фэйсбүүк, Github дээр нэргүй хаягнаас бичсэн.

Цагдан хяналтыг сөрсөн ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮД

Бээжингээс цагдан хянах, сүрдүүлэн дарамтлах нь ихсэж байгаа хэдий ч Хятад болон бусад улсад төвтэй хэд хэдэн хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) Хятад хэлт ард түмний дунд өрнөж буй үйл явдлын талаар эрэн сурвалжилж, олон нийтэд мэдээлэл хүргэсээр байна.



1 - ЭХ ГАЗРЫН ХЯТАД



Цайсинь

2009 онд Бээжин хотод үүсгэн байгуулагдсан долоо хоног тутмын Цайсинь сонин, түүний хятад-англи хос хэлээр эрхлэн гаргадаг цахим хуудас Хятадын хамгийн хараат бус ХМХ-д тооцогддог бөгөөд эрх баригчдын тогтоосон улаан шугамыг байнга сөргөж байдаг. 2020 онд цагдан хянах ажиллагаа эрчимжсэнийг үл харгалзан Уханьд Ковид-19 өвчнөөр нас барагчдын албан ёсны тоо эргэлзээтэй байгаа талаар Цайсинь эрэн сурвалжилсан. 2021 оны 10 дугаар сард Цайсинийг мэдээллийн эх сурвалж болгон эш татах боломжтой хэвлэл мэдээллийн албан ёсны жагсаалтаас хассан. caixin.com



Хятадын иргэний хөдөлгөөн

Хятад хэлээр эрхлэн гаргадаг мэдээллийн тус сайт Хятадын зохиолч, улс төрийн тоймч Сю Жион хоригдсоны дараа 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Хятад дахь иргэний нийгэм, хүний эрхийн чиглэлээр мэдээлдэг. cmcn.org




Жунсун (Олон нийтийн төлөөх мэдээлэл)

2018 онд үүсгэн байгуулагдсан Хятад хэл дээр нийтэлдэг тус мэдээллийн сайт мэргэжлийн бус Хятад сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээг нийтэлж, эрх баригчдын нийтлэхийг хориглосон контентийг байршуулдаг. zhongxuncn.blogspot.com



64 Тяньван

1998 онд үүсгэн байгуулагдсан Хятад хэл дээр нийтэлдэг тус мэдээллийн сайт Хятадад үйлдсэн хүний эрхийн олон арван мянган зөрчлийг баримтжуулсан бөгөөд 2016 онд RSF-ийн шагнал хүртсэн. 2004 оны RSF-ийн Хэвлэлийн эрх чөлөөний шагналтан, тус сайтыг үндэслэгч, эрэн сурвалжлах сэтгүүлч Хуан Чи "гадаадад төрийн нууц задруулсан" хэргээр 12 жилийн ял эдэлж байна. 64tianwang.net



Вэйчуанван (Эрхийн нөлөөллийн сүлжээ)



Хятад хэл дээр нийтэлдэг тус мэдээллийн сайтыг сайн дурынхан ажиллуулдаг. 2008 оноос хойш Хятад дахь хүний эрхийн зөрчлийн талаар, түүн дотроо идэвхтнүүд, сэтгүүлчдийг баривчлах, сураггүй алга болгох, хууль бусаар хорих хэргийн талаар мэдээлж байна. wqw2010.blogspot.com



Миншэн Гуанча (Иргэний эрх ба амьжиргааны харуул)

2006 онд үүсгэн байгуулагдсан Хятад хэлээр эрхлэн гаргадаг мэдээллийн энэ сайт ажилчин ангийн, түүн дотроо ажилчид, багш нарын эсрэг хүчирхийллийг мэдээлж сурвалжлахын зэрэгцээ томоохон хотууд дахь хүчээр нүүлгэн шилжүүлэх ажиллагааны талаар нийтэлдэг. Түүний үндэслэгч Лю Фэйюэ "хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан" хэргээр 2019 онд таван жилийн хорих ял авсан. msguancha.com

2 - ХОНКОНГ



Citizen News (Иргэний мэдээ)

Хятад хэл дээр нийтэлдэг ашгийн бус тус цахим мэдээллийн хэрэгслийг Хонконгийн сэтгүүл зүйн 10 ахмад ажилтан 2017 онд үүсгэн байгуулсан. 2021 оноос хойш урьд нь i-CABLE сувгаар цацагдаж байсан алдарт "China Beat" нэвтрүүлгийн багт ажиллаж байсан хүмүүстэй хамтран Хятадын цаг үеийн асуудлаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэж байна. hknews.com




Хонконгийн чөлөөт хэвлэл (Hong Kong Free Press)

Хонконгд 2015 онд үүсгэн байгуулагдсан Хонконгийн чөлөөт хэвлэл нь ашгийн бус, олон нийтийн санхүүжилттэй, хятад хэлт ард түмний мэдээг англи хэлээр нийтэлж, нэвтрүүлдэг мэдээллийн цахим хуудас юм. hongkongfp.com



InMedia

2004 онд байгуулагдсан Хятад хэлээр эрхлэн гаргадаг тус цахим ХМХ "нийгмийн ардчилсан хөдөлгөөний төлөөх хараат бус мэдээ, хэвлэл мэдээллийн талбар" хэмээн өөрсдийгөө тодорхойлсон. Цахим сайтын талбар Хонконгийн мэргэжлийн бус сэтгүүлчдийн нийтлэл, мэдээ сурвалжилгад нээлттэй байдаг. inmediahk.net



Stand News (Мэдээний индэр)

2014 онд Хонконгд үүсгэн байгуулагдсан энэхүү хараат бус, өргөн хүрээний агуулга бүхий Хятад хэлээр эрхлэн гаргадаг мэдээний сайт Хятадын улс төр, нийгмийн асуудлыг хамарч, "ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёс, шударга ёс"-ны үнэт зүйлсийг эрхэмлэдэг. thestandnews.com

3 - ТАЙВАНЬ



Сурвалжлагч (The Reporter)

Тайваньд төвтэй, Хятад хэлээр гардаг, ашгийн бус мэдээллийн тус сайт нь 2015 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Хятад хэлт нийгмийн талаар мэдээлэх, эрэн сурвалжлахад голлон анхаардаг. Шинжаан дахь "дахин хүмүүжүүлэх лагерь"-уудын талаар мэдээлсний төлөө 2020 онд Хонконг дахь Хүний эрхийн хэвлэл мэдээллийн шагнал зэрэг сэтгүүл зүйн нийт 62 төрлийн шагнал хүртсэн. twreporter.org

4 - СИНГАПУР



Initium Media

Өргөн хүрээний агуулга бүхий Хятад хэлээр эрхлэн гаргадаг энэхүү цахим ХМХ нь 2015 онд Хонконгд үүсгэн байгуулагдсан. Тус ХМХ 2020 онд сэтгүүл зүйн үйл ажиллагааны төлөө Ази дахь Нийтлэлчдийн нийгэмлэг (SOPA)-ээс дөрвөн төрлийн шагнал хүртсэн. Дарамт шахалтаас зайлсхийх үүднээс Inition Media 2021 онд төв байраа Сингапур руу нүүлгэхээр шийдсэн. theinitium.com

5 - ЭНЭТХЭГ



Түвдийн Пост Интернэшнл (Tibet Post International)


Гурван хэл дээр (англи, түвд, хятад) нийтэлдэг мэдээний цахим хуудсыг 2007 онд Хойд Энэтхэгийн Дарамсала руу хөөгдөж, цөлөгдсөн Түвдийн хэсэг сэтгүүлч үүсгэн байгуулсан. Тус сайт БНХАУ-ын Түвдийн өөртөө засах оронд болж буй хүний эрхийн зөрчлийн талаар түлхүү мэдээлж сурвалжилдаг. thetibetpost.com

6 - АНУ




Boxun News

Хятад хэлээр эрхлэн гаргадаг мэдээллийн уг сайт нь 1998 оноос хойш халдварт өвчин, хүний эрхийн зөрчил, авлига, хээл хахуулийн дуулиант хэргүүд, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг эрх баригчдын хориглосон мэдээ мэдээллийг Хятадын мэргэжлийн бус сэтгүүлчдээс хүлээн авч нийтэлж байна. boxun.com



China Digital Times

2003 онд АНУ-д үүсгэн байгуулагдсан хятад-англи хоёр хэлээр эрхлэн гаргадаг энэхүү цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь суртал ухуулгын хэлтсийн зааварчилгаа, албан ёсны үг хэллэг, хэрэглэхийг хориглосон түлхүүр үгсэд дүн шинжилгээ хийж, орчуулан хүргэх замаар Хятад дахь суртал ухуулга, цагдан хяналт, кибер туршуулын ажиллагааны талаар үнэлж баршгүй мэдээлэл хүргэдэг. Chinadigitaltimes.net



Mingjing News

Mingjing News бол Хятадын улс төр, бизнес, нийгмийн асуудал, түүхийн талаар нийтэлдэг, оролцоонд тулгуурласан мэдээний сайт юм. 2014 онд засгийн газраас Коммунист намын Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүн Жоу Юнканы эсрэг зохион байгуулсан нууц мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлсний дараа кибер халдлагад өртсөн. Улмаар Жоу Юнканы шүүх хурал хаалттай болж, түүнд бүх насаар хорих ял оноосон. Mingjingnews.com

Онилох бай нь сэтгүүлчид болов



Албан тушаалтнуудын авлигын хэргийг илчлэх, шог зураг нийтлэх, хүний эрх хамгаалахаар зориглосон сэтгүүлчид шүүхийн хаалга татахад хүрнэ.

© RFA - © Weibo - © CCTV - © Twitter

Хараат бус сэтгүүл зүй мөхлийн замдаа

Ши Жиньпин дарга 2013 оны эхээр засгийн эрхэнд гарсны дараа сэтгүүлчид, улс төрийн тоймчид Маоизмын үе дууссанаас хойш улс орон даяар урьд өмнө гарч байгаагүй их баривчилгаанд өртсөн. Ийнхүү 10-аад жил өрнөсөн Хятадын хэвлэл мэдээлэл дэх олон ургальч үзэл, яриа хэлэлцээний сорилт гэнэт тасрав. RSF-ийн 2021 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр БНХАУ 180 орноос 177-д бичигдэж, Хойд Солонгосоос ердөө хоёрхон байрын өмнө жагсаж буй бөгөөд тус улсад хамгийн багадаа 127 сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний хамгаалагч хоригдож байна.

2004 оны RSF-ийн Кибер эрх чөлөөний төлөө шагналын эзэн, 64 Тяньван хүний эрхийн талаарх мэдээллийн цахим хуудсыг үндэслэгч, эрэн сурвалжлах сэтгүүлч **Хуан Чи** 2016 онд баривчлагдсан. 2019 онд Мянъян Ардын дунд шатны шүүхээс (Сичуан муж) түүнд Хятадын албан тушаалтнуудын үйлдсэн хүний эрхийн зөрчлийг эрэн сурвалжилсан хэргээр [12 жилийн хорих ял](#) оноосон. 2020 оны 4 дүгээр сарын 30-нд Хятадын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн ажилтан асан сэтгүүлч **Чэн Жиерэн** Коммунист намын хэд хэдэн албан тушаалтныг авлигын хэрэгт холбогдсон баримт илчилсэн хэргээр Гуян хотын (Хунан муж) Ардын шүүхээс [15 жилийн хорих ял](#) сонссон. 2018 оны 7 дугаар сард шог зургаараа алдартай уран бүтээлч **Зян Ифэй** [зургаан жил хагасын хорих ял](#) сонссон бол нэрт сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч **Чин Йонмин** "хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан" хэргээр [13 жилийн хорих ял](#) шийтгүүлсэн.

Хүнд ял шийтгэл

Мэргэжлийн бус сэтгүүлчид ч ял шийтгэлээс мултарсангүй. Блог хөтлөгч **Ву Ган** засгийн газрын авлигын талаар олон нийтэд мэдээлсэн хэргээр 2017 оны сүүлээр Тяньжиний шүүхээс (хойд Хятад) [найман жилийн хорих ял](#) сонссон. *Иргэний эрх ба амьжиргааны харуул* хүний эрхийн цахим хуудсыг үндэслэгч, ерөнхий редактор **Лю Фэйюэд** 2019 оны нэгдүгээр сард Суйжоу хотын (Хубэй муж) дунд шатны Ардын шүүхээс [таван жилийн хорих ял](#) оноосон.

[Гадаадын гурван сэтгүүлчийг](#) тагнуул хийсэн хэргээр цагдан хориод байгаа Хятадын эрх баригчдыг хилийн болоод үндэстний хамаарах асуудал ч хязгаарлаж чадахгүй болоод байна. Хятадын Глобал Телевиз (CGTN) төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн группт ажилладаг Австралийн бизнесийн мэдээллийн хөтлөгч **Чэн Лэй** 2020 оны наймдугаар сараас хойш "гадаадад төрийн нууц задруулсан" хэргээр хоригдож байна. Энэ явдлаас нэг жилийн өмнө Австралийн улс төрийн тоймч **Ян Хэнжун** ижил төстэй хэргээр баривчилж, дур зоргоор хориод байна. Хонконгд хэвлэлийн газар байгуулсан Шведийн иргэн **Гуй Минхай** 2015 онд Тайландад хулгайлагдснаасаа хойш 2020 онд дээрхтэй ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн хэргээр 10 жилийн хорих ял шийтгүүлсэн.

Эрүүдэн шүүх, харгис хэрцгий, хүнлэг бус харьцаа

Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, үйл ажиллагаа нь ил тод бус гэдгээрээ зартай Хятадын шоронд бүхий л төрлийн хүчирхийлэл үйлдэгддэг бөгөөд хоригдож буй сэтгүүлчидтэй зүй бусаар харьцаж, эмнэлгийн тусламж үзүүлэхээс татгалздаг. 2013 онд баривчлагдахаасаа өмнө Түвдийн өөртөө засах орны аялал жуулчлалын хөтөч, мэдээллийн гол эх сурвалж байсан **Кунчок Жинпа** хоригдож байхдаа 2021 оны хоёрдугаар сарын 6-нд [харгис хэрцгий, хүнлэг бус харьцааны](#) улмаас 51 насандаа амиа алдсан юм. Тэрээр өөрийн төрсөн нутаг Дриру (Түвдийн зүүн хойд хэсэг) мужид болсон эсэргүүцлийн талаар гадаадын хэвлэлд мэдээлэл өгсний дараа "төрийн нууц задруулсан" хэргээр Лхас хотын шоронд 21 жилийн ял эдэлж байжээ.

2010 оны Нобелийн энхтайвны шагналтан, 2004 оны RSF-ийн Хэвлэлийн эрх чөлөөний шагналын эзэн **Лю Сяобо**, блог хөтлөгч **Ян Тонгян** нар хоригдож байхдаа 2017 онд эмчилгээгүй хорт хавдраар нас барсан юм. RSF-ийн тооцоолсноор, одоогоор Хятадад хоригдож буй наад зах нь 10 хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагчийг нэн даруй суллахгүй бол амь нас нь эрсдэх аюултай байна.



АНХААРЛЫН ТӨВД

Хоригдож буй арван хүнийг онцлох нь



Илхам Тохти - 51

Ажил мэргэжил: Uyghur Online мэдээллийн сайтыг үндэслэгч.

Хоригдож буй газар: Өрөмч (Шинжааны өөртөө засах орон).

Оноосон ял: “Салан тусгаарлах ажиллагаа явуулсан” хэргээр бүх насаар хорих (2014 оны 9 дүгээр сар).

Учир шалтгаан: Засгийн газрыг шүүмжилсэн.

Эрүүл мэндийн байдал: Зүрх, уушги муудсан, жин алдсан; 2018 оны сүүлээс хойш ямар нэг мэдээлэл байхгүй.



Гулмира Имин - 43

Ажил мэргэжил: Salkin мэдээний сайтыг админ асан.

Хоригдож буй газар: Өрөмч (Шинжааны өөртөө засах орон).

Оноосон ял: Анхандаа “салан тусгаарлах ажиллагаа явуулсан”, мөн “гадаадад төрийн нууц задруулсан” хэргээр бүх насаар хорих ял авч байсан (2010 оны дөрөвдүгээр сар). 2017 онд түүний хорих ялыг 19 жил 8 сар болгон бууруулжээ.

Учир шалтгаан: Засгийн газрыг шүүмжилсэн.

Эрүүл мэндийн байдал: 2010 онд болсон шүүх хурлаас өмнө тэрээр эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцааны золиос болсон; 2010 оноос хойш ямар нэг мэдээлэл байхгүй.



Лю Жянхуа (Вэн Юү)- 60

Ажил мэргэжил: CCTV, Phoenix телевиз, Сингапурын Strait Times хэвлэл мэдээллийн хэрэгслийн улс төрийн тоймч

Хоригдож буй газар: Янчэн шорон, Янжяо (Хэбэй муж).

Оноосон ял: “төрийн нууц задруулсан” хэргээр 20 жилийн хорих ял (2006 оны 12 дугаар сар).

Учир шалтгаан: Хятад дахь эдийн засаг, улс төр, нийгмийн байдлын талаар бодол шүүмж хэлсэн.

Эрүүл мэндийн байдал: Хятадын хараат бус Пэн төв ТББ-ын тэмдэглэсэнчлэн, эрүүл мэндийн байдал нь доройтсон бөгөөд эрх баригчид түүнд эмнэлгийн тусламж үзүүлэхээс татгалзсан.



Жан Хайтао - 49

Ажил мэргэжил: Voxup, Чөлөөт Ази радио болон Америкийн дуу хоолой ХМХ-ийн улс төрийн тоймч

Хоригдож буй газар: Шаяа (Шинжааны өөртөө засах орон).

Оноосон ял: “хорлон сүйтгэх ажиллагаанд өдөөн хатгасан”, “гадаадад төрийн нууц задруулсан” хэргээр 19 жилийн хорих ял авсан (2016 оны нэгдүгээр сар).

Учир шалтгаан: Нийгмийн хэвлэл мэдээлэл, гадаадын хэвлэл мэдээлэл дэх ярилцлагуудад Бээжингийн эрх баригчдын гаргасан үйлдлийг шүүмжилсэн.

Эрүүл мэндийн байдал: Зодуулсан бөгөөд зургаан сарын турш хөлөнд нь хүнд гав зүүх арга хэмжээ авсан; хоол өгөхгүй өлсгөсөн; 2018 оны дөрөвдүгээр сараас хойш ямар нэг мэдээлэл байхгүй.



Чин Юнминь - 68

Ажил мэргэжил: Хятадын Хүний эрхийн манаач (Human Rights Watch) болон Rose China сонин бичгийн улс төрийн тоймч бөгөөд үүсгэн байгуулагч.

Хоригдож буй газар: Ухань (Хубэй муж).

Оноосон ял: “хорлон сүйтгэх ажиллагаанд өдөөн хатгасан” хэргээр 13 жилийн хорих ял авсан (2018 оны 7 дугаар сар).

Учир шалтгаан: хүний эрх, тэр дундаа хэвлэлийн эрх чөлөөг дээдэлсэн ардчилалд тайван замаар шилжих үзэл санааг гаргасан.

Эрүүл мэндийн байдал: 20-иод жилийн хугацаанд хоригдож, хөдөлмөрийн лагерьт өнгөрүүлэхдээ биеийн байдал асар доройтсон бөгөөд шүүх хурлын үеэр ухаан алдаж унасан. Улмаар 2019 онд эрүүл мэнд нь улам муудсан.



Хуан Чи - 58


Ажил мэргэжил: 64 Тяньван мэдээллийн цахим хуудсыг үндэслэгч

Хоригдож буй газар: Бажун (Сичуан муж).

Оноосон ял: “гадаадад төрийн нууц задруулсан” хэргээр 12 жилийн хорих ял авсан (2019 оны 7 дугаар сар).

Учир шалтгаан: Хятадын төрийн аппаратын хүчирхийлэлд өртсөн хохирогчдын дуу хоолойг хүргэсэн

Эрүүл мэндийн байдал: Найман жилийн турш шорон, хөдөлмөрийн лагерьт хоригдсоны улмаас элэг, зүрхний үйл ажиллагаа доройтсон; хүчирхийлэлд өртөж, гэмтэл авсан.



Иу Мантин (Яо Вэнтян) - 76

Ажил мэргэжил: Morning Bell Press хэвлэлийн газрыг үндэслэгч.

Хоригдож буй газар: Дунгуан (Гуандун муж).

Оноосон ял: “хууль бус бараа хил нэвтрүүлсэн” хэргээр 10 жилийн хорих ял шийтгүүлсэн (2014 оны тавдугаар сар).

Учир шалтгаан: Ши Жиньпин даргын талаар ном хэвлэхийг завдсан.

Эрүүл мэндийн байдал: Астма, зүрх, түрүү булчирхайн хорт хавдар, гепатит В; таван удаа цус харвасан ч эрүүл мэндээс шалтгаалан өршөөлд хамрагдах хүсэлтийг нь хүлээн аваагүй; 2017 оны 11 дүгээр сараас хойш ямар нэг мэдээлэл байхгүй.



Гуй Минхай (Майкл Гуй) - 57

Ажил мэргэжил: Causeway Bay номын дэлгүүр, Mighty Current хэвлэлийн газрын үндсэн хувь эзэмшигч.

Хоригдож буй газар: Нинбо (Жөжиэн муж).

Оноосон ял: “гадаадад төрийн нууц мэдээллийг хууль бусаар задруулсан” хэргээр 10 жилийн хорих ял авсан (2020 оны хоёрдугаар сар); 2015 оноос хойш хоригдож байна.

Учир шалтгаан: Ши Жиньпин даргын хувийн амьдралын талаар ном хэвлэхийг санаархсан.

Эрүүл мэндийн байдал: төв мэдрэлийн тогтолцооны хүнд эмгэгийн шинж тэмдэг илэрсэн; Консулын хууль тогтоомжийг үл ойшоон түүнд ЭСЯ-ны эмчээс зөвлөгөө авахыг зөвшөөрөөгүй (1996 оноос хойш Шведийн иргэншилтэй болсон).



Ву Ган - 49

Ажил мэргэжил: Хүний эрх хамгаалагч, Твиттер хуудаст тоймч.

Хоригдож буй газар: Цинлю (Фужиэн муж).

Оноосон ял: “хорлон сүйтгэх ажиллагаанд өдөөн хатгасан” хэргээр найман жилийн хорих ял авсан (2017 оны 12 дугаар сар).

Учир шалтгаан: Коммунист намын албан тушаалтнууд холбогдсон авлигын талаар хошин өнгө аястай тайлбар хийсэн.

Эрүүл мэндийн байдал: эрүүдэн шүүх, нойргүй байлгах харгислалын хохирогч, шоронд байх хугацаандаа 15 кг жин хаясан; 2019 оны гуравдугаар сараас хойш ямар нэг мэдээлэл байхгүй.



Жян Изфэй - 53

Ажил мэргэжил: Voxup цахим мэдээллийн хуудасны зураач.

Хоригдож буй газар: Чунчин (Сичуан муж).

Оноосон ял: “хорлон сүйтгэх ажиллагаанд өдөөн хатгасан”, “хууль бусаар хил давсан” хэргээр зургаан жилийн хорих ял шийтгүүлсэн (2018 оны 7 дугаар сар).

Учир шалтгаан: Хятад дахь хүний эрхийн зөрчлийн талаар шог зураг зурсан.

Эрүүл мэндийн байдал: Эрүүдэн шүүсэн, эмнэлгийн тусламж үзүүлээгүйн улмаас нэг нүд нь хараагүй болсон.

Шинжааны хэвлэл мэдээлэл бүслэлтэд орсон нь

2016 оноос хойш Бээжингийн эрх баригчид "терроризмтой тэмцэх" нэрийдлээр баруун хойд Шинжааны өөртөө засах орны түрэг хэлтэн лалын шашинт хүн амын эсрэг, гол төлөв Уйгур угсаатныг чиглэсэн хүчирхийлэн хэлмэгдүүлэх ажиллагаа явуулахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд урьд хожид байгаагүйгээр саад хийх болов. Олон улсын хэвлэл мэдээллээр түгээсэн мэдээллийн дагуу наад зах нь нэг сая хүнийг хорих лагерьтай төстэй "мэргэжлийн сургалтын төвүүд"-д дур зоргоор хорьж байна.

2021 оны 6 дугаар сард Францын өдөр тутмын *l'Opinion* сонины сэтгүүлч дээрх нөхцөл байдлын талаар асуухад, Парист суугаа Хятадын Элчин сайд Лу Шай гэнэн хуурамч, дүр эсгэсэн хийрхэл хоёрын хооронд холбирч, [ийнхүү хариулав](#): "Хэрвээ үнэхээр "геноцид" болон хүний эрхийн асар олон зөрчил гарсан бол (...), яагаад хэн ч нийгмийн хэвлэл мэдээллээр илчлээгүй юм? Шинжаанд очдог гадаадын жуулчид, дипломатууд, сэтгүүлчид маш олон байдаг. Мэдээж, барууны сэтгүүлчид ч мөн байдаг. Тэд эерэг талыг нь харсан ч үйл явдлын сөрөг талыг нь ухан гаргаж, бичдэг."

Шинжаанд очих зөвшөөрөл авсан цөөн гадаадын сэтгүүлчдийг хараа хяналтад авч, тэднийг чөлөөтэй зорчих, ярилцлага хийхийг хориглож, мэдээ сурвалжилга нь Бээжингийн таалалд нийцээгүй тохиолдолд Хятадын нутаг дэвсгэрт нэвтрэх эрхгүй сэтгүүлчдийн хар жагсаалтад оруулдаг тухай Элчин сайд дурдахаа "мартжээ." 2018 оны 8 дугаар сард *Buzzfeed News*-ийн Хятад дахь товчооны дарга **Мега Ражагопалан** визээ сунгаагүй тул түүнийг [тус улсыг орхихыг шаардсан](#). Өмнөх жил нь тэрээр Шинжааныг "мөрдөн тагнах ажиллагааны талбар" болохыг тодотгосон тайлан мэдээ нийтэлж байсан.

Цагдан хяналтыг эсэргүүцэж зүрхэлсэн Хятадын сэтгүүлчид улам илүү эрсдэлтэй тулгардаг. Дэлхийн хэвлэлийн хоёр удаагийн шагналт гэрэл зургийн сэтгүүлч **Лу Гуан** 2018 онд Шинжааны нийслэл Өрөмч рүү орон нутгийн гэрэл зурагчидтай уулзахаар очсоны дараа [ор сураггүй алга болсон](#). Түүнийг тагнах ажиллагаа явуулж буй гэх мэдээлэл байна. Уйгурын сэтгүүлч, эрдэмтэн, Вацлав Хавелийн нэрэмжит Европын Зөвлөлийн шагнал болон Сахаровын нэрэмжит Европын парламентын шагнал хүртсэн **Илхам Тохти** 2014 оноос хойш "салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан" хэргээр [бүх насаар хорих ял](#) эдэлж байна. Salkin мэдээллийн сайтын админ асан **Гульмира Имин** 2009 оноос хойш мөн уг хэргээр бүх насаар хорих ял эдэлж байна. Хятадын влог хөтлөгч **Гуангуан** Уйгур дахь 20 хорих төвийг илрүүлсэн талаарх баримтат нэвтрүүлгийг YouTube суваг дээр байршуулсны дараа дарамтаас зайлсхийн, 2021 оны аравдугаар сард АНУ руу дүрвэсэн.

Шинжааны өөртөө засах оронд эрх чөлөөт сэтгүүлчдийн алхам бүрийг хянадаг

© Johannes Eisele / AFP



2016 онд албан ёсоор "терроризмтой тэмцэх" нэрийдлээр хэлмэгдүүлэх ажиллагаа эхэлснээс хойш эрх баригчид Уйгурын хэдэн зуун сэхээтэн, тэр дундаа олон сэтгүүлчийг [баривчилсан](#). 2019 оны 5 дугаар сард Уйгурын хүний эрхийн төсөл (UHRP) төрийн бус байгууллага тус бүс нутгийн 58-аас цөөнгүй сэтгүүлч, редактор, нийтлэлчийг эрх баригчид баривчлан саатуулсан болохыг [олж илрүүлсэн](#). 2021 оны арваннэгдүгээр сард RSF Хятадад хоригдож буй нийт 127 сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагчдын талаас илүү нь буюу 71 нь уйгур сэтгүүлчид байгааг тогтоосон.



ЯРИЛЦЛАГА

“Эрх баригчид Хятадад буй ойр дотны хүмүүсийг маань дарамталж байна”

АНУ-ын Конгрессийн санхүүжилттэй хувийн хэвшлийн ХМХ болох "Чөлөөт Ази" радиогийн (RFA) Уйгурын асуудал хариуцсан сэтгүүлч Гулчера Хожа Шинжааны өөртөө засах орны талаар нийтэлж нэвтрүүлсэн сэтгүүлчдэд учрах дарамтын талаар ярилаа. Тэрээр 2019 онд Магнитскийн нэрэмжит Хүний эрхийн шагнал, 2020 онд Олон улсын эмэгтэйчүүдийн хэвлэл мэдээллийн сангийн Сэтгүүл зүйн салбар дахь эр зоригийн шагнал хүртсэн юм.

Шинжааны өөртөө засах оронд хэвлэл мэдээллийн нөхцөл байдал ямар байна вэ?

“Сүүлийн жилүүдэд Шинжааны талаар нийтэлж, нэвтрүүлэхийг хязгаарласан нь тус бүс нутагт мэдээлэл тасрахад хүргэсэн. Улмаар хараат бус мэдээ мэдээллийг гол төлөв Хятадын гадна үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд түгээж байна. Би хамтран зүтгэгчтэйгээ энэ бүс нутагт төрж өссөний хувьд, нутгийн хэлээр ярьдаг тул эрх баригчдын суртал ухуулгын эсрэг тэмцэж, тус бүс нутгийн бодит байдлын талаар дэлхий нийтэд мэдээлэл өгч чадна. Хараат бусаар мэдээлж, нийтэлдэг тул Хятадын засгийн газар биднийг өөрсдийн бодлогод нь аюул учруулж байна гэж үзэж буй. Тийм ч учраас тэд бидний дуу хоолойг боомилохыг хүсэж байна” гэв.

Танд ямар төрлийн дайралт ирдэг вэ?

“Эрх баригчид бидэнд шууд халдаж чадахгүй болохоороо Хятадад оршин сууж байгаа төрөл төрөгсдийг маань дарамталж байна. Намайг 2001 онд АНУ-д нүүж ирснээс хойш манай гэр бүлийнхнийг Хятадын засгийн газар онилж, байнга дарамтлан, байцааж байсан.

2017 оны 9 дүгээр сард төрөл төрөгсөд маань WeChat-д харилцахаа гэнэт больсон. Хятадын засгийн газар миний ахыг эрхэлж буй ажлаас минь болж баривчилсан гэж сонссон. 2018 оны хоёрдугаар сарын 3-нд миний эцэг эх болон бусад 24 ах дүү, хамаатан саданг баривчилсан. Одоогоор миний мэдэж байгаачлан, Уйгурын асуудлаарх манай тасгийн бүх ажилтнуудыг дарамтлахын тулд тэдний гэр бүлийн аль нэг гишүүнийг хорих лагерь эсвэл шоронд хорьсон.”

Ийм дарамт шахалт таны ажилд нөлөөлж байна уу?

“Бид Уйгурын бүс нутагт оршин суугаа дуу хоолойгоо хүргэх боломжгүй олон сая уйгурчууд, бусад лалын шашинт цөөнхийн дуу хоолой болж буй учраас дуугүй болохгүй. Бид амин чухал мэдээлэл нийтэлдэг. Энэ нь өдгөө тус бүс нутагт үйлдэгдэж буй соёлын геноцидтой тэмцэхэд нэмэр болно.”

© D.A. Peterson / U.S. State Department

Гадаадын сурвалжлагчид хүсээгүй гэрч болсон нь

Хятадын Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч Жао Лицянь 2021 оны 7 дугаар сарын 29-нд хийсэн хэвлэлийн бага хурал дээр BBC-г (Британийн өргөн нэвтрүүлгийн корпорац) "Сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйгээс ноцтой хазайж, Хятадыг довтлон доромжилдог", гадаадын сэтгүүлчдийн эсрэг чиглэсэн тус дэглэмийн галзуурлыг харуулсан "худал мэдээ" бэлтгэдэг "хов жив хөөцөлдсөн өргөн нэвтрүүлгийн корпорац" гэжээ. Энэ хэлсэн үгээрээ тэрээр тухайн сард Хятадын төв хэсэгт (Хенан муж) болсон үерийн гамшгийн талаар мэдээлсэн BBC, Los Angeles Times, Deutsche Welle-ийн гадаадын сурвалжлагчдын бие махбодид халдаж, цахимаар сүрдүүлэн заналхийлсэн хэргийг "зөвтгөх"-ийг санаархсан. Эдгээр халдлагыг Хятадын Коммунист залуучуудын холбоо үйлдсэн гэдгийг онцлох нь зүйтэй.

2021 оны хоёрдугаар сарын 4-нд Хятадад нэвтрүүлэг явуулах зөвшөөрлөө албан ёсоор [цуцлуулсан](#) Британийн олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын эсрэг эрх баригчид анх удаа халдаж байгаа хэрэг биш юм. Дараа сард нь BBC-ийн Хятад дахь сурвалжлагчаар есөн жил ажилласан **Жон Судворт** Шинжааны өөртөө засах орны лалын шашинт Уйгурын хүн амыг дарангуйлж буйг мэдээлсэнд дургүйцсэн эрх баригчдын удаа дараагийн сүрдүүлэг заналхийллээс үүдэн тус улсыг орхин гарахад хүрсэн. Тус улсад 200 сая хяналтын камер суурилуулах төсөл бүхий үй олноор мөрдөн тагнах Skype системийн талаар нийтлэл бичсэнийх нь дараа Судвортыг 2017 онд Хятадын албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэл *Global Times* "улс төрийн өрөөсгөл хандлагатай, сэтгэцийн эмгэгтэй" хэмээн буруутгасан.

"Алтан үе"-ийн төгсгөл

Хятад дахь гадаадын сурвалжлагчдаас, ялангуяа улс төр буюу хүний эрхийн асуудлыг хөнддөг бол асар их хүчин чармайлт шаардана. 1990, 2000-аад онуудад тэд болон тэдний Хятадын хамтран зүтгэгчид эрэн сурвалжилга хийхэд тодорхой эрх чөлөө эдэлж байсан бөгөөд ажилдаа шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг албан ёсоор, мөн бусад байдлаар олж авах боломжтой байсан үе бий. Эрх баригчдын хувьд энэ нь сайн муу хоёр талтай байв. Гадаадын сурвалжлагчдын нийтлэлүүд зарим тохиолдолд таагүй агуулгатай байсан ч дэлхий нийтэд Хятадын эдийн засаг, нийгмийн хөгжлийг мэдээлснээр хөрөнгө оруулагчдыг татахад үнэтэй хувь нэмэр оруулж байсан.

Ковид-19 цар тахлын улмаас гадаадын сурвалжлагчдын эсрэг дарамт шахалт улам бүр эрчимжсэн.

© Thomas Peter / Reuters



Хорин жилийн дараа байдал эрс өөрчлөгдөж, Хятад дахь гадаадын сэтгүүлчдийн энэхүү "алтан үе" улиран одсон. Хараат бус сэтгүүл зүйтэй дайн зарлаж, дэлхийд хамгийн хүчирхэг суртал ухуулгын машинаар өөрсдийгөө тоногдосон Хятадын эрх баригчид гадаадын сурвалжлагчдыг дуугүй болгохын тулд хүсээгүй гэрч болгов. **Хятад дахь Гадаадын сурвалжлагчдын клуб (FCCC)** 2021 оны 3 дугаар сарын 1-нд нийтэлсэн жилийн [тайландаа](#) Ковид-19-ийн эрүүл мэндийн хямралын зэрэгцээ дарамт шахалт эрчимжиж буйг зэмлэн буруушаав. Тус дэглэм нь мөрдөн тагнах, визний зөвшөөрлийг урвуулан ашиглах ажиллагаан дээр үндэслэн гадаадын сурвалжлагчдыг айлган сүрдүүлэх бодит тогтолцоог бүрдүүлсэн. 2020 онд 18-аас доошгүй гадаадын сурвалжлагчийг тус улсаас албадан гаргасан.



© BBC

Эх сурвалжийг дарамтлах нь

Дарамт шахалт дан ганц сэтгүүлчдийг бус мөн тэдний хамтран ажиллагсад, эх сурвалжийг нь чиглэн дайрдаг. 2020 оны арванхоёрдугаар сарын 7-нд Бээжингийн Үндэсний аюулгүй байдлын товчоо өмнө нь CNBC, CBS News, Al Jazeera, Thomson Reuters зэрэг олон улсын мэдээллийн агентлагт ажиллаж байсан Хятадын үндэсний болон Bloomberg агентлагийн мэдээний туслах ажилтан **Хазе Фаныг** "үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн" хэргээр [баривчилсан](#). Тэрээр гадаад ертөнцтэй ямар ч холбоогүй хоригдож буй бөгөөд шүүх хурал нь товлогдоогүй байна. Сэтгүүлчдэд зайлшгүй шаардлагатай мэдээллийн эх сурвалж улам бүр хомсдож, залхаан цээрлүүлэлтээс болгоомжлох үүднээс нэрээ нууцлахыг хүсдэггүй тохиолдол гэж байхгүй болов. Хятад дахь ардчиллыг дэмжих хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, их сургуулиас тэтгэвэрт гарсан профессор, 84 настай **Сун Вэнгуан** 2018 онд Америкийн дуу хоолой радиод (VOA) утсаар шууд ярилцлага өгч байх үеэр Жинань (Шаньдун муж) дахь [гэрээсээ баривчлагдсан](#).

Барьцаалагдах эрсдэл

Гадаадын сурвалжлагчдын харьяалагддаг улс, Хятад улсын хооронд улс төрийн асуудалтай бол барьцаалагдах эрсдэлтэй тэдэнд Хятадаас хөөгдөх нь санаа зовоосон асуудал байхаа больсон. Одоогоор Хятадад тагнуул хийсэн хэргээр хятад гаралтай гадаадын гурван сэтгүүлч хоригдож байна. Хонконгийн хэвлэлийн газрыг үндэслэгч, Шведийн нийтлэлч **Гүй Минхай** 2020 онд арван жилийн хорих ял шийтгүүлсэн бол Австралийн сэтгүүлч **Ян Хэнжун, Чэн Лэй** нар 2019, 2020 онуудад тус тус баривчлагдаж, одоо хүртэл шүүх хуралгүйгээр цагдан хоригдож байна.

2020 оны 9 дүгээр сарын 3-нд Австралийн сурвалжлагч **Билл Бэртлс** (ABC News) болон **Майкл Смит** (*The Australian Financial Review*) нар Чен Лэйгийн хэргийг эрэн сурвалжилсныхаа дараа баривчлагдахаас зугатаж, Австралийн элчин сайдын яамнаас орогнол хүссэн. Хоёр сэтгүүлч цагдаад байцаагдсаны дараа есдүгээр сарын 7-нд тус улсаас гарч чадсан.

Хятадын эрх баригчдын зүгээс гадаадын сурвалжлагчдад үзүүлж буй хүчтэй дарамт шахалтын нөлөөгөөр тэдний бэлтгэдэг мэдээ мэдээллийн тоо хэмжээ, чанар чансаа буурахын зэрэгцээ Хятадад өрнөж буй үйл явдлын мэдээ сурвалжилга, мэдлэг ойлголт хязгаарлагдмал болж байна. Мөн оны хоёрдугаар сард албадан гарсан *Wall Street Journal*-ийн Хятад дахь товчооны дэд дарга асан **Жош Чин** 2020 оны 8 дугаар сард англи хэл дээр гардаг ChinaFile цахим сэтгүүлд бичсэн нийтлэлдээ "үйл явдлыг олон талаас харуулсан, амьд, үнэн бодит өгүүлэмж бичихэд улам хэцүү болсон" хэмээн халагласан.



2

ОГЦОМ УНАЛТАД ОРСОН ХОНКОНГИЙН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

- Бээжингээс 2020 онд баталсан Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар шалтаглан Хонконгийн засгийн газар наад зах нь 12 сэтгүүлч, хүний эрх хамгаалагчийг яллагдагчаар татсаны арвыг нь цагдан хорьж, тус бүс нутгийн Хятад хэл дээр гардаг сөрөг хүчний хамгийн томд тооцогдох Apple Daily сонины үйл ажиллагааг зогсоосон.
- Бээжингийн эрх баригчдын таалалд нийцэхийн тулд Хонконгийн захирагч Кэрри Лам хэвлэлийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг болсон олон нийтийн медиа групп RTHK (Хонконгийн радио телевиз)-ийг хараа хяналтдаа онилж, сэтгүүлчдийн эсрэг хүчирхийллийг нүд анин өнгөрүүлж байна.

© Isaac Lawrence / AFP

Хараат бус хэвлэл мэдээллийн эсрэг дарангуйлал

“Үндэсний аюулгүй байдал” бүхнээс дээгүүр

Хонконг БНХАУ-ын мэдэлд шилжсэнээс хойш 25 жил өнгөрч байгаа ч тус бүс нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй Суурь хуулиар 2047 он хүртэл баталгаажуулсан хэвлэлийн эрх чөлөөний зарчимд урьд өмнө байгаагүй ихээр аюул занал учраад байна. Хонконг 2002 онд RSF-ийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс анх гарч байхад 18 дугаар байранд жагсаж байсан бол нэг үеийн хугацаанд буюу 2020 онд 80 дугаар байр хүртэл ухарчээ.

Энэ хугацаанд Бээжин Хонконгийн Хятад хэлээр эрхлэн гаргадаг хэвлэл мэдээллийг хэсэг хэсгээр [ажмаар хяналтдаа авч](#), зар сурталчилгаа захиалагчдаараа дамжуулан бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шахалт үзүүлэхүйц шууд бус тогтолцоог бий болгосон. 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Хятадын хууль тогтоох дээд байгууллага болох Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооноос “Хонконгийн засаг захиргааны онцгой бүсэд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай БНХАУ-ын хууль”-ийг баталснаар байдал улам дордсон.

Уг хуулийн бичвэр ойлгомжгүй, зориуд буруу илэрхийлсэн нь “террорист үйл ажиллагаа”, “салан тусгаарлах”, “хорлон сүйтгэх”, “гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах” гэмт хэрэгт бүх насаар хорих ял оноох, хууль ёсны нэрийн дор дур мэдэн баривчлах, шийтгэл оногдуулах үүд хаалга нээгдсэн. Хонконгийн Их сургуулийн Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн судалгааны төвийн захирал **Кейт Ричбург** 2021 оны 5 дугаар сард АНУ-д байрлах CNBC телевизэд өгсөн ярилцлагадаа, уг хууль нь Хонконгд хэвлэлийн эрх чөлөөг удаан боловч гарцаагүй мөхөлд хүргэнэ гээд, энэ үйл явцыг эртний Хятадын “мянган удаа зүсэж алах” эрүү шүүлттэй зүйрлэв.

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлагдсанаас хойш 12 сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч төрийн эсрэг “гэмт хэрэг үйлдсэн” хэргээр ял шийтгүүлээд байна.

© Anthony Wallace / AFP



Бүх насаар хорих ялтай "гэмт хэрэг"

Хятад хэл дээрх эх хувилбар, англи орчуулга адилхан салаа утгатай уг хууль батлагдсан даруйдаа хүчин төгөлдөр болсон бөгөөд Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн талаар мэдээлж сурвалжлах нийт сэтгүүлчдэд тэдний хаана байгаагаас үл хамааран үйлчилнэ (Зүйл 38).

Хонконгд болсон шүүх хурлын тухайд сэтгүүлчид бүх насаараа хоригдох ялтай ижил хэмжээний хүнд хор уршигтай нүүр тулдаг бөгөөд хуульд гэмт хэрэгтнийг "шилжүүлэх" гэсэн нэр томъёог огт дурдаагүй. Гэсэн хэдий ч шүүх хурлыг үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт цаазаар авах ял оноох заалттай БНХАУ-д явуулах нөхцөл бүрдүүлсэн (Зүйл 55). Тус хууль мөн зарим шүүх хурлыг хэвлэл мэдээлэл, олон нийтийн хараанаас ангид явуулах эрх олгосон (Зүйл 41).

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Бээжингийн эрх баригчид Хонконгд Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах алба (Зүйл 48) байгуулж, хэвлэл мэдээлэл, гадаадын сурвалжлагчдын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хүлээлгэсэн (54-р зүйл). Мөн орон нутгийн шүүх эрх мэдлээс ангид үйл ажиллагаа явуулах (Зүйл 14) Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хороог (Зүйл 12) байгуулсан нь сэтгүүлчид болон тэдний эх сурвалжийг айлган сүрдүүлэх, мөрдөн тагнах ажиллагааг чөлөөтэй явуулах нөхцөл бүрдүүлсэн.

Удаа дараа хойшилсон төсөл

1990-ээд онд Хонконг Хятадын тухай мэдээллийн гол гарц болж байх үед эх газарт эрэн сурвалжилга хийж байсан сэтгүүлчид “төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн” хэрэгт буруутгагдах эрсдэлтэй байв. 1994 онд өдөр тутмын *Ming Pao* сонины сурвалжлагч **Ши Ян** Хятадын Төв банкны хөрөнгийн зах зээлийн стратегийг задруулсны дараа “улсын санхүүгийн нууц баримт хулгайлсан” хэргээр 12 жилийн хорих ял авсан. Энэ хэргийн дараа Хонконгийн сэтгүүлчид хэд хэдэн удаагийн жагсаал цуглаан зохион байгуулсан.

2002 онд Их Британи газар нутгийг Хятадад эргүүлэн өгснөөс тавхан жилийн дараа Бээжингийн шахалтаар Хонконгийн гүйцэтгэх засаглал төрийн эсрэг гэмт хэрэгт бүх насаар хорих ял оногдуулах шийтгэлтэй Үндэсний аюулгүй байдлын тухай хууль батлах саналыг Хууль тогтоох зөвлөлд [анх удаа](#) өргөн барьсан. Ийм төрлийн зохицуулалт нь улс төр, шашин шүтэх, хэвлэлийн эрх чөлөөнд шууд заналхийлж буйд түгшсэн хагас сая Хонконгчууд гудамжинд гарч, эсэргүүцлийн жагсаал зохион байгуулсны дараа хуулийн төслийг тэр даруй эргүүлэн татсан.

2014 онд Хонконгчууд [дахин гудамжинд гарч](#) илүү их ардчиллыг нэхэж, ялангуяа Хууль тогтоох зөвлөлийг бүх нийтийн санал хураалтаар сонгохыг шаардсан. Энэ нь цагдаа нар жагсагчдыг хүч хэрэглэн тараахаас өмнөх 79 хоногийн турш төв бизнес дүүргийг тайван замаар эзэлсэн “Шүхэр хөдөлгөөн” байсан юм. Хэзээ нэгэн цагт тус газар нутгийг хяналтаасаа алдахаас эмээсэн Бээжингийн эрх баригчид Хонконгийн гүйцэтгэх засаглалтай хамтран хэтийн аюулгүй байдлыг зохицуулах хуулийн төсөл дээр ажиллаж эхэлсэн.

Замаасаа зайлуулсан нь

2019 оны эхээр шинээр томилогдсон захирагч Кэрри Лам “2019 оны Эрүүгийн хэргийн хууль тогтоомж дахь (Нэмэлт өөрчлөлт) оргодол гэмт хэрэгтний асуудал ба эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” буюу [“ялтан шилжүүлэх”](#) гэдэг нэрээр танигдсан шинэ хуулийн төслийг таниулан сурталчлах аян эхлүүлсэн. Тус хуулийн төсөлд Хонконгд үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдогч оршин суугч, аялагчдыг эх газрын Хятадад шилжүүлэн өгөхөөр заасан. Уг хуулийн төсөл онолын хувьд улс төр, эдийн засгийн гэмт хэрэг, хүний эрхийг зөрчиж болзошгүй хэргийг оруулаагүй боловч Хонконгчууд өөрсдийн төлөөллийг Бээжингийн шаардлагыг эсэргүүцэх, ялангуяа идэвхтэн, сэтгүүлчидтэй холбоотой хэргийн хувьд сөрж чадахгүй байх вий хэмээн болгоомжилж байна.

Хонконгчууд хавар дахин гудамжинд гарч жагсав. Зургаадугаар сарын 9-нд тэд нэг саяулаа байсан бол мөн сарын 16-ны өдөр гэхэд 1.5 саяас 2 сая болтлоо нэмэгдсэн нь ажил хөдөлмөр эрхэлдэг хоёр хүн тутмын нэг болж байв. Энэ нь 7.5 сая хүн амтай нутаг дэвсгэрт урьд өмнө байгаагүй өндөр үзүүлэлт юм. Хонконгийн гүйцэтгэх засаглал хуулийн төслийг татахаас аргагүй болов. Нэр хүнд унагаасан энэ хэрэг Бээжингийн эрх баригчдын тэсвэр тэвчээрийг барав. Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эрүүл мэндийн хямрал ид дундаа явагдаж байх үед Бээжин засаг захиргааны онцгой бүс нутагт зориулан өөртөө засах эрхийг нь зөрчихүйц [Үндэсний аюулгүй байдлын тухай хууль](#) баталсан.

АНХААРЛЫН ТӨВД

Улс орны эсрэг дөрвөн төрлийн гэмт хэрэг

The four "crimes against the state" provided by the National Security Law are worded so vaguely that all possible interpretations can be used to silence journalists.

“Үндэсний аюулгүй байдалд заналхийлж, гадаадын улс орон буюу гадны хүчнүүдтэй үгсэн хуйвалдах”

- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих ял.
- **Тодорхойлолт:** "Төрийн нууц задруулах буюу тагнан турших" замаар "дайсагнасан үйл ажиллагаа" явуулах, Хятадын эсрэг "үзэн ядалт"-ыг өдөөх; "гадаад улс буюу байгууллагатай үгсэн хуйвалдах"; гадаад улс буюу байгууллагын "зааварчилгааг шууд болон шууд бусаар авах".
- **Хятад дахь урьдач нөхцөл:** Гадаадын хэвлэл мэдээлэл бол өөрийн байрлаж буй улсын эрх ашгийг хамгаалахын тулд ажилладаг засгийн газрын агент гэсэн суртал ухуулгыг Бээжин байнга явуулдаг. 2020 онд гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байсан дор хаяж 18 сэтгүүлчийг Хятадаас [албадан гаргасан](#). 2021 онд Хятадын эрх баригчид тагнуул хийсэн хэргээр гадаадын гурван сэтгүүлчийг [баривчлан саатуулсан](#).
- **Хонконг дахь хэрэгжилт:** 2020 онд *Apple Daily* сониныг үндэслэгч **Жимми Лай** тухайн хэрэгт буруутгагдаж байсан. 2021 онд *Apple Daily*-д ажилладаг зургаан хүн, түүн дотроо сэтгүүлчид "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах"-д [Лай-тай үгсэн тохирсон хэргээр ял шийтгүүлсэн](#). 2020 оны нэгдүгээр сард Хонконгийн захирагч Кэрри Лам гадаадын хэвлэл мэдээлэл, тэр бүү хэл гадаадын оршин суугчдын үүсгэн байгуулсан Хонконгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг барууны засгийн газруудын төлөөлөл байх магадлалтай хэмээв.

“Хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах”

- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих ял.
- **Тодорхойлолт:** Хятадын “үндсэн тогтолцоог” “нураах буюу дордуулах”, эсвэл Хятадын төв эрх мэдэл буюу Хонконг дахь эрх мэдлийн байгууллагын үүргээ гүйцэтгэхэд ноцтойгоор “хөндлөнгөөс оролцох, тасалдуулах, дордуулах”.
- **Хятад дахь урьдач нөхцөл:** Хамгийн багадаа 13 сэтгүүлч “хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан”, “хорлон сүйтгэх үйл ажиллагаанд өдөөн турхирсан” хэргээр хоригдож байна.
- **Хонконг дахь хэрэгжилт:** Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч **Клаудиа Мо, Гвинет Хо Квай-лам** нар тус нутаг дэвсгэрт ардчилал, хэвлэлийн эрх чөлөөг дэмжсэн хэргээр 2021 онд [баривчлагдан саатуулагдсан](#). Тусгаар тогтнолыг дэмжсэн үйл явдлын талаар мэдээлсэн, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийг эш татсан сэтгүүлчид, мөн Хятадын дэглэмийн талаар шүүмж буюу эрэн сурвалжлах нийтлэл бичсэн сэтгүүлчдийг энэ хэрэгт буруутгадаг.



Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан “төрийн эсрэг гэмт хэрэг” гэсэн дөрвөн зүйл бүхий маш бүрхэг бичвэртэй хуулийн бүх тайлбараар сэтгүүлчдийг дуугүй болгох боломжтой.

© Paul Yeung

“Салан тусгаарлах үйл ажиллагаа явуулах”

- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих ял.
- **Тодорхойлолт:** “Үндэсний эв нэгдлийг бусниулан доройтуулах”, “Хонконгийг Хятадаас салан тусгаарлах”.
- **Хятад дахь урьдач нөхцөл:** Эх газарт Эх газрын хувьд, тухайн гэмт хэргийг "салан тусгаарлах үйл ажиллагаа явуулах" хэрэгтэй гол төлөв хавсруулан, бүс нутгийн хэл, соёлыг сурталчилсан Уйгур, Түвд зэрэг аливаа хувь хүн, бүлэг хүмүүст хамаатуулдаг. Сэтгүүлч, академич **Илхам Тохти** 2014 онд "салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан" хэргээр [бүх насаар хорих ял](#) сонссон.
- **Хонконг дахь хэрэгжилт:** Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу Хонконгийн соёлын онцлог, тусгаар тогтнолыг дэмжигч хөдөлгөөний талаар бичсэн аливаа сэтгүүлчийг “салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан” хэргээр буруутгадаг. *Financial Times* сонины Азийн мэдээний редактор **Виктор Маллег** 2018 онд тусгаар тогтнолын төлөө тэмцэгчийг оролцуулсан Гадаадын сурвалжлагчдын клуб (FCC)-ээс зохион байгуулсан мэтгэлцээнийг хөтлөн явуулсан хэргээр Хонконгоос [албадан гаргасан](#). Хэрэв тэр үед аюулгүй байдлын тухай хууль мөрдөгдөж байсан бол Маллег "салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан" хэргээр буруутгах байв.

“Террорист үйл ажиллагаа явуулах”

- **Ялын дээд хэмжээ:** Бүх насаар хорих ял.
- **Тодорхойлолт:** “нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэх үйл ажиллагаа” явуулснаар “нийгэмд ноцтой хор уршиг учруулсан, учруулахаар завдсан”.
- **Хятад дахь урьдач нөхцөл:** Бээжингээс Шинжааны өөртөө засах орны Уйгур угсаатны эсрэг явуулж буй ажиллагааны хүрээнд одоогоор наад зах нь 71 сэтгүүлчийг терроризмтой холбоотой хэргээр баривчлан саатуулж байна. Шинжааны боловсролын хэвлэлийн газрын ахлах редактор асан **Вахитжан Осман** "салан тусгаарлах болон терроризмын үзэл санаа"-г сурталчилсан хэргээр 2016 оноос хойш хоригдож байна.
- **Хонконг дахь хэрэгжилт:** Хятадын болон Хонконгийн удирдагчид ардчиллын төлөөх хөдөлгөөнийг "терроризм" гэж үзэх нь түгээмэл тул жагсаал цуглаан болж буй газраас мэдээ сурвалжилга бэлтгэх нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу террорист үйл ажиллагаа явуулсан хэргээр ял авах эрсдэлтэй. Хятадад мөн эдгээр хөдөлгөөний талаар мэдээлсэн гадаадын сэтгүүлчдийг "терроризмыг дэмжсэн" хэргээр баривчлах буюу албадан гаргах заалттай.

АД ҮЗЭГДСЭН СЭТГҮҮЛЧИД



© Anthony Wallace / AFP

Хонконг Хотын Их Сургуулийн оюутны сэтгүүлд дэд ерөнхий редактор ажилтай **Вон Ка-хо**, Passion Times цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд сурвалжлагч хийдэг **Ма Кай-чун** нар долоон жилийн хорих ялтай гэмт хэрэг болох "[үймээн самуун дэгдээсэн](#)" хэргээр 2023 оны 5 дугаар сарын 29-нд эрүүгийн хэргийн шүүхээр шүүгдэнэ. Хоёр сэтгүүлч 2019 оны долдугаар сарын 1-нд ялтан шилжүүлэх хуулийн төслийг эсэргүүцсэн жагсаал цуглааны хажуугаар 500,000 гаруй хүн Хонконгийн Хууль тогтоох зөвлөлийн байранд халдаж буйг сурвалжилж байхдаа баривчлагдсан. Эдгээр сэтгүүлчийг ажлаа хийснийх нь төлөө шүүхэд дуудсан нь Хонконгийн хэвлэлийн эрх чөлөө сүүлийн үед доройтож буйг улам тод илтгэн харуулж байна. Хамгийн сүүлд Хонконгийн 12 сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэгч төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр мөрдөн шалгагдаж байгаагаас 10 нь цагдан хоригдож, үлдсэн 4 нь үндэсний аюулгүй байдлын эсрэг хэргээс бусад төрлийн гэмт хэргээр баривчлах ял шийтгүүлээд байна.

Чөлөөт сурвалжлагч, Нэгдсэн Вант Улсын ITV телевизийн идэвхтэн **Вилсон Ли Чун-чак** Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу шийтгүүлсэн Хонконгийн анхны сэтгүүлч бөгөөд хууль батлагдсанаас хойш ердөө нэг сарын дараа цагдан хоригдсон. Батлан даалтад гарсан түүнийг "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" хэргээр одоо хүртэл мөрдөн шалгаж байна. Засгийн газраас үйл ажиллагааг нь зогсоосон Apple Daily өдөр тутмын сониныг үндэслэгч **Жимми Лай** батлан даалтад гарах боломжгүй байсан бөгөөд өнөөг хүртэл "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах явуулга хийсэн" хэргээр цагдан хоригдож байна. Мөн тус [группд ажиллаж байсан зургаан хүнд](#) цагдан хорих арга хэмжээ аваад байна. Эдгээрийн дотор ерөнхий менежер **Чеюн Ким-хун**, гүйцэтгэх ерөнхий редактор **Лам Ман-чун**, туслах нийтлэлч **Чан Пуй-ман**, ерөнхий редактор **Райан Лау Вай-квон**, редакцийн зохиолч **Фун Вай-кон**, **Юн Чин-Ки** (Ло Фун, Ли Пин нууц нэрээр тус тус алдаршсан) нар байна.



Сурвалжлагчид мэргэжлийн ажлаа хийсний төлөө шүүхэд дуудагдах эрсдэлтэй боллоо.

© Stand News

Үндэсний аюулгүй байдлын хуулийн хохирогч болсон хүмүүсийн дунд Хонконгийн нэртэй хоёр хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч бий. Тэднийг "хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулахаар хуйвалдсан" хэргээр [баривчлан саатуулсан](#). Тэд бол хууль тогтоогч, мөн сэтгүүлч асан **Клаудиа Мо** болон 2019 оны 7 дугаар сарын 21-нд Юэн Лон метроны буудал дээр ардчиллын төлөө жагсагчид, сэтгүүлчид болон зорчигчдын эсрэг Бээжинг дэмжигч зохион байгуулалттай "triad" бүлэглэлийн дайралтыг шууд дамжуулж байсан Stand News сонины сурвалжлагч асан **Гвинет Хо Квай-лам** нар юм.

Үүнтэй зэрэгцэн Хонконгийн засгийн газар "Giggs" хэмээх нууц нэрээр алдаршсан радиогийн хөтөлгөч **Ван Иу-Синг** яллахын тулд Британийн колончлолын үед үйлчилж байсан, 1970-аад оноос хойш хэрэглээгүй үймээн самуун дэгдээх тухай зүйл заалтыг сэргээсэн. 2020 оны арваннэгдүгээр сараас хойш цагдан хоригдож байгаа уг сэтгүүлчийг батлан даалтад гаргахаас хоёр ч удаа татгалзсан бөгөөд түүнд 14 жилийн хорих ял оногдуулсан юм.

1968 онд үүсгэн байгуулагдсан, нэр хүнд сайтай Хонконгийн Сэтгүүлчдийн холбоо (HKJA) хүртэл мөрдөн шалгагдаж буй сэтгүүлчдэд дэмжлэг үзүүлэхээр "зориглосон" хэргээр засгийн газрын шахалтад өртөөд байна. 2021 оны есдүгээр сард Хонконгийн Аюулгүй байдлын нарийн бичгийн дарга, цагдаагийн дарга асан Крис Танг тус холбоог "сургуулиудад нэвтэрч", "оюутан сэтгүүлчдийг гишүүн болгохоор уруу татсан" хэргээр буруутгасан.



Хууль тогтоогч, мөн сэтгүүлч асан Клаудиа Мо ардчилал, хэвлэлийн эрх чөлөөг дэмжсэний төлөө бүх насаараа хоригдох ял авах эрсдэлд өртөв.

© Peter Parks / AFP

АНХААРЛЫН ТӨВД

RSF-ийн шагналын эзэн Жимми Лай бүх насаар хоригдох эрсдэлтэй тулгарав

Apple Daily сониныг үндэслэгч, 2020 оны RSF-ийн Хэвлэлийн эрх чөлөөний шагналт Жимми Лай сүүлийн 30 жилийн турш Хонконг дахь хэвлэлийн эрх чөлөө, ардчиллын төлөө ил тодоор тэмцэж ирсэн. 2020 оны 12 дугаар сараас хойш цагдан хоригдож байгаа тэрээр Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн хэвлэл мэдээлэлд холбогдох анхны бай болсон бөгөөд бүх насаар хорих ял сонсох магадлалтай байна.

73 настай Жимми Лай 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр шоронгоос бичсэн захидалдаа "Шударга ёсыг эрэлхийлэх нь сэтгүүлч бидний хүлээсэн үүрэг юм" гэжээ. Хонконгийн засгийн газраас хаасан түүний үүсгэн байгуулсан Apple Daily сонинд дахин халдахыг үгүйсгэхгүй байгаа тэрээр ажилтнууддаа хандан "шантрахгүй байх"-ыг уриалав.

2020 оны RSF-ийн Хэвлэлийн эрх чөлөөний шагналт Жимми Лай Хонконг дахь хэвлэлийн эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгч юм. Тэрээр Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар шийтгүүлсэн анхны хүмүүсийн нэг бөгөөд уг хуулийн дагуу [бүх насаар хорих ял шийтгүүлэх](#) эрсдэлтэй байна. 2020 оны 12 дугаар сараас хойш хоригдож байгаа түүнд олон хэргээр ял тулгаж буй бөгөөд гурван удаа "зөвшөөрөлгүй" жагсаал цуглаан "зохион байгуулсан", "оролцсон" хэргээр 20 сарын хорих ял эдэлж байна.

Маоизмын үед Хятад улс түүхэндээ хамгийн аймшигтай өлсгөлөнд нэрвэгдэж байхад 12 настай байсан Лай Хонконгод дүрвэн ирсэн бөгөөд хувцасны дэлгүүрт ажиллаж байхдаа бие даан англи хэл сурсан. 1981 онд тэрээр Giordano хувцасны брэндийг үүсгэн байгуулсан нь түргэн хугацаанд олон улсад өргөжин тэлж, улмаар хөрөнгөжсөн. 1989 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Тяньаньмэний талбайд болсон хядлага түүнд ардчилал, хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэх хүсэл эрмэлзлэл төрүүлсэн. 1990 онд тэрээр долоо хоног тутмын Хятад хэлээр гардаг Next Magazine сэтгүүл, 1995 онд Apple Daily сониныг үүсгэн байгуулсан.

Жимми Лай болон түүний үүсгэн байгуулсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрх баригчдын байнгын дарамт шахалтад өртөж, хэд хэдэн гэмт хэргийн золиос болж байв. 2013 онд түүний орон байрыг автомашинаар дайрсан бөгөөд халдлага үйлдэгчид сануулга өгөх үүднээс сүх, хутга үлдээгээд явсан. 2015 онд багтай этгээдүүд түүний гэр болон сонины төв байр руу гар хийцийн тэсэлгээний хэрэгсэл шидсэн. 2019 онд ялтан шилжүүлэх хуулийн төслийг эсэргүүцсэн жагсаал цуглааны үеэр Лайд дахин халдаж, гэрийг нь шатаасан.

© Isaac Lawrence / AFP



"Аадар борооноор Хонконгчууд Apple Daily-тэй салах ёс хийв": сүүлийн дугаар нь нэг сая хувь борлогдов.

© Apple Daily

Apple Daily задран нурсан нь

2021 оны 6 дугаар сарын 17-ны үүрээр 500 цагдаа Хонконгийн хамгийн алдартай хэвлэл мэдээллийн нэг Apple Daily сонинг эзэмшдэг Next Media группын төв байрыг бүслэв. Ийм дүр зургийг террорист халдлага үйлдсэн, эсвэл тэсрэх бөмбөг тавьсан хэрэг гарахад харж болох боловч Хонконгийн тухайд энэхүү [үймээн самуун дэгдээх](#) шалтгаан хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрөө байв.

Бээжингийн тушаалаар цагдаа нар Apple Daily-ийн байр руу дайран орж, сэтгүүлчдийг өрөөнөөс нь хөөн гаргаж, компьютер, утас, бусад төхөөрөмжийг нь хураан авсан. Энэ явдлын хажуугаар, цагдаа нар тус сонины удирдлагуудыг орон гэрээс нь баривчилсан. Тухайн өдрийн орой засгийн газар Apple Daily сонины толгой компани болох Next Digital группын хөрөнгийг битүүмжлэн царцаасан нь тус байгууллагын ажилтнууд, ханган нийлүүлэгчид цалинжих боломжгүй болж, улмаар үйл ажиллагаа явуулах аргагүйд хүрсэн.

Долоо хоногийн дараа буюу 6 дугаар сарын 24-нд Apple Daily эцсийн дугаараа нийтэлсэн. Тухайн өдрийн сүүлээр дугаарын борлуулалт нэг саяд хүрсэн нь энгийн үед зарагддаг тооноос 10 дахин байв. Олон хүн Их Британийн колони байсан улсын хэвлэлийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг болсон 26 жилийн түүхтэй сониныг дэмжихээр сонины мухлагууд дээр шөнөжин дугаарлан зогссон. Хонконгийн оршин суугчдын ийнхүү өргөн хүрээнд дэмжсэн тэр өдрөөс хойш хэвлэл мэдээллийнхний зүгээс тус сониныг үндэслэгч Жимми Лайд байнгын дарамт шахалт үзүүлж, түүнийг 2020 оны 12 дугаар сард шоронд хорьсон явдлыг эсэргүүцэх боломж олгосон юм.

Энэ үйл явцыг түргэн хугацаанд шийдвэрлэхэд түлхэц болох үүднээс 2021 оны 9 дүгээр сарын эхээр Apple Daily-ийн толгой компани Next Digital татан буугдах хүсэлтээ өгч, захирлуудын зөвлөл огцорсон. Тухайн сарын сүүлээр засгийн газар Next Digital-ийн үйл ажиллагааг хаахаар шүүхэд хандсан.



© Anthony Wallace / AFP

АНХААРЛЫН ТӨВД

Хонконгийн сэтгүүлчдэд эрх чөлөөгөө хадгалан нутгаа орхих, эсвэл шоронд орох сонголт үлджээ

2021 оны 6 дугаар сард Гадаадын сурвалжлагчдын клубийн (ФСНК) хийсэн судалгаагаар Хонконг дахь сэтгүүлчдийн бараг тал хувь нь засаг захиргааны онцгой бүс нутгийг орхигоор шийдсэн. Тэдний зарим нь RSF-д өгсөн ярилцлагадаа тус бүс нутгийг орхин гарах, эсвэл шоронд орохын аль нэгийг сонгоход хүрч буй талаар ярьжээ.

2021 оны 6 дугаар сарын 27-нд Хонконгийн нисэх онгоцны буудал дээрээс Apple Daily сонины тоймчийг баривчилснаас хойш хоёр хоногийн дараа Hong Kong Free Press цахим мэдээллийн хэрэгслийн редакцийн захирал асан **Крис Чэн** тус нутаг дэвсгэрийг орхигоор шийдсэн.

"Энэ баривчилгаа олон сэтгүүлчийг айлгасан. Тэр үед миний тэвчээрийн хязгаар алдарсан байх" хэмээн Чэн өгүүлэв. Тэрээр Нэгдсэн Вант Улс руу шилжин суурьшиж, АНУ-д төвтэй Америкийн дуу хоолой олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагад чөлөөт уран бүтээлчээр ажиллаж байна. Алс холын зай, цагийн зөрүү зэргээс үүдэн Чэний хувьд Хонконгийн талаар барагтай бол мэдээлж чадахгүй байна. Түүний хувьд тус улсад өрнөж буй үйл явдал дэндүү бүрхэг бараан бөгөөд тэрээр, "Харамсалтай нь, одоогийн байдлаар Хонконгийн тухайд шүүхээс ял авсан хүмүүсийн талаарх мэдээ мэдээлэл зонхилж буй бөгөөд би өөрийн биеэр оролцож чадахгүй байна" гэв.

Эрэн сурвалжлах сэтгүүлч **Бао Чои** (зурагны баруун дунд талынх) 2021 оны 4 дүгээр сард худал мэдээлэл тараасан хэргээр торгох [ял шийтгүүлсэн](#) бөгөөд АНУ-д сэтгүүл зүйн чиглэлээр сурахаар Хонконгоос явсан. Тэрээр Бээжинг дэмжигч зохион байгуулалттай "triad" бүлэглэл ардчиллын төлөө жагсаал цуглаанд оролцож байсан тэмцэгчид, сэтгүүлчид, хажуугаар өнгөрч байсан хүмүүс руу халдсан үйлдэлд цагдаа нарын зүгээс ямар ч арга хэмжээ аваагүй талаар баримтат нэвтрүүлэг хийсэн юм. Ийнхүү ажлаас түр завсарласандаа сэтгэл хангалуун байгаа хэдий ч тэрээр үүнийг цөллөг гэж үзээгүй. Чои "Намайг баривчилж магадгүй байсан болохоор зугатаж байгаа хэрэг биш. Сэтгүүлчдэд ажлаа хийх орон зай үлдсэн хэвээр байгаа" гэв.

Хонконгийн Сэтгүүлчдийн холбооны тэргүүн **Ронсон Чаны** үзэж буйгаар, сэтгүүлчдийн шилжин нүүх, эсвэл үлдэх шийдвэр янз бүрийн хүчин зүйлээс хамаардаг. Тэрээр хэлэхдээ, "Олонх нь гэр бүлийнхнийхээ ирээдүйд санаа зовниж, Хонконгийн улс төрийн уур амьсгал улам ширүүн болж байгаа энэ үед зовлон зүдгүүр амсахаас сэргийлэхийг хүсэж байгаа ч зарим сэтгүүлчийн хувьд гадаад оронд мэргэжлээрээ хэрхэн ажиллах нь тодорхойгүй тул тийм ч амархан явж чадахгүй" гэв. Олон улс орныг хилээ хаахад хүргэсэн Ковид-19 цар тахал шилжин нүүх хүсэлтэй сэтгүүлчдийн боломжийг ч мөн хязгаарласан.

Хонконг дахь олон сэтгүүлч ирээдүйнхээ төлөө шаналж байгаа ч тэдний ихэнх нь Хонконгийг хувь заяанд нь даатгаад орхихыг хүсэхгүй байна. Хонконгд төвтэй цахим мэдээллийн сайтын нэрээ нууцлахыг хүссэн редактор "Өөрийгөө цагдан хянасан далд ухамсарт нуугдаж буй бодлоосоо салах шаардлага бидэнд байнга тулгардаг. Гэвч бид үлдэхийн тулд энд байна. "Ёс зүйн хэм хэмжээ, сэтгүүл зүйн хэм хэмжээ, эрхэм зорилгоо хэвээр хадгалж үлдэхийн зэрэгцээ тогтвортой үйл ажиллагаа, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах үүднээс ямар хэлцэл хийж, ямар тохиролцоонд хүрч болохыг харахын тулд алхам алхамаар урагшлах болно."



© Anthony Wallace / AFP

Хориң жилийн турщ уруудан доройтсон хэвлэлийн эрх чөлөө

Доройтлын цаг тооллыг урьдчилан таамагласан нь

1997 оны 7 дугаар сарын 1-нд Хонконгийг Их Британиас Хятадад шилжүүлэн өгөх үеэр Хонконгийн олон оршин суугч 1980-аад оноос хойш тэдний эдэлж байсан хэвлэлийн эрх чөлөөг "нэг улс - хоёр тогтолцоо" бодлогын дагуу Засаг захиргааны онцгой бүсийн суурь хуулиар баталгаажуулсныг үл харгалзан Хятад улс үл хүндэтгэх вий хэмээн түгшиж байв.

1996 оны дундуур Төрийн зөвлөлийн дэргэдэх Хонконг, Макаогийн асуудал эрхэлсэн газрын захирал Лу Пин, шилжилтийн дараа сэтгүүлчдэд "хоёр Хятад", "нэг Хятад, нэг Тайвань", "Хонконгийн тусгаар тогтнол"-ын талаар нөлөөлөл хийхгүй байхыг анхааруулсан нь чөлөөт хэвлэлийг боомилох ажиллагааг эртнээс төлөвлөж байсан гэж дүгнэхэд хүргэсэн. Захирагчаар томилогдох гэж байсан Тун Чи-хва Хонконгийн оршин суугчдыг түгшээсэн асуудалтай холбогдуулан, шилжилтийн өмнөхөн хэлсэн үгэндээ Хятадын нийгэмд "хувь хүний эрх"-ээс "дэг журам" илүү чухал байсан хэмээн өгүүлэв.

"Ухамсартай, зориудын бөгөөд чин сэтгэлийн хүчин чармайлт"

Бүс нутаг эх газарт эргэн нэгдсэнээс хойших сар өдрүүдэд нөхцөл байдал бараг өөрчлөгдөөгүй тул хэвлэл мэдээллийн хэрэгслүүд засгийн газраас хараат бус байдлаа алдалгүй үргэлжлүүлэн ажиллаж байсан. Энэ үйл явцаас хойш нэг сарын дараа колончлолын дараах Хонконг дахь хэвлэлийн эрх чөлөөний асуудлаарх семинар дээр Хонконгийн Баптист их сургуулийн сэтгүүл зүйн ахлах багш **Тим Хамлетт** төв засгийн газрыг "ухамсартайгаар, зориуд, чин сэтгэлээсээ Хонконгоос холдохоор чармайж" байгааг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч энэ байдал удаан үргэлжилнэ гэдэгт эргэлзэж буйгаа илэрхийлэв. Үнэн хэрэгтээ Бээжингийн энэ илэрхий найрсаг санаа олон сэтгүүлчийг [эргэлзэхэд хүргэсэн](#).

1997 оны 9 дүгээр сард, хүлээлгэн шилжүүлснээс хойш хоёр сарын дараа Хятадын ГХЯ-ны Хонконг дахь хороо " гадаад, дотоодын сэтгүүлчдийн мэдээлж сурвалжлах хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй" гэсэн амлалтаа дахин давтаж, санаа зовнисон Хонконгийн оршин суугчдыг тайвшруулахыг оролдов. Тухайн үед нийтлэгдсэн хэвлэлийн эрх чөлөөний төлөө ажилладаг Сэтгүүлчдийг хамгаалах хороо (СР)-ны тайланд Хонконгийн хэвлэл мэдээллийг дарангуйлна гэх айдас хараахан "биеллээ олоогүй" байгааг хүлээн зөвшөөрч буй ч урт хугацаандаа Хонконгийн хэвлэлийн эрх чөлөөнд аюул учруулж болзошгүй "өөрийн цагдан хяналтын" эрсдэл нэмэгдэж байгааг анхааруулсан.

Мянганы эхний арван жилийн турш нөхцөл байдал өөрчлөгдөөгүй хэвээр байв. 2003 онд хагас сая Хонконгчууд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төслийг цуцлахыг шаардан гудамжаар жагсахад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аливаа саад бэрхшээлгүйгээр ажлаа хийж, Apple Daily сонин эхний нүүрэндээ "Гудамжинд уулзацгаая" уриа нийтэлж, уг эсэргүүцлийн [гол зохион байгуулагч](#) гэдгээ харуулсан.

Өмнөд Хятадын өглөөний шуудан (SCMP) өдөр тутмын сониныг Алибаба эзэмшив

2012 онд англи хэл дээр нийтэлдэг өдөр тутмын *Өмнөд Хятадын өглөөний шуудан* (SCMP) сонины ерөнхий редактороор эх газрын сэтгүүлч, Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх бага хурлын гишүүн Ван Шянвэй томилогдсоны дараа тус сонины сэтгүүлчид түгшүүр зарлав. Тухайн үед Хятадын Коммунист намтай нэлээн ойр дотно байсан Хятадын бизнесмэн Жэк Магийн үүсгэн байгуулсан Алибаба групп холдинг гурван жилийн дараа уг ХМХ-ийг эзэмшилдээ оруулсан нь сэтгүүлчдийг айдастай хэвээр үлдээв.

Захирагч “уучлал гуйхыг” шаардав

Гурав дахь захирагч Люн Чун-Ин буюу Ч.И. Люн хэлэхдээ, 2013-2017 оны хооронд эрх баригчид болон хэвлэл мэдээллийн хоорондын харилцаа илт муудсан. Албан тушаалд томилогдсон эхний жил түүнийг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлтэй холбоотой байж болзошгүй талаарх нийтлэл Хонконгийн эдийн засгийн сэтгүүлд гарсны дараа тэрээр тус ХМХ-ийг түүнээс бичгээр уучлалт гуйхыг шаардсан. Мөн *Apple Daily* сонин зэрэг хэд хэдэн хараат бус хэвлэл мэдээллийг [хэл амаар дайрч давшилсан](#).

2014 онд Хонконгийн сэтгүүлчид анх удаа цагдаагийн зүгээс их хэмжээгээр үйлдэх хүчирхийллийн бай болсон. Тухайн үед ардчиллыг дэмжих “Шүхэр хөдөлгөөн”-ийг цагдаа нар хүч хэрэглэн тараахад 2000 гаруй хүн, түүний дотор 30 орчим сэтгүүлч шархадсан. Цагдаагийн зүгээс ч бай, Бээжинг дэмжигч мафийн бүлэглэлийн зүгээс ч бай хэвлэл мэдээллийн эсрэг бие махбодийн халдлага тасарсангүй. Түүнээс хойш Ч.И. Люн, түүний халагч залгамжлагч Кэрри Лам нар нутаг дэвсгэр дээр өрнөж буй эсэргүүцлийн хөдөлгөөнийг мэдээлж сурвалжлах хэвлэл мэдээллийн нөлөөлөл, боломжийг тууштай хумиж, хараат бус хэвлэл мэдээллийн эсрэг нээлттэй дайн зарлав.



Хятадын мэдэлд шилжсэнээс хойш 25 жилийн дараа Хонконгд тус улсын оршин суугчдын айж байснаар хэвлэлийн эрх чөлөө эрс доройтсон.

© Paul Lakatos / AFP

АНХААРЛЫН ТӨВД

РТНК олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг цагдан хянаж, залхаан цээрлүүлэв

Нэгэн үе редакцийн хараат бус байдлаараа Хонконгийн оршин суугчдын бахархал байсан РТНК олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага өдгөө хөтөлбөрийн шинэ захирлаар дамжуулан бүрэн утгаар цагдан хяналтад өртөв.

2021 оны гуравдугаар сарын 1-нээс Патрик Ли Хонконгийн радио телевизийн (РТНК) өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн [захирлаар ажиллаж эхэлсэн](#) өдрөөс эхлэн хамгийн багадаа 12 шинэ бүтээлийг богино хугацаанд эфирээс татаж, мөн архивлагдсан 200 гаруй нэвтрүүлгийг байгууллагын Youtube сувагаас устгасан. Тяньаньмэний талбайд болсон хядлагын дурсгалд зориулсан арга хэмжээний дүрс бичлэг бүхий *LegCo Review* улс төрийн шоу нэвтрүүлгийн дугаарыг Лигээр “батлуулаагүй” цацсан тул РТНК-ийн архиваас устгасан.

Хэвлэл мэдээллийн ямар ч туршлагагүй, РТНК дахь [улс төрийн комиссар](#) энэ хүнд сурталтан урьд өмнө төрийн бодлогын талаар айх айдасгүй эрэн сурвалжилдгаараа нэртэй ХМХ болсон тус байгууллагын хэмжээнд бүрэн цагдан хяналт тогтоов. Батлахаас татгалзсан хөтөлбөрүүдийг эфирээс хассанаар түүний сэтгэл ханасангүй. Түүний нийтэд түгээхэд тохиромжгүй гэж үзсэн контент бүтээхэд гар бие оролцсон ажилтнуудын цалинг хоёр дахин бууруулна хэмээн сүрдүүлэв.

2021 оны 9 дүгээр сард тус өргөн нэвтрүүлгийн байгууллага сэтгүүлчдийг “үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхлыг хамгаалахад засгийн газарт дэмжлэг үзүүлэх”, Хонконгийн гүйцэтгэх засаглал болон Хятадын засгийн газрыг “үзэн ядах, ялгаварлан гадуурхах, дайсагналцуулах”-д өдөөн турхирах, гүнзгийрүүлэхээс зайлсхийх, “гадаадын засгийн газар буюу улс төрийн байгууллага”-тай харилцахаас татгалзах тухай редакцийн шинэ удирдамж баталсан. РТНК нь үзэгчдэд “эх оронч үзэл” төлөвшүүлэх зорилгоор 2021 оны 8 дугаар сард Хятадын төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн байгууллага Хятадын хэвлэл мэдээллийн групптэй хамтран ажиллаж эхэлсэн.

Патрик Ли албан тушаалд томилогдсоноор гүйцэтгэх продюсер **Фон Хю-шан, Лю Вай-лин, Дорис Вон**, шагнал хүртсэн сурвалжлагч **Ивонне Тон** нарын дор хаяж дөрвөн ахлах ажилтан халагдах өргөдлөө өгсөн. Засгийн газрын албан тушаалтнуудад тууштай асуулт тавьдагаараа нэртэй бас нэг сэтгүүлч **Набела Косер** ч гэрээгээ сунгахаас татгалзжээ.

РТНК-ийн нэвтрүүлгийг бэлтгэхэд гуч гаруй жил хувь нэмрээ оруулсан Британийн ахмад сэтгүүлч, улс төрийн тоймч **Стивен Винс** өөрийн хөтөлдөг англи хэл дээрх *The Pulse* улс төрийн ток шоу нэвтрүүлгийг хасах шийдвэр гарсны дараа 2021 оны 8 дугаар сард Хонконгоос явсан. Тэрээр “Хонконг сэтгүүлчдэд аюулгүй газар гэж эрүүл ухаантай хэн ч батлан хэлж чадахгүйд хүрээд байна” гэв.



© RTHK / YouTube Screenshot



Сурвалжлагчид бие махбодийн хүчирхийлэлд өртсөн нь

2019 оны 6 дугаар сарын 12-нд ардчиллыг дэмжих жагсаалын үеэр Хонконгийн цагдаагийн газрын өдөр тутмын хэвлэлийн бага хурал маш хурцадмал уур амьсгалд болж өнгөрөв. Хэвлэлийн бага хурлыг сурвалжилж буй сэтгүүлчид бүгд [цагдаагийнхны түрэмгий авираас](#) хамгаалахад зайлшгүй хэрэгтэй дуулга малгай “байлдааны өмсгөл” өмссөн нь олон зуун сэтгүүлчид гэмтэл бэртэлд өртөж энэ нь улам даамжирсаар байнгын үзэгдэл болсонтой холбоотой. Хонконгийн Сэтгүүлчдийн холбоо сэтгүүлчдийн эсрэг хүчирхийллийг [алхам тутамдаа баримтжуулан](#) мэдээлдэг ч цагдаагийн газар үргэлж үгүйсгэсээр байна.

Эсэргүүцлийн хөдөлгөөнийг сурвалжлах сэтгүүлчдийн хувьд харааж зүхүүлэх, гавлуулах, бороохойдуулах, нулимс асгаруулагч хийгээр утуулах, үрлэн сумтай буу, даралттай ус шүршигчид өртөх нь хэвийн үзэгдэл мэт болсон. Дэлхий дахинд олон арван жилийн туршид, хэвлэлийн эрх чөлөөний үлгэр загвар болж байсан газар нутаг дээр Британийн колончлолын үеийн өв уламжлалаас үүдэлтэй аливаад харьцангуйн үүднээс ханддаг зангаа цагдаа нар аль хэдийн умартаж, харин ч Хятадын бусад нутаг дэвсгэрт үйлчилдэг хатуу дэг журмыг сахиулах арга барилыг хэрэглэн, жагсагчид, сэтгүүлчид алиныг нь ялгалгүй цугларсан олныг цохиж, занчих болов.

Халуун чинжүү зориудаар шүршив

Халуун бүсийн хөгжингүй хотдоо тааламжтай хувцаслах боломж боллоцоотой байсан Хонконгийн сэтгүүлчид шинэ нөхцөлд түргэн дасан зохицох хэрэгтэй болов. Тэдний шинэ хувцас, дэгжин хэв маягийг дагахын оронд илүү энгийн, барилгын талбар дээр ажиллахад тохирмоор, хөлд эвтэйхэн гутал, ус үл нэвтрэх амны хаалт, аюулаас сэргийлэх гэрэлтүүлэгч бүхий хантааз ба хорт хийнээс хамгаалах хаалтаас бүрдэх болсон, мөн ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгцээтэй хамгаалалтын хувцас өмсөх болсон нь гэмтэж бэртэх, амьсгалын замын эрхтэнээ гэмтээх эрсдэл дэндүү ихэссэнтэй холбоотой юм.

2019 оны 9 дүгээр сард индонези хэлээр эрхлэн гаргадаг Суара Хонконгийн мэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ)-ийн сэтгүүлч **Веби Мега Индах** [үрлэн сумтай бууны суманд](#) оногдсоны дараа баруун нүд нь сохорсон. Мөн оны 11 дүгээр сард өдөр тутмын Mad Dog цахим хэвлэлийн сэтгүүлч өндөр даралттай ус шүршигчид шүршүүлснээс яаралтай хагалгаа хийлгэх шаардлагатай тархины хүнд бэртэл авчээ. Цагдаагийн алба хаагчид санаатайгаар, байнга хэвлэл мэдээллийн ажилтнууд руу халуун чинжүү шүршиж байсан ба мөн сэтгүүлчид гэдэг нь танигдахуйц бүлэг хүмүүс рүү гал нээж, буудсаар байв. 2020 оны 5 дугаар сард болсон баривчилгааны үеэр *Apple Daily* сонины гэрэл зургийн сурвалжлагч эмэгтэйг цагдаагийн алба хаагч 20 секунд орчим хоолойг нь боосон тухай мөн мэдээлж байв.



Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн халдлага

Сэтгүүлчдийн эсрэг цагдаагийн алба хаагчид хүчирхийлэл үйлдэхийн зэрэгцээ, Бээжинг дэмжигч бүлэг орон нутгийн зохион байгуулалттай гэмт бүлэглэлд хандан хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй “тооцоо бодохыг” уриалах болов. 2014 оны 3 дугаар сард, ардчиллыг дэмжигч эсэргүүцлийн “Шүхэр хөдөлгөөн” эхлэх үеэр сэтгүүлч **Кевин Лау**, түүний дараа өдөр тутмын *Минг Пао* сонины ерөнхий эрхлэгчийг жижиг сүхээр цохиж, хүнд гэмтэл учруулжээ. Халдлага үйлдсэн этгээдүүдийг баривчилж шийтгэсэн хэдий ч өдөж турхирсан хүмүүс ял зэмгүй үлдсэн. Ардчиллыг дэмжигч ХМХ-үүд тухайлбал, *Apple Daily* болон эрхлэгч **Жимми Лай** нарын эсрэг хэд хэдэн удаа эрүүгийн гэмт халдлага үйлджээ.

2019 оны 7 дугаар сард сурвалжлагч **Гвинет Хо Квай-Лам** нь Юэнь Лон метроны буудлын зорчигчид, сэтгүүлчид, эсэргүүцлийн хөдөлгөөний жагсагч нар руу Бээжинг дэмжигч гэмт бүлэглэл өргөн цар хүрээтэй халдлага зохион байгуулсны хохирогч бөгөөд гэрч болов. Халдлагыг шууд дамжуулан нэвтрүүлсэн түүнийг гэмт бүлэглэлийнхэн зодож занчин, гарыг нь цус гартал гэмтээсэн. *Apple Daily* сонин болон *Now News TV* сувагт ажилладаг гурван сэтгүүлч мөн энэ халдлагын үеэр бэртсэн юм.

2021 оны 5 дугаар сард, *Epoch Times* сонины сурвалжлагч **Сара Лианыг** оршин суудаг байрны нь ойролцоо хоёр эрэгтэй хүн бейсболын цохиураар хөл рүү нь удаа дараа цохиж, гэмтээжээ. Уг сонины



агуулах руу сарын өмнө зэвсэглэсэн дөрвөн этгээд [халдаж](#), ажиллагсдыг айлган сүрдүүлж, улмаар сонины гол хэвлэх машиныг эвдлэн сүйтгэсэн байна. Хоёр жилийн өмнө уг сонины агуулахад гал тавьсан хэдий ч азаар ямар нэгэн хохирол учраагүй өнгөрсөн юм.

Үрлэн сумтай буу, даралттай ус шүршигч, нулимс асгаруулагч хий: Энэ нь Хонконг дахь эсэргүүцлийн хөдөлгөөнийг сурвалжлах сэтгүүлчдийн хувьд шинэ дэг журам болов.

© Isaac Lawrence / AFP

© Philip Fong / AFP

© Nasha Chan / Initium Media



© Anthony Wallace / AFP

Кэрри Ламын салаа утгатай үгс

Нэр дэвшихийг нь хөхиүлэн дэмжсэн Бээжингийн эрх баригчдын дэмжлэгтэйгээр 2017 онд явагдсан сонгуульд Кэрри Лам захирагчаар сонгогдсон нь гайхмаар хэрэг биш байлаа. Хэвлэл мэдээллийн байгууллага руу удаа дараа халдсанаараа олон нийтийн шүүмжлэлийн бай болсон Ч.И. Лянгийн залгамжлан, сэрүүцүүлэх төхөөрөмжөөр тоноглогдсон Хонконгийн засаг захиргааны ертөнцөд 37 жил ажилласан туршлагаас өөр онцлох зүйлгүй, анхааралд өртөмгүй энэ ахлах түшмэл гарч ирсэн юм. Сэтгүүлчид удаан хугацааны турш шахаж шаардаж байсан [засгийн газрын хэвлэлийн бага хурлыг](#) хараат бус цахим ХМХ-д нээлттэй болгосон нь Кэрри Ламын эхний шийдвэрийн нэг байв. Хэвлэлийн эрх чөлөөнд ахиц дэвшил гарах нь гэж хэн хүнгүй итгэх дөхсөн үйл явдал болсон.

Харамсалтай нь, Кэрри Лам өөрийн үнэн дүр төрхөө удалгүй харуулсан. Бээжингийн дэглэмийн утсан хүүхэлдэй тэрээр “эх оронч үзэл” нэрийн дор зорилгоо хэрэгжүүлж, эрх чөлөөг үгүйсгэгч бодлогоо зогсолтгүй хамгаалахын зэрэгцээ, Хонконгийн иргэд эрх чөлөөгөө ямар ч хэлбэрээр алдаагүй хэмээн чанга дуугаар тунхаглан зарлах болсон. Тэрээр сэтгүүлчид болон бусад хүмүүсийг эх газрын Хятадад [шилжүүлэн өгөхийг](#) зөвшөөрсөн хуулийн төсөл 2019 оны эхээр батлуулахыг оролдсон нь Хонконгд урьд хожид гараагүй эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөхөд нөлөөлж, хуулийн төслөө татан авахад хүргэсэн юм. Эдгээр жагсаал цуглааны үеэр цагдаагийн алба хаагчид олон сэтгүүлчийн эсрэг бие махбодийн хүчирхийлэл үйлдсэн ч Кэрри Лам үүнийг хүлээн зөвшөөрөхөөс үргэлж татгалзсаар байв.

Дүр эсгэсэн яриа

2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр, хүчирхийллийг буруушаан, хямралаас ангижрах арга замыг санал болгон, [RSF-ээс илгээсэн захидлын хариуд](#) Кэрри Лам, “Хонконгийн өнгөрсөн, одоо ба ирээдүйн амжилтад чөлөөт, нээлттэй хэвлэл мэдээллийн орчин ба мэдээ мэдээллийн аливаа саадгүй, чөлөөт урсгал амин чухал ач холбогдолтойг” хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлсэн юм. Гэсэн хэдий ч тэрээр бүх баримт нотолгоог үгүйсгэн, “олон нийтийн жагсаал цуглааныг сурвалжлах ХМХ-ийн эрх ба хэвлэлийн эрх чөлөөнд цагдаагийн алба хаагчид хүндэтгэлтэй ханддаг”, мөн “Хонконгд гэрэл зургийн сурвалжилга хийх, телевизийн мэдээ мэдээлэл бэлтгэх, нийтлэл бичсэний төлөө сэтгүүлчид ямарваа нэгэн шийтгэл амсаагүй, шоронд хоригдоогүй” тухай мэдэгдэж, олон нийтийг бухимдахад хүргэсэн.

Сэтгүүлчдийг хамгаалдаг тухай мэдэгдсэнээс хойш жил хүрэхгүй хугацааны дараа 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Кэрри Лам, дэглэмийн зүгээс төрийн эсрэг гэмт хэрэгт сэжиглэгдсэн бүх хүмүүс, түүн дотроо сэтгүүлчдийг бүх насаар нь хорьж шийтгэхийн тулд Бээжингийн дэглэмийн баталсан Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг нийтийн өмнө талархалтай хүлээн авсан нь өөрийнх нь захирагчийн эрх мэдлийг үл тоомсорлон, улмаар засаг захиргааны онцгой бүс нутгийн дотоод хэрэгт шууд оролцохыг зөвшөөрсөн хэрэг болсон юм.

Бурууг зөвтгөх нь

Харин хэдхэн сарын дараа Кэрри Лам дээрх хуулийг мөрдлөг болгон дагаж, шүүхийн дарамт учруулах замаар “төрийн эсрэг гэмт хэрэг” үйлдсэнд тооцож, *Apple Daily* сонинг үндэслэгч, RSF-ийн 2020 оны Хэвлэлийн эрх чөлөөний шагналын эзэн **Жимми Лай**, хууль тогтоогч, мөн сэтгүүлч асан **Клаудия Мо** болон бусад 12 сэтгүүлчийг буруутган ялласан юм. Уг хуулийг мөн *Apple Daily* сонины дүрмийн сангийн хөрөнгийг царцаахад хэрэглэсний улмаас 2021 оны 6 дугаар сарын сүүлээр сонин үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн юм. Засгийн газар *Apple Daily* сониныг чухам юунд буруутган шүүмжилж байгааг тэрээр “энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн асуудал ч бус, мэдээ дамжуулах асуудал ч бус” харин Бээжингийн цагдан хоригоос татгалзаж, сөрөг хүчний хөдөлгөөнд өөрийгөө илэрхийлэх боломж олгосон учраас “үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн асуудал” боллоо хэмээн ажиггүй тайлбарласан юм.

Бурууг хүчээр зөвтгөхийн тулд хэлсэн Кэрри Ламын илтгэл итгэмээргүй өнгө аястай болж хувирсан ба тэрээр: “Хонконгийн засгийн газрыг шүүмжлэх нь асуудал биш бөгөөд харин, гэхдээ засгийн газрыг огцруулахаар өдөөн турхирах үйл ажиллагаа санаачилваас, мэдээж энэ нь өөр хэрэг гэдгийг хэлэх нь зүйтэй. [...] Хэвлэл мэдээллийн нөхөд маань харин үүнийг ялгаж ойлгох чадвартай байх ёстой” гэсэн юм. Гэхдээ Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн аль нэг хэсэгт шүүмжлэл энд дуусаж, одоо огцруулах асуудал сөхөгдөж байгаа хэмээн тодорхойлсон заалт оруулаагүй учраас сэтгүүлчийн хувьд буруутан болохоос сэргийлэх цорын ганц арга нь шүүмжлэхээс татгалзаж амаа хамжих явдал болсон юм.

Аажим ухралт

Кэрри Лам Хонконгийн хэвлэлийн эрх чөлөөний мөн чанарыг алгуурхан алдагдуулж байна. Тэрээр 2021 онд дуу, дүрс бичлэгийн групп болох Хонконгийн радио телевизийн (RTHK) редакцад хяналт тогтоохын тулд хөтөлбөрийн захирлаар [цагдан хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн](#) хүнийг тохоон томилж, улмаар түүнд бүтэн сарын турш өөрийн өдөр тутмын ярилцлагын нэвтрүүлгээ хөтлөх санал тавьсан байна.



Сэтгүүлчдийн баривчилгаа, дүр эсгэсэн яриа ба визний зөвшөөрлийг урвуулан ашиглах нь: Кэрри Лам хэвлэлийн эрх чөлөөг хаан боогдуулах аяныг амжилттай зохион байгуулав.

© RTHK / Screenshot

Түүний удирдсан засаг захиргаа, хэвлэл мэдээлэлд олгодог “олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн” хэвлэлийн магадлан итгэмжлэлээс татгалзсан нь хэвлэлийнхнийг тодорхойлох боломжгүй нөхцөл үүсч, улмаар бие даасан ХМХ, чөлөөт уран бүтээлчид ба оюутны хэвлэл мэдээллийн байгууллагыг өөрсдөдөө ашигтайгаар, санаан зоргоор хясан боох нөхцөл бүрдсэн. 2021 оны 9 дүгээр сард Хонконгийн цахим хэвлэл мэдээллийн хэрэгслийн анхдагчид болох *Stand News*, *Citizen News* нарын сэтгүүлчдийг Хятадын үндэсний баярын өдрийн арга хэмжээнд нэвтрүүлэхээс татгалзжээ.

Эцэст нь, Кэрри Лам эх газарт ихэвчлэн хэрэглэж дассан гадаадын сэтгүүлчдэд олгодог [визний зөвшөөрлийг урвуулан ашиглах аргыг](#) амьдралд нэвтрүүлсэн юм. Тусгаар тогтнолыг дэмжигч идэвхтнийг оролцуулан, Хонконгийн Гадаадын сурвалжлагчдын клубт (FCCNK) үдийн цай – мэтгэлцээн хөтлөн явуулсны улмаас *Financial Times* сонины сэтгүүлч **Виктор Маллег** 2018 онд хөөн гаргасан. Мөн 2021 оны 11 дүгээр сард болох Хонконгийн Чөлөөт Хэвлэлийн (HKFP) цахим уулзалтад оролцохыг хүссэн **Аарон Мак Николас** болон эх газрын Хятад улсаас хөөгдөн гараад удаагүй *New York Times* сонины сурвалжлагч **Крис Бакли** нарт 2020 онд виз олгохоос татгалзсан. Түүнчлэн Кэрри Ламын засаг захиргаа Их Британийн өдөр тутмын *The Economist* сэтгүүлийн сэтгүүлч **Сью-Лин Вонгийн** визний хугацааг ямар нэгэн тайлбар хэлэлгүйгээр, сунгахаас татгалзсан байна.

АНХААРЛЫН ТӨВД

Макаогийн бие даасан хэвлэл мэдээлэл бэрх цагт

Хятадын засаг захиргааны бас нэгэн онцгой бүс Макао нь тэрслүү үзэлт Хонконгтой харьцуулахад “үзүүлэнгийн хүүхэлдэй” адил бусдын төсөөлөлд буудаг хэдий ч үргэлж хязгаарлагдмал байсан хэвлэлийн эрх чөлөө тэнд улам багассаар байна.

2021 оны 10 дугаар сарын 20-нд 1996 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй *Macau Concealers* хэмээх цахим хуудас хотыг “олон өнцгөөс” тольдохыг чармайсан нэвтрүүлэг гаргасан өдрөө үйл ажиллагаагаа зогсоож буйгаа зарлахдаа “урьд хожид байгаагүй орчин нөхцөл” буюу цагдан хяналт улам нэмэгдэж, хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагыг дарамтлах болсон тухай дурджээ.

Хонконг нэгдсэнээс хойш хоёр жилийн дараа буюу 1999 онд Хятадад эргэн нэгдсэн, Португалийн колони байсан Макао хувь тавилантайгаа чимээгүй эвлэрэхээс өөр сонголт байгаагүй. 700 мянга гаруйхан хүн амтай, мөрийтэй тоглоомын салбараас эдийн засаг нь бүрддэг Макао эх газрын Хятадтай сайн харилцаагаа хадгалах ёстой болжээ. Хонконгийг бодвол хамаагүй жижиг, цомхон хэвлэл мэдээлэлд сонголт хийх боломж хомс ба “эмзэг” буст тооцогдох орон нутгийн сэдэвт асуудлаар харьцангуй бие даасан байдлаа хадгалан, нөлөө нь өсөн нэмэгдсэн Бээжингийн дэглэмд нийцүүлэн ажиллах болов. 2009 онд, Макао төрийн эсрэг гэмт хэрэгт 30 хүртэлх жилийн ял оноох Үндэсний аюулгүй байдлын тухай хууль баталсан хэдий ч өнөөг хүртэл энэ хуулийн дагуу шийтгэл оноосон тохиолдол гараагүй юм.

2019-2020 онуудад төрийн санхүүжилтээс ихээхэн хамааралтай Макаогийн хэвлэл мэдээлэл Хонконгийн ардчиллыг дэмжигчдийн эсэргүүцлийн хөдөлгөөний тухай нэвтрүүлэхээс зайлсхийж, хол хөндий үлдсэн. Харин англи, португали хэл дээрх цөөн тооны ХМХ өргөн цар хүрээтэй мэдээлэл бэлтгэсний улмаас тэдэнд ирэх дарамт шахалт нэмэгдэж, заналхийлэсаналхийлэн сүрдүүлэх нь ихэсчээ.

2019 оны 12 дугаар сард Хятадын дарга Ши Жиньпин Макао айлчлах үеэр Хонконгийн тав зургаан ХМХ-ийн сэтгүүлчдийг “нийгмийн аюулгүй байдалд заналхийлэх” гэдэг үндэслэлээр Макаогийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхээс татгалзсан. Португалийн олон нийтийн телевизийн сурвалжлагчдыг RTP (*Rádio e Televisão de Portugal*), цагдаагийн алба хаагчид хэдэн цагийн турш байцаан шалгаж, бэлтгэсэн нэвтрүүлгийн материалыг хураасан. Үүгээр зогсохгүй, орон нутгийн нэлээд хэдэн сэтгүүлчийг мөшгөсөн талаар мэдээлж, тэдний зарим нэгд Ши Жиньпиний айлчлалын үеэр “хэлж ярих зүйлдээ болгоомжтой” хандахыг анхааруулсан байна.

2021 оны 4 дүгээр сард Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын (*Teledifusão de Macau*) гүйцэтгэх хороо “Хятад болон Макаогийн засгийн газрын явуулж буй бодлогод харшлах үзэл бодол илэрхийлэх ба мэдээлэл түгээх” мөн “эх оронч үзэл сурталчлах”-ыг хориглосон [багц заавар](#) гаргаж, улмаар ажлаас халахаар сүрдүүлсний дараа 14 сэтгүүлч огцрохоос аргагүй байдалд оров.



© Macau Photo Agency



3

МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ НЬ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОГДОХ ҮЕ

- Хятадын Коммунист нам (ХКН) хамгийн сүүлийн үеийн технологийн ололтод түшиглэн, цаашид мэдээлэл олж авах нь эрх бус харин гэмт хэрэгт тооцогдох нийгмийн хэв загварыг бүтээхээр зорьж байна. Цагдан хяналт, суртал ухуулга, олон нийтийн хараа хяналтыг сөрөн давж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө авч үлдэхийн тулд Хятадын интернэт хэрэглэгчид хүчин чармайлтаа ихэсгэж, ур ухаанаа сорьж байна.
- Барууны орнуудын “дайсагнах хүчний” нөлөөг бууруулах нэрийдлээр Хятад улс өөрсдийн бий болгосон төрийн эрх ашигт үйлчлэх хуурмаг сэтгүүл зүйн үзэл баримтлалыг тарааж, суртал ухуулгаа улам илүү өнгөлөн далдалсан хэлбэрээр дэлхий дахинд түгээхээр ажиллаж байна. Энэ заналхийлэлтэй нүүр тулсан ардчилсан орны засгийн газар ба иргэний нийгмийн байгууллагууд хариу үйлдэл хийхдээ хүлээж тэвчихгүй болов.

© Bobby Yip / Reuters

Олон нийтийн санаа бодлыг хянах

Ковид-19: Эрх чөлөөний тэсрэлт тэр дороо хүчинд автан дарагдав

2020 оны 2 дугаар сарын эхээр Ковид-19 өвчиний тухай анх [мэдээлсэн шүгэл үлээгч](#), Ухань хотын Төв эмнэлгийн нүдний эмч **Доктор Ли Вэнляныг** нас барсны дараа Хятадын интернэт хэрэглэгчдийн дунд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүсэмжилсэн дуу хоолой хүчтэй цуурайтав. Өнгөрсний нь дараа баатар хэмээн өргөмжилсөн ч уг өвчнөөр нас барахаас хэд хоногийн өмнө түүнийг цагдаагийн газар “худал мэдээ тарааснаа” хүлээн зөвшөөрсөн мэдэгдэлд албадан гарын үсэг зуруулсан.

Түүнийг өнгөрснөөс хэдхэн хоногийн дараа, өөд болсон эмчийн дурсгалыг хүндэтгэх, хямралт цаг үед буруу бодлого явуулсан эрх баригчдыг шүүмжлэх, сүүлийн жилүүдэд тус оронд нийгмийн сүлжээн дэх агуулгыг хатуу чанд хянах болсныг эсэргүүцсэн #WomenYaoYanlunZiyou (Бид үзэл бодлоо илэрхийлэхийг хүсэж байна) өргөн цар хүрээтэй хөдөлгөөн Хятадын Сина Вейбо нийгмийн сүлжээнд өрнөж хоёр сая гаруй удаа уг онцлох тэмдэгийг ашигласан байна. Цагдан хянах албаны дарамт шахалтын улмаас эдгээр уриалгын ихэнхийг одоо устгажээ.

Өнөөгийн дэглэм ил тод байдлыг хангадаггүй, албан ёсны хэвлэл мэдээллийн бэлтгэсэн мэдээ хангалтгүй тул Хятадын ард иргэд бухимдан, үл итгэх хандлагатай байдгаас зарим иргэд хараа хяналтаас гарсан цар тахлын тухай сэтгүүл зүйн баримтжуулсан мэдээлэл бэлтгэсэн. Тэдний нэг, баруун хойд зүгийн Хэйлунжян мужийн хуульч **Чэн Чиуши** 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн эмх

з а м б а р а а г ү й
бужигнааны талаар сурвалжилж, өөд бологсдын гэр бүлтэй ярилцлага хийх зэргээр ихэнх цагаа Ухань хотын эмнэлэгт өнгөрөөв.



Цар тахлын тухай анх мэдээлсэн шүгэл үлээгч эмч Ли Вэнляныг нас барсны дараа зарим хүмүүс учрыг магадлахаар өөрийн эрхгүй Ухань хот руу явцгаасан.

© Mark Ralston / AFP

Ухань хотын оршин суугч, жирийн нэхмэл эдлэлийн наймаачин **Фан Бин** мөн Ковид-19 цар тахлын бодит байдлыг нутаг нэгт иргэддээ зайлшгүй мэдээлэх хэрэгтэйг ойлгон, эмнэлгүүд ачааллаа дийлэхгүй дүүрсэн байгааг баримтжуулсан анхны дүрс бичлэгээ 2020 оны 1 дүгээр сарын 25-нд нийгмийн сүлжээнд байршуулсан. Мэргэжлийн бус эдгээр хоёр сэтгүүлч 2020 оны 2 дугаар сарын эхээр [сураггүй алга болсон](#) ба цагдаагийн газар тэднийг баривчилсан байх магадлалтай. Алга болсноос хойш Чен Куйши 2021 оны 9 дүгээр сарын 30-нд нийгмийн сүлжээнд дахин гарч ирсэн ч өөрт тохиолдсон зүйлийн талаар ярихыг хүсээгүй. Харин Фан Бин хаана байгаа тухай өнөө хэр нь тодорхой мэдээлэл байхгүй.

Цар тахлыг багасгаж харагдуулах нь

Цар тахалтай тэмцэхдээ “олон нийтийн санаа бодлыг хянан зохицуулахыг эрчимжүүлэх” тухай Ши Жиньпин даргын 2020 оны 1 дүгээр сарын 20-нд гаргасан уриалга нь иргэдийн үнэн бодит, хараат бус мэдээ мэдээлэл олж авах гэсэн хязгааргүй хүсэлтэй зөрчилдөж байв. Харьцангуй чөлөөт хэвлэл болох *Цайсинь* ба *Цайжин* зэрэг хэвлэлд эрх баригчид бэлтгэл дутуу, нөхцөл байдалд уян хатан хандаагүй зэргээ хаацалж, цар тахлын бодит аюулыг нуун дарагдуулж буйг хөндөх болсон тул Коммунист нам 300 орчим сэтгүүлчийг “үнэн хэрэгтээ - үзэл суртлын дайчдыг” Ухань хот руу цар тахалтай тэмцэх тэмцлийг “ээрэг” өнцгөөс харуулахаар илгээв.

Түүнээс хойш удалгүй Хятадын эрх баригчид цахим орчин дахь мэдээ мэдээллийн урсгал, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэхийг хянан зохицуулах шаардлагатайг онцлов. Цахим орчинд олон нийтийн санаа бодол бүрдүүлэх Бээжингийн [стратеги төлөвлөгөөг](#) 2020 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд Хятадын Цахим орчны Захиргаанаас гаргасан 3200 удирдамж, 1800 санамж бичигт үндэслэн илчилсэн *New York Times* болон ProPublica сонины хамтарсан [эрэн сурвалжилга](#) 2020 оны 12 дугаар сард нийтлэгдсэн юм. “Эдгэрэшгүй” гэх мэт нэр томъёог мэдээллийн сайтад хязгаарлах хэлбэрээр өвчний хор хөнөөлийг нуун далдлах, цар тахалтай холбоотой түлхүүр үгс болон мэдэгдлийг хаах, цахим орчинд хөлсний бичээч нарыг дайчлан ажиллуулах нь Бээжингийн эрх баригчдын ашигладаг цахим орчны зэвсгийн бүх хэлбэр юм.

Шүүмжилсэн дуу хоолойг хүчээр дарав

Ли эмчийг өөд болсноос хойш удалгүй Хятадын цахим орчны захиргаа дараах удирдамжийг орон нутгийн товчоо бүрд илгээсэн ба “Энэ тохиолдлоос [Ли Вэнляны үхэл], үүдэн гарах үр дагавар, тухайлбал, нэг үхрийн эвэр доргиод мянган үхрийн эвэр доргиодог, жижиг зүйл даамжирсаар сүйрэлд хөтөлдөг, нөхцөл байдал нүд ирмэхийн зуур хяналтаас гардаг гэх зэргийг тунгаан бодох, энэ нь мөн цахим орчинд санал бодлыг хянан зохицуулах үүрэгтэй бидний өмнө тулгарч байгаагүй хүнд сорилт гэдгийг саруул ухаанаар хүлээн зөвшөөрөх ёстой юм” гэв. Цахим орчны захиргааны бүх товчоо цахим орчин дахь санаа бодолд анхаарлаа хандуулах, улс төрийн тогтолцоо руу дайрсан, нам болон засгийн газрын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан аливаа үйлдлийг хатуу хянах ёстой” гэжээ.

Цагдан хяналтыг шүүмжилсэн дуу хоолойг хүчээр дарах дээр хэлмэгдүүлэлт ийнхүү нэмэгдэв. 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 3 дугаар сарын 26 хүртэлх хугацаанд Хятад дахь Ковид-19 цар тахалтай холбоотой цахим орчинд үг хэлсэн 897 [Хятадын интернэт хэрэглэгчийн](#) хэргийг Хятадын хүний эрхийг хамгаалагч ТББ (CHRD) баримтжуулсан байна. Цар тахлын хямралыг сурвалжилсан арав орчим сэтгүүлч мөн цахим орчинд сэтгэгдэл бичигчид, түүнчлэн сэтгүүлч **Жан Жан** нарыг 2020 онд баривчлан хорьжээ.



© Chen Qiushi / YouTube Screenshot

АНХААРЛЫН ТӨВД



© Zhang Zhan / YouTube Screenshot

Ухань хотоос бэлтгэсэн мэдээний төлөө дөрвөн жилийн хорих ял

Ухань хотод өвчин дэгдэх үеэс эхлэн нийгмийн сүлжээнд Ковид-19 цар тахлын тухай мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэсний төлөө дөрвөн жилийн хорих ялаар шийтгүүлсэн сэтгүүлч, RSF байгууллагын 2021 оны Хэвлэлийн эрх чөлөөний шагналын эзэн Жан Жан гэм буруугүй болохоо нотлохын тулд амь насанд нь аюул учруулж мэдэх хагас өлсгөлөн зарлажээ.

38 настай, сэтгүүлч эмэгтэй, Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллагын 2021 оны Хэвлэлийн эрх чөлөөний шагналын эзэн **Жан Жанд** гуравхан цаг үргэлжилсэн шүүх хурлын дараа буюу 2020 оны 12 дугаар сарын 28-нд Шанхай хотын шүүхээс “хэрүүл зарга үүсгэсэн, маргаан дэгдээсэн” хэргээр дөрвөн жилийн хорих ял ногдуулсан байна. Ковид-19 цар тахал дөнгөж дэгдсэн үед Ухань хот руу сурвалжилга хийхээр аюул, эрсдэлийг үл хайхран 2020 оны 2 дугаар сард очсон зоримог сэтгүүлчдийн нэг нь тэр эмэгтэй байсан юм. 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Ухань хотноо түүнийг алга болсон тухай мэдээлэхээс өмнө Жан Жан 100 гаруй видео сурвалжилга бэлтгэж, өөрийн [YouTube сувар](#), WeChat болон Твиттерт байршуулсан байна. Алга болсны маргааш нь эрх баригчид түүнийг Шангайд хоригдож байгаа тухай зарласан.

Ял шийтгэл ногдуулах ёстойг батлах баримт нотолгоо үзүүлээгүй хэрнээ, прокурор түүнийг буруутган яллаж “маш их хэмжээний хуурамч мэдээлэл цахим орчинд түгээсэн” гэсэн ялын дүгнэлт үйлдсэн. Буруутан гэдгээ хүлээн зөвшөөрөхөөс үргэлж татгалзсаар ирсэн сэтгүүлч эмэгтэй давж заалдах шатны шүүхээс татгалзсан ба түүний өмгөөлөгч нарын нэг нь баривчлах байрны ажилтнууд давж заалдвал илүү хүнд шийтгэл ногдуулахаас өөр үр дүнд хүрэхгүй гэдгийг түүнд ойлгуулсан гэж мэдэгдсэн.

Шударга шүүхийг үгүйсгэсэн энэ үйлдлийг эсэргүүцэн Жан хагас өлсгөлөн зарласан хэдий ч түүнийг хамрын нүхээр нь хүчээр хооллосон байна. Сэтгүүлч эмэгтэйн биеийн байдал эрс муудсан ба: 2021 оны 10 дугаар сарын сүүлээр 1.77 см өндөр эмэгтэйн [жин 40 кг хүрэхтэй үгүйтэй болж](#), бусдын тусламжгүйгээр хөдөлж, толгойгоо өндийлгөж чадахгүйд хүрсэн. 2021 оны 8 дугаар сард тэрээр 11 хоног эмнэлэгт хэвтэн эмчлүүлээд гарсан.



Хятадад цагдан хянах, мөрдөн тагнах нь дээд цэгтээ хүрсэн. © Aly Song / Reuters

Хятадын интернэт орчин мөрдөн тагналт дор

2021 оны 11 дүгээр сарын 2-нд Хятадын нийгмийн сүлжээ Сина Вейбо-д олон улсын теннисний тэмцээний аварга **Пэн Шуай** Намын Улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн асан, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч асан Жан Гаолиг хүчингийн хэрэгт буруутгасан. 30 хүрэхгүй минутын дараа тамирчин эмэгтэйн тавьсан бичлэг, түүнтэй холбоотой хүмүүсийн бичсэн сэтгэгдлийг устгаж, тамирчны бүртгэл хаягийг хайлтын системээс арилгасан. Дээд түвшний удирдагчдыг эрсдэлд оруулах дуулианыг хав дарахын тулд бүх аргаар цагдан хянахыг оролддог. Пэн Шуайг өөрийг нь гэрийн хорионд оруулсан тухай дараа нь мэдээлжээ.

Хоёр сарын өмнө Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын тэргүүлэгч Evergrande компанийн санхүүгийн эргэлзээтэй үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээлэл, компанийн асар их өрийг төлөхөд учрах хүндрэл нь Хятадын эдийн засгийг ганхуулах эхлэл болох тухай WeChat мессежийн аппликейшн дээр гарсан эрэн сурвалжлах *Цайсинь* сэтгүүлийн нийтлэлийг цагдан хянасан. 2021 оны эхээр, интернэт хэрэглэгчдэд хориотой сэдвүүдээр богино хугацаанд хэлэлцүүлгийн бүлэг үүсгэх боломж олгодог шифрлэгдсэн мессежийн програм болох Сигнал болон аудио аппликейшн Клубхаусыг мөн Хятадын интернэт орчинд ашиглахыг хориглосон.

Хориглосон түлхүүр үгс

Өөр улсаас холбогдох боломжтой, виртуал хувийн сүлжээг (VPN) ашиглахгүйгээр Google системд хайлт хийх, эсвэл гадаадын мессежийн систем, тухайлбал, WhatsApp ашиглах нь Хятадад бараг боломжгүй зүйл. Дэлхийн бусад улсаас Хятадын интернэт орчинг тусгаарлахын тулд Бээжингийн дэглэмийн хөгжүүлсэн техникийн систем “Их галт хана” (The Great Firewall)-г байнга сайжруулах болсноор олон тооны цахим хуудсын IP хаягийг хаагаад зогсохгүй, мөн хориглосон түлхүүр үгс орсон агуулгыг цагдан хянах боломжтой болсон. Хятадын цагдан хяналтын эсрэг тэмцдэг GreatFire ТББ-ын тооцоолсноор, дэлхийн хүмүүсийн зочлох дуртай [1000 цахим хуудсын 160-д](#) тус улсад байхдаа хандах боломжгүй аж.

Гэхдээ, 2000 оны дундуур, тэр үед хурдацтай хөгжиж байсан Хятадын интернэт орчинд эрх чөлөөний салхи сэвэлзэж, интернэт хэрэглэгчид өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тэр тусмаа улс төрийн дээд ангийнханд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлэх боломжтой байсан юм. 2010 оноос хойш Хятадын дэглэм газар авах болсон энэ явдлын аюулыг ойлгож, хяналтаа чангалсан. 2014 онд дэглэмийн зүгээс интернэт орчинг хянах хоточ нохдын бүлэг байгуулж, улмаар энэ нь 2018 онд Цахим орчны асуудал эрхэлсэн төв комисс болж, Ши Жиньпин өөрөө тэргүүлэх болсон. Хятадын цахим орчны захиргааны гүйцэтгэгч байгууллага Хятадын нэг тэрбум интернэт хэрэглэгчдийн цахим орчин дахь үйл ажиллагааг чандлан хянахаар өргөн хүрээтэй арга хэмжээ авах болов.

"Цэвэрлэх" аян

Америкийн Фрийдом Хаус ТББ-ын мэдээлснээр, 2019 онд 11000 гаруй Хятадын цахим хуудас, 737 мянган нийгмийн сүлжээний бүртгэл хаяг ба хэлэлцүүлгийн чат групп хаагдсан байна. Одоогийн байдлаар, ялангуяа, гадаад харилцаа ба батлан хамгаалах, эдийн засаг, улс төрийн сэдвээр засгийн газрын зөвшөөрөлтэй цахим хуудсууд болон тодорхой, цөөн хэдэн бүртгэлтэй албан хаягаас мэдээ мэдээлэл түгээх зөвшөөрөл өгсөн. 2021 оны 2 дугаар сард “эмзэг” гэсэн тодотголтой нийгмийн асуудлаас холхон байхыг блог хөтлөгчдөд хүртэл анхааруулсан захирамж гарчээ.

Цагдан хяналт нь тухайн цаг үеийн нөхцөлд дасан зохицох замаар сэдэвчилсэн “цэвэрлэх” аян өрнүүлдэг болохыг Хонконгийн Их сургуулийн Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн төвийн удирдсан "WeChatSCOPE" төслийн хүрээнд харуулсан байна. 2021 оны 6 дугаар сард Хятадын засгийн газар биткойныг хориглох шийдвэрээ зарласны дараа Байду хайлтын систем болон Сина Вейбо нийгмийн сүлжээ нь гурван томоохон криптовалюта биржийн хайлтын үр дүнг хаасан. Үүний дараа сард WeChat Хятад даяар оюутнуудын удирддаг бэлгийн цөөнхийн бүлгийн (LGBTQ) олон арван бүртгэл хаягийг интернэт дэх мэдээллийн дүрмийг зөрчсөн гэсэн үндэслэлээр устгасан.

Хоёр сая гаруй хүн цагдан хянах албанд ажилладаг

Хятадын интернэт орчинг хянах цагдан хяналтын албанд ажиллаж буй хүмүүсийн тоо тодорхойгүй байдаг ч, 2013 онд албан ёсны эх сурвалжийн мэдээлснээр, уг алба [хоёр сая ажилтантай](#) байсан ба тэр цагаас хойш тоо нь мэдэгдэхүйц нэмэгдсэн. 2021 оны 8 дугаар сард, Вэйбо нийгмийн сүлжээний цагдан хянагчид сард хамгийн цөөн нь 500 удаа цагдан хяналтын мэдээлэл өгөх төлөвлөгөөтэй ба үүнээс 90 хувь нь баримт нотолгоотой байх ёстой, эс бөгөөс тэд өөрсдөө ажилгүй болдог нь илчлэгдсэн юм.

Хятадын зах зээлд хөлөө олж, тэсэж үлдэхийн тулд гадаадын компаниуд ч мөн цагдан хяналтын дүрэмд захирагдахаас өөр аргагүй байдалд ордог. 2020 оны 8 дугаар сард Apple компанийн Хятадад бүртгэлтэй App Store-оос олон улсад нээлттэй 3487 аппликейшн, түүн дотроо Хятадын 148 цахим хуудас [алга болсон](#) байв. Microsoft группийн охин компани LinkedIn цахим хуудас цагдан хяналт улам бүр нэмэгдэх болсноос Хятад дахь үйлчилгээгээ 2021 оны 10 дугаар сард зогсоож буйгаа мэдэгдсэн. Үүнээс сарын дараа, Америкийн Yahoo! портал Хятадыг орхин гарч буйгаа зарласан ба цахим цагдан хяналтын улмаас ихэнх үйлчилгээ нь аль хэдийн хаагдаад байсан болохоор үнэн хэрэгтэй, бэлгэдлийн чанартай зүйл болсон юм.

"Нам чиний алхам бүрийг хянаж байгаа"

Хүмүүсийн яриаг тандан чагнах нь мөн төсөөлөхийн аргагүй хэмжээнд хүрсэн. 2014 оноос интернэт хэрэглэгчдийг цахим мэдээллийн үйлчилгээ авах ба мессежний аппликейшн ашиглахдаа зөвхөн өөрийн жинхэнэ нэр хаягаар бүртгүүлэхийг шаардсан журам үйлчилж эхэлсэн. Нийгмийн сүлжээнд байршуулсан бичлэг, харилцан ярианы агуулга, шифрлэж нууцлаагүй байдлаар эрх баригчид шууд үзэх боломжтой, мөн эдгээр бүх мэдээллийг эрүүгийн гэмт хэрэгт нотлох баримт болгон ашиглаж болно.

BBC-ийн Хятад дахь сурвалжлагч **Стефен МакДонелл** 2019 онд өөрийн WeChat бүртгэл хаяг дээрээ Тяньаньмэний хядлагын 30 жилийн ойг тохиолдуулан Хонконгд болж буй жагсаалын зургийг нийтэлсний дараа түүнд анхааруулж хэлэлгүйгээр бүртгэл хаягийг нь хаасан. Өөрийн бүртгэл хаягт нэвтрэхийн тулд сэтгүүлч нүүр царай, дуу хоолой таниулах аппликейшн хүчээр уншуулахад хүрчээ.

Онолын хувьд, хэрэглэгчдийг цахим луйвраас хамгаалах зорилготой бүтээсэн залилангийн эсрэг гар утасны програмыг Хятадын эрх баригчид өөрчлөн, эдийн засгийн мэдээллийн агентлаг Bloomberg гэх мэт "онц аюултай" цахим хуудаст зочилсон интернэт хэрэглэгчдийг илрүүлэхэд ашигладаг болсныг 2021 оны 9 дүгээр сарын 14-нд *Financial Times* сонин мөн илчилсэн юм.

Троллуудын арми

Коммунист намын суртал ухуулгын алба мөн үзэл сурталын тэмтрүүлээ нийгмийн сүлжээнд шургуулаад амжсан. Нийгмийн сүлжээнд жирийн иргэний дүрээр албан ёсны мэдээг сурталчлах үүрэгтэй, бичсэн мессеж бүртээ 50 юаний (7 евроцент) хөлс авдаг [суртал ухуулагчдын арми](#) буюу "50 центийн арми" гэгч

Бээжингийн дэглэм дор ажилладаг. 2017 онд Америкийн Улс төрийн шинжлэх ухааны тойм сэтгүүлд нийтлэгдсэн [судалгаагаар](#) дэглэмийн эдгээр алба хаагчид нийгмийн сүлжээнд жилдээ 448 сая бичлэг хийдэг гэсэн тооцоо гарчээ.


Хятадын үндсэрхэг үзэл гаарахын хэрээр, дэглэмийг дэмжигч сайн дурынхны арми Хятад болон бусад орны нийгмийн сүлжээнд хүчээ авчээ. Залуу бүсгүйчүүд голдуу ажилладаг гэж тооцдог учраас тэднийг "бяцхан ягаанууд" хэмээн хочилдог ба эдгээр түрэмгий хөлсний бичээч нар хамаг хүчээрээ дэглэмийг шүүмжлэлээс хамгаалж байна. Эдгээр интернэт троллуудын хэтэрхий эмзэглэдэг занг шоглосон ["Эмзэгхэн" дууг](#) 2021 оны 10 дугаар сард Малайзийн дуучин **Намэвээ**, Австралийн дуучин **Кимберли Чэн** нар дуулсныг Хятадад хориглосны дараа уг дууны бичлэг Тайвань болон Хонконгд YouTube суваг дээр хамгийн олон удаа үзсэн дүрс бичлэгийн жагсаалтыг тэргүүлжээ.



Хятадын үндэстний үзэлт интернэт троллуудыг зөөлхөн шоглосон "Эмзэгхэн" нэртэй дууг эх газрын Хятадад хориглосний дараа уг бичлэг Тайвань болон Хонконгд хамгийн олон удаа үзсэн дүрс бичлэгийн жагсаалтыг тэргүүлжээ.

© Namewe / YouTube Screenshot

АНХААРЛЫН ТӨВД



© Martin Bureau / AFP

Хэлмэгдүүлэхэд зориулагдсан технологийн дэвшил

Иргэдийн санал сэтгэгдлийг хянах, мэдээллийн урсгалыг хатуу хяналтдаа байлгахын тулд Бээжин хамгийн сүүлийн үеийн технологийн ололтод дулдуйдан, намын соргог хараа тусах зайнаас гадуур аливаа нэгэн яриа хэлцэл явагдах ёсгүй гэсэн үл гүйцэлдэх төслийг нийгэмд зориулан бүтээж байна.

Хятадын Шэньян Лигун их сургууль болон Хятадын Шинжлэх ухааны академийн судлаачид интернэт хэрэглэгчдийн хэлний өөрчлөлтөд дасан зохицох, өөрөө бие даан судлах чадвартай цагдан хяналтын хиймэл оюун ухааны бичвэрийг зохион бүтээснээ 2021 оны 4 дүгээр сард бахархалтайгаар зарласан юм. Бээжингийн дэглэм сүүлийн жилүүдэд гэмт хэрэгтэй тэмцэх нэрийдлээр улам түрэмгий технологи зохион бүтээх болсон ба тухайлбал, хяналтын дүрс бичлэгийн Скай Нет програмын оронд, олон нийтийг мөрдөн тагнах зориулалттай Хурц нүд програмыг Хятадын бүх нутаг дэвсгэрт царай таних камераар тоноглон 2015 онд суурилуулсан.

Олон улсын өрсөлдөөнийг үгүй хийх замаар дотоодын үйлдвэрлэгчийг бүхий л талаар дэмжсэн дэглэмийн бодлогын үр дүнд, мэдээлэл, технологийн үндэсний томоохон компаниуд, тухайлбал, хайлтын Байду програм, цахим худалдааны хүчирхэг том Алибаба, интернэт болон харилцаа холбооны аварга том Tencent, Huawei ба ZTE төрөн гарсан юм. Дэмжлэгийн хариуд, эдгээр компаниуд цагдан хяналт, суртал ухуулга, мөрдөн тагнах програм бүтээхэд дэглэмд хүчээр туслахаас өөр аргагүй болсон.

Бээжингийн дэглэм хэрцгий хэлмэгдүүлэлтийн талбар болсон Шинжааны өөртөө засах бүс нутгийг Хятадын Hikvision, SenseTime, CloudWalk, and iFlytek зэрэг гарааны компаниудтай хамтран нүүр царай таних системийг хөгжүүлэх туршилтын талбар болгон ашиглаж ирсэн. Тус бүс нутгийн оршин суугчид сүмд хандив өргөх, чатын бүлэгтээ Коран судраас иш татан бичих, эсвэл хүлээн авах, лалын шашны номын цахим хувилбар суулгах тогтоосон хэв журмаас "гажууд" зан авир гаргаж байгаа эсэхийг утасны хэрэглээг тандан хянах замаар илрүүлдэг аппликейшныг утсандаа хүчээр суулгахад хүрсэн.

Ийм төрлийн технологийг ашиглан, иргэдийн зан төлвөөс хамааран эрхийг нь зохицуулдаг нийгэм дэх "нэр хүнд"-ийн системийг бүрдүүлэх ба гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааг урьдчилан таамаглах боломжтой "ухаалаг цагдааг" ойрын ирээдүйд бүтээнэ гэж Хятадын дэглэм найдаж байна. Эрэн сурвалжлах албаны сэтгүүлч **Лю Ху**, 2017 оны эхээр, өмнө нь сэтгүүлчийн үүрэгт ажлаа гүйцэтгэж байхдаа [баривчлагдан шийтгүүлд байсны](#) төлөө туршилтын журмаар хэрэгжүүлж байгаа нийгмийн нэр хүндийн системийн хар жагсаалтад багтсаныг харахад, нийгэмд иймэрхүү төрлийн төсөл хэрэгжүүлнэ гэхээр хүн бүхэнд айдас төрж, шинжлэх ухаан-уран зөгнөлийн "Цөөнхийн өчил" ба телевизийн олон ангит "Хар толь" кинон дээр дүрслэгддэг дарангуйллын өмнө бөхийсэн айдас хүйдсийн ертөнц санагдана.

Хятадын мөрдөн тагналтын технологи гадагшаа экспортод гарч эхэлсэн нь улам илүүтэй санаа зовоох зүйл болов. 2021 оны 8 дугаар сард Top 10 VPN цахим хуудас Хятадын Huawei компанийн технологиор интернэт орчноо удирдаж буй 68 засгийн газрын 17 нь мэдээллийн технологийн зарим сайт руу нэвтрэх эрхийг хааж байгааг [илчлэн бичсэн](#). Мөн энэ үед, Литва улсын Үндэсний кибер аюулгүй байдлын төвөөс Хятадад цагдан хориглосон 1300 гаруй түлхүүр үгс агуулсан програм хангамжтай Хятадын Huawei, Xiaomi, and OnePlus брэндийн ухаалаг гар утасны хэрэглээнээс [татгалзахыг олон нийтэд хандан уриалсан](#).



Нийгмийн сүлжээнд өргөн тархсан энэ шогчилсон дүрс нь хувийн нууцтай холбоотой асуудалд, Хятадын дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнд хэр итгэж болохыг харуулсан хэрэг юм.

© Facebook

Эсэргүүцэх олон арга бий

2021 оны 2 дугаар сарын 8-ны долоо хоногт "Ху Ши Жинь фэн клуб" нэртэй чат хэлэлцүүлгийн бүлэг Клубхаусын аудио чатын өрөөний аппликейшн дээр маш хүчтэй тархсан. Чат хэлэлцүүлгийн бүлэг хэт үндсэрхэг үзэлтэй төрийн хэвлэл болох *Глобал Таймс* сонины ерөнхий эрхлэгчийн 2021 оны 1 дүгээр сарын 14-нд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх багцын талаар АНУ-ын Ерөнхийлөгч Жон Байден мэдэгдэлтэй холбогдуулан хэлсэн "Хэрвээ манай улс хүн бүрд мөнгө тараах гэж байгаа бол энэ нь хэнд ч мөнгө өгөхгүй гэсэн үг" хэмээн үгийг иш татан тохуурхахыг зорьжээ. Интернэт хэрэглэгч нэгэн "Хэрэв хаа сайгүй хана байгаа бол хаана ч хана байхгүй гэсэн үг" хэмээн ёжилсон нь Хятадын интернэтийн цагдан хяналт болон Байден өмнөх ерөнхийлөгч Дональд Трампын босгосон цагаачлалын эсрэг ханыг егөөдсөн хэрэг юм.


Коммунист намын шүүлтүүрээр ариутган цэвэрлэсэн үг хэллэгтэй үргэлж тулгардаг Хятадын олон нийт хууртахаа больж, илүү үнэн бодит мэдээлэл олж авах, цагдан хяналтад өртөөгүй мэдээлэл солилцох шинэ арга шийдэл байнга эрэлхийлж байдаг. "Хятад хүмүүс ХМХ-ийн бүх сувгаар өргөн хүрээтэй түгээсэн мэдээ мэдээлэл байсан ч эрх баригчдын хэлсэн үгэнд итгэхгүй байх нь олонтоо. Бодит үнэнийг мэдээлсэн байсан ч тэд эрх баригчдад итгэдэггүй" гэдгийг иргэний нийгмийн GreatFire байгууллагыг үндэслэгчид гэрчилсэн юм.

"Голын хавч" ба "усны тоолуур"

Маргаантай сэдэвтэй холбоотой түлхүүр үгсийг цагдан хяналтын алба хаамагц, интернэт хэрэглэгчид ур, ухаанаа уралдуулан, ахиад шинийг бодож олдог. Ихэд түгээмэл арга бол хориглосон үгийг дуудлага адил мөртөө өөр өөр ханзаар бичдэг ижил нэрээр солих явдал юм. 2018 оны 1 дүгээр сард "цагаан будаа-туулай" (хятадаар *mǐ-tu*) хэмээх нэр томьёо нь Вэйбо нийгмийн сүлжээнд гарч ирсэн ба энэ нь түр хугацаанд эрх баригчдын цагдан хяналтад өртөн хаагдсан #MeToo-тэй яг адилхан дуудагддаг. БНХАУ-ын дарга асан Ху Жинтаогийн санаачилсан эвт ёсны нийгэм байгуулах санаачилгыг илэрхийлсэн "эвт ёс" (хятадаар *héxié*) гэдэг үгийн ижил нэр "голын хавч" нэр томьёо нь цахим орчинд цагдан хяналтад өртөж байгааг илэрхийлдэг байна.

Үүний бусад хувилбар нь латин хэлний үгсийн [эхний үсгийг](#) ашиглах, жишээлбэл, засгийн газрын "ZF" (хятадаар *zhèngfǔ*), эсвэл Хятадын цагдаа нар усан хангамжийн ажилтны дүрд хувирч, барилга байгууламж дотор анхаарал татахгүйг хичээн эргэлддэг зуршилтай холбоотой, "хэн нэгэн гэрт зочлох" гэсэн утгыг илэрхийлсэн "усны тоолуур шалгах" гэх мэт нэр томьёог ашигладаг.

2020 оны эхээр Хятадад Ковид-19 цар тахал эрчимтэй дэгдсэн үед интернэт хэрэглэгчид цагдан хяналт, мөрдлөгөөс эмээлгүй намын байр суурийг шүүмжлэх, үнэнийг илчлэнгээ өөд болсон шүгэл үлээгч **Ли Вэнлян** эмчийн дурсгалыг хүндэтгэхийн тулд овсгоо самбаатай байдлаа харуулж чадсан юм. Зарим нэг хүмүүс "Би чадахгүй" ба "Би ойлгохгүй байна" гэсэн бичээстэй нүүрний хаалт зүүсэн өөрийн зургаа



Цагдан хяналтад өртөхгүйн тулд, хятадын иргэд, өөрийн хэлний дуудлага ижил үг ашигладаг ба тухайлбал, трэнд болсон сэдэв #MeToo-тэй хятад хэлний "будаа-туулай" гэсэн үг яг адилхан дуудагддаг.

© Marcella Cheng / The Conversation

байршуулсан нь “хуурамч мэдээлэл түгээхээ” зогсоох, нөхцөл байдлыг ойлгохыг шаардсан цагдаагийн газрын шаардлагад Ли эмчийн өгсөн хариулыг эш татсан хэрэг байлаа. Ардын өдрийн сонин харьяаны Рэн Ву сэтгүүлийн эмч нарт ногдуулсан цагдан хяналтыг шүүмжилсэн нийтлэлийг сонин мухлаг бүрээс хураахад, түүнийг хадгалж үлдэхийн тулд дэлгэц дээрх зураг, англи хэл дээрх орчуулга, шифрээр бичсэн хувилбар, брайл тэмдэгт, тэр ч байтугай дүрс тэмдэгтээр хадгалжээ.

Нээлттэй эх сурвалж ба блокчейн

Дэлхийн өнцөг булан бүрд байгаа инженер, хөгжүүлэгч нарт код болон програм хангамжийн төслүүд дээр хамтран ажиллах боломжийг олгодог хамгийн том нээлттэй эх сурвалж бүхий цахим хуудас Github платформ нь мөн цагдан хяналтад өртсөн агуулгыг хамгаалан байршуулах, хоргодох газар болжээ. 2019 онд мэргэжлийн салбарт оршиж буй хөдөлмөрийн хүнд нөхцлийг илрүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн "996.ICU" төслийн хүрээнд Хятадын технологийн олон компанийн ажилчид цагдан хяналтад өртөөгүй хэдэн мянган мэдүүлэг цуглуулсан байна. Шинэ технологийн салбарыг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай энэ платформд нэвтрэх эрхийг хаах нь Засгийн газарт хүндрэлтэй асуудал юм.

Хятадын интернэт хэрэглэгчид түүнчлэн [блокчейн](#) технологийг ашиглах болсон ба өгөгдлийг олон тооны компьютерт зэрэг түгээдэг болохоор устгах боломжгүй байдаг. Бээжингийн их сургууль бэлгийн хүчирхийллийг хэрхэн нуун дарагдуулахыг оролдсон тухай 2018 оны 4 дүгээр сард хүний эрхийн тэмцэгч **Сюэ Инийн** бичсэн дэлгэрэнгүй захидлыг нэрээ нууцалсан байдлаар Ethereum блокчэйн платформ дээр байршуулсан. Тухайн оны 7 дугаар сард, нярай хүүхдүүдэд ямар ч үр дүнгүй вакцин хийснийг илрүүлсэн мөрдөн байцаалтын явцыг мэдээлэхдээ уг технологийг ашигласан.

Муур-ба-хулгана тоглоом

Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд үндэсний компаниудад виртуал хувийн сүлжээ (VPN) ашиглах замаар “Их галт хана” хоригийг алгасан цагдан хяналтад байгаа цахим хуудсуудтай холбогдох боломжийг Хятадад өнөө хэр нь зөвшөөрсөөр байгаа юм. Гэвч, ялангуяа 2017 онд интернэт орчинг “цэвэрлэх” [аяны](#) хүрээнд энэ асуудал сөхөгдсөнөөс Хятадын төрийн зөвлөл аажмаар хувийн сүлжээ ашиглахыг хязгаарлах болж, GreenVPN ба Haibe VPN зэрэг нэр хүндтэй томоохон үйлчилгээ эрхлэгч компаниуд үйл ажиллагаагаа зогсоож, хаагдсан. Apple өөрийн бүх VPN (виртуал хувийн сүлжээ) аппликейшнийг Хятад дахь App Store-оос [арилгасан](#).

Хятадад бүтээгдэхүүнээ сурталчлах, төлбөрт үйлчилгээ үзүүлэх боломжгүй гадаадын VPN үйлчилгээ эрхлэгчид өрсөлдөөний гадна үлддэг. Харин Хятадын үндэсний VPN эзэмшигчид нь эрх баригчидтай [мэдээллээ хуваалцдаг](#) байх өндөр магадлалтай. “Хууль бус сувгаар олон улсын интернэтэд нэвтэрсэн” гэсэн үндэслэлээр VPN-г бусдад худалдаж, ашигласан нэлээд хэдэн хүнд ял ногдуулаад байгаа ба үүнд нэг хүн таван жил хагас шоронд хоригдож, мөн 500,000 Хятад юанийн (бараг 80,000 ам.доллар) торгууль төлөх шийтгэл хүлээсэн байна. Мөн түүнчлэн, 2019 онд Хятадын Цахим орчны захиргаа блокчейн платформд нэрээ нууцлахыг хориглосон [журам](#) гаргасан. Эцэст нь, мөн Хятадын эрх баригчид цагдан хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой Github платформын ижил төстэй хувилбарыг хөгжүүлэхээр чармайж байна.

Муурнаас нуугдах хулгана аятай энэ тоглоом интернэт хэрэглэгчдийг шинэ шийдэл олохын тулд байнга төсөөлөн бодох чадвараа дайчлахад хүргэдэг. Тэдний бүтээлч сэтгэхүй сайшаалтай хэдий ч 2021 оны 3 дугаар сард Эмнести Интернэшнл ТББ-ын хэвлүүлсэн [нийтлэлд](#) нэгэн хүн “гайхалтай цэцэн ухаан, уран төсөөллийг зөвхөн бусдад дуу хоолойгоо хүргэхээр тэмцэхэд бус бүтээлч ажилд ухаалгаар зарцуулах боломжтой байсан бол” хэмээн гайхшран бичсэн.

ЯРИЛЦЛАГА

“Хятадын цагдан хяналт удахгүй машин сургалт (machine learning) ашиглана”

Хятад дахь цагдан хяналтын эсрэг шийдэл олохоор ажилладаг GreatFire ТББ нь Германы өргөн нэвтрүүлгийн Дойче Велле байгууллагын 2013 оны “Цахим орчны шилдэг идэвхтэн” шагнал хүртсэн. Уг байгууллагын нэрээ нууцлахыг хүссэн үүсгэн байгуулагчид Хил хязгааргүй сурвалжлагчдын асуултад хариулахыг зөвшөөрсөн юм.

GreatFire хэрхэн ажлаа эхэлсэн, байгууллагаа хэрхэн үүсгэн байгуулсан бэ?

Хятадын интернэт орчинд цагдан хяналтыг халах, ил тод байдлыг хангах зорилгоор GreatFire байгууллага 2011 онд эхэлсэн. Хятадад хаагдсан гадаадын цахим хуудсуудын жагсаалт гаргах манай эхний төсөл анх Analyzer (Дүн шинжээч) гэсэн нэртэй байснаа [дараа нь Blocky (Хаагдсан нь) гэж өөрчлөн нэрлэсэн]. Гэвч Хятадын платформууд цагдан хяналтад улам бүр өртөх болсноос хойш Вейбо платформын блогд зориулсан жижигрүүлсэн FreeWeibo нэртэй цагдан хяналтаас ангид хувилбарыг байршуулахаар шийдсэн. Манай платформ Вейбогоос илүү нэр хүндтэй болсон тул бид WeChat мессежийн аппликейшн ашиглан төслөө давтан хэрэгжүүлсэн. Дараа нь бид AppleCensorship.com цахим хуудас бүтээсэн ба энэ нь Хятадын эрх баригчдын шахалтаар Apple өөрийн дэлхий даяарх App Stores-ыг хэрхэн цагдан хянаж байгаад дүн шинжилгээ хийдэг. “Одоогоор бид есөн төсөл амжилттай хэрэгжүүлж байгаа ба энэ нь нэг талаар Хятад дахь цагдан хяналтын албаны хөгжил мөн үүний эсрэг тэмцлийг харуулж байна”.

Байгуулагдсан цагаас хойш ямар саад бэрхшээлтэй нүүр тулгарав?

“Бид зөвхөн Хятадын ард иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Үндсэн хуулиар олгогдсон эрхийн төлөө тэмцэж байгаа атал Хятадын Коммунист намын албан ёсны хэвлэл мэдээлэл биднийг “Хятадын эсрэг үзэлтэн” гэж яаравчлан буруутгасан”. Хятадын эрх баригчид зөвхөн буруутгаад зогсохгүй, 2015 онд бидний эсрэг асар том кибер халдлага үйлдсэн ч азаар удалгүй сэргэж чадсан. “Бидэнд тулгарч буй хамгийн том саад бол тэмцлийн арга хэрэгслээ Хятадын олон нийтэд сурталчлахад бэрхшээлтэй байдаг. Бид Хятадад хараахан хаагдаагүй гадаадын томоохон цахим хуудсуудаар дамжуулан мэдээлэл түгээх, мөн иргэдийн дунд ам дамжсан мэдээлэл тараадаг ч хангалтгүй хэвээр байгаа”.

Цаашид ямар сорилт хүлээж байгаа, та нар үүнд ямар бэлтгэлтэй байна вэ?


“Хятадад нөхцөл байдал улам дордож болзошгүй, Хятадын эрх баригчид уламжлалт цагдан хяналтаа хэрэгжүүлэхээс гадна илүү хурдан, үр дүнтэй ажиллахын тулд машин сургалтыг удахгүй мөрдөн тагнахад ашиглана. Үүнээс гадна Apple зэрэг том компаниуд муу үлгэр дуурайлал үзүүлэх болсон. Зөвхөн Хятадад түгээсэн мэдээлэлд цагдан хяналт тавиад зогсохгүй Хятадын эрх баригчдын нэрийн өмнөөс дэлхийн даяар цагдан хяналт явуулдаг. Бусад компаниуд хэрвээ Apple-ийн жишгийг дагавал Хятадын эрх баригчдын цагдан хянахыг хүсдэг мэдээллийг олон нийт олж авахад бүр илүү хүндрэлтэй болно. Ийм учраас бид технологийн талын үзүүлэлтээ сайжруулахаар чармайн ажиллаж, мөн эрх баригчдын шаарддаг цагдан хяналтын дарамт шахалтаас татгалзахыг сонирхогч талын компаниуд, мэдээж Хятадын компаниудын хувьцаа эзэмшигчид, хэрэглэгчид болон ажиллагсдад ойлгуулахыг тасралтгүй чармайж байна.



GREATFIRE.ORG

© GreatFire.org

Сэтгүүл зүйг хориглосон НИЙГМИЙН алсын хараа



Хятадын телевизийн дэлхийн сүлжээний (CGTN) сэтгүүлч "Ухань хотод болж чухам юу болж буй" тухай хэрхэн мэдээлэхийг тайлбарлахдаа - Хилийн чанадад өрнөсөн шүүмжлэлийг сөргүүлэн" Хятад орон хүний эрхийн талаар өөрийн гэсэн ойлголттой" хэмээн оршин суугчаас авсан ярилцлагыг үзүүлэх жишээтэй.

© Capture d'écran BRNA / CCTV

Бээжингийн зохиосон хэвлэл мэдээллийн загварыг амжилттай гадагш гаргав

Зүүн Африк, Европ, Ойрх Дорнод гээд дэлхийн хүн амын гуравны хоёр орчим хувийг эзэлдэг 100 гаруй улстай Хятад улсыг холбох зам тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг тусгасан асар том хүсэл зорилго агуулсан төслийг 2013 онд Хятад улс эхлүүлсэн ба уг "Бүс ба зам" санаачилгын хүрээнд 2019 оны 4 дүгээр сард Хятад улс "Бүс ба зам" санаачилгын талаар албан ёсны "мэдээлэл солилцох" зорилготой Ардын өдрийн сонины (*People's Daily*) тэргүүлдэг хэвлэл мэдээллийн сүлжээ (BRNN) байгуулж, дэлхийн өнцөг булан бүрээс гишүүн элсүүлсэн.

Хэвлэл мэдээллийн сүлжээ (BRNN) ийм төрлийн анхны байгуулага биш. 2016 онд Хятадын Олон улсын телевизийн корпорац (CITVC) 133 байгууллагаас бүрдсэн кино, телевиз, ХМХ-ийн нэгдэл болох "Бүс ба зам" хэвлэл мэдээллийн нийгэмлэг (BRNA)-ийг санаачлан байгуулжээ. CCTV Видео ньюс агентлаг (CCTV+)-ээр удирдуулсан "Бүс ба зам" мэдээллийн холбоо (BRNA) 2017 онд байгуулагдаж, түүнд 42 улс орон, бүс нутгийн 74 хэвлэл мэдээллийн байгууллага, гол төлөв өргөн нэвтрүүлгийн мэдээний агентлагууд гишүүнээр элссэн.

"Ярилцах сэдвээ" тулгах нь

Хятад улс дээрх байгууллагаар дамжуулан дэлхийн өнцөг булан бүрээс ХМХ-ийг татан оролцуулж, төслөө олон улсад сурталчлахыг эрмэлздэг. "Бүс ба зам" хэвлэл мэдээллийн нийгэмлэгийн хамтарсан нэвтрүүлэг, олон улсын хамтын бүтээл төслийн хүрээнд хийгдсэн *Торгоны зам дахин нээгдсэн нь*, *Хятадын тэврэлт*, *Хятадын мега төслүүд* зэрэг телевизийн нэвтрүүлгийг 20 гаруй орны 80 орчим ХМХ дэлхийн 30 гаруй хэлээр нэвтрүүлсэн.

Синьхуа агентлагийн охин компани Хятадын эдийн засгийн мэдээллийн алба 2017 оны 12 дугаар сард Европын 20 орчим судалгааны төв, хэвлэл мэдээллийн байгууллагатай "Бүс ба зам" санаачилга (BRI)-ын талаар хөрөнгө оруулагчдад чиглэсэн санхүүгийн мэргэшсэн мэдээллээр хангах гэрээнд гарын үсэг зурсан. Үүнд, Германы *Дойче Пресс агентлаг*, Италийн *Класс Едитори*, Бельгийн *Ле Соир*, Их Британийн *Метро*, Испанийн *Санхүүгийн ертөнц*, мөн *Нээлттэй харилцаа холбоо*, Сербийн *Танжуг Ньюс*, Грекийн *Афин ньюс агентлаг* оролцсон байна.

Хэвлэл мэдээллийн BRNA болон BRNN сүлжээ нь намдаа суртал ухуулга хийх, төрийн санхүүжилттэй ХМХ-ээр ажлын арга барилаа сурталчлах боломж олгосон сургалт зохион байгуулдаг. BRNA-ийн мэдэгдэлд дурдсанаар, оролцогчид Хятадын технологийн салбарын ололтыг гайхширч, Ковид-19-тэй тэмцсэн Хятадын "үр дүнтэй хүчин чармайлт"-ыг сайшаан магтжээ.

Мөн сэтгүүлчдэд зориулсан тусгай курс, төсөлтэй холбоотой хөндөн ярих сэдвийг заадаг. Өөрөөр хэлбэл, төсөлд хамрагдсан орнуудын сэтгүүлчдэд Хятад улсад суртал ухуулгад ашигладаг "ижил хэлээр" ярихыг зөвлөдөг "Донфан тэтгэлэгт хөтөлбөр"-ийг санаачилсан. Хятад дахь 26 хоногийн сургалтыг төрийн өмчит *China Daily*, Хятадын хоёр их сургууль, China Eastern Airlines групп ивээн тэтгэдэг.

Түрэмгийгээр урин дуудах нь

Бээжин "Бүс ба зам" санаачилгаас гадна сэтгүүлчдэд өөрийн бодлогыг ойлгуулах, хэрвээ бололцоо нь бүрдвэл, бусдад нөлөө бүхий тэднээр дамжуулан дэлхийн бусад улсад гайхагдахын тулд хөгжиж буй орнуудын сэтгүүлчдэд таатай сэтгэгдэл төрүүлэхээр ихээхэн хүчин чармайлт гаргадаг. Гадаадын сэтгүүлчдийн айлчлал Бээжинд ашиг тустай байдаг бас нэг зүйл нь: Сэтгүүлчид айлчлалаа хэрхэн дүрслэн ярих нь Хятадын төрийн ХМХ-д итгэл үнэмшил төрүүлэх, улмаар Коммунист намын бодлогыг дэлхий нийт сайшааж байгаа мэт сэтгэгдэл жирийн иргэдэд төрүүлдэг.

Дээрх солилцооны хөтөлбөрийг газарзүйн байршлаар бүс нутаг бүрийн хэвлэлийн төв зохион байгуулдаг ба Хятадын Гадаад хэргийн яам, Олон нийтийн дипломат харилцааны нийгэмлэг хамтран удирддаг. Эдгээрээс хамгийн нэр хүндтэй нь тухайн орны ХМХ-ээр таатай мэдээлэл гаргах зорилготой Энэтхэгийн хойг, Зүүн өмнөд Ази, Африкийн сэтгүүлчдийг арван сарын турш бүх зардлыг нь дааж урьдаг сургалт юм.

Сэтгүүлчдийг урин аялуулах нь цохон тэмдэглээд, гоочлоод байх зүйл биш. Олон орны засгийн газар улсынхаа нэр хүндийг дээшлүүлэхийн тулд үүнийг зохион байгуулдаг. Гэвч Хятадын тухайд авч үзвэл, айлчлах сэтгүүлчдийг удирдлага нь сонгодоггүй харин намын зөвшөөрлөөр Хятадын элчин сайдын яам сонгох ба хариуд нь ямар нэг зүйл шаарддаг. Уригдах нөхцөл ойлгомжтой: сэтгүүлчид "Хятадын талаар сайхан түүх ярих", тэр ч байтугай дарангуйллын дэглэмийг даян дэлхийд энхийг сахиулагч, ардчилсан орон хэмээн магтан дуулах хэрэгтэй.

Гэвч уригдсан зочдод оршин суух хугацаандаа чөлөөтэй аялахыг зөвшөөрдөггүй. 2019 оны 1 дүгээр сарын 10-наас эхлэн Шинжааны өөртөө засах оронд айлчилсан Турк, Египет, Афганистан, Пакистан, Бангладеш зэрэг лалын шашинтай орнуудын сэтгүүлчдэд лалын шашинт нэг сая Уйгур иргэд Шинжаан дахь дахин хүмүүжүүлэх лагерьт хоригдож байгаа эсэхийг чөлөөтэй шалгах боломж олгоогүй. Үүний оронд эрх баригчид тэднийг "терроризмтой тэмцэх" тэмцлийг харуулсан үзэсгэлэн дээр аваачсан.



BRICS-ийн орнуудын хэвлэл мэдээллийн жил бүрийн дээд хэмжээний уулзалт Хятадын хувьд барууны хэвлэл мэдээллийн давамгайллыг буруушаах мөн "тэнцвэргүй байдлыг" засахыг уриалах боломж юм.

© Greg Baker / AFP

“Хятадад үйлдвэрлэв” хэвлэл мэдээллийн арга хэмжээ

Хятад улс сургалтаас гадна, өөрийн үзэмжээр олон улсын арга хэмжээ зохион байгуулан хэвлэл мэдээллийн талаарх дарангуйллын үзэл бодлоо сурталчлахыг эрмэлзэж байна. Хятад 2009 онд Дэлхийн хэвлэл мэдээллийн дээд хэмжээний чуулга уулзалт зохион байгуулсан ба – үнэн хэрэгтээ нэр нь авцалдаагүй – уг арга хэмжээг Хятадын төрийн мэдээллийн Синьхуа агентлаг эхнээс нь зохион байгуулж бүхэлд нь удирдан санхүүжүүлсэн. Анхны дээд хэмжээний уулзалтад олон улсын нэр хүндтэй түншүүд: Ньюс Корп (АНУ), Ассошиэйтэд Пресс (АНУ), Томсон Ройтерс (Их Британи), ИТАР-ТАСС (Орос), Киодо Ньюс (Япон), ВВС (Их Британи), Turner (АНУ) болон Google News Corp. (АНУ) оролцсон.

“21 дүгээр зууны сорилттой тулгарах нь” сэдэвт хоёр дахь дээд хэмжээний уулзалт 2012 онд Москва хотноо зохиогдсон ба 102 орны нийт 213 олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон. Катарын Аль Жазира телевиз “Мэдээ мэдээлэл, мэдээллийн байгууллагын ирээдүй” нэртэй 120 байгууллага, 100 ХМХ оролцсон гурав дахь удаагийн дээд хэмжээний уулзалтыг Катарын нийслэл Доха хотноо 2016 оны 3 дугаар сард зохион байгуулав. Дарангуйлал тогтсон, хэвлэлийн эрх чөлөөг үгүйсгэдэг орнуудад зохиогдсон эдгээр дээд хэмжээний уулзалтууд нь Хятад улсын хувьд “ээрэг мэдээлэл” түгээх, “дэлхийн хэвлэл мэдээллийн шинэ дэг журам”-ын үзэл баримтлалаа сурталчлах боломж олгосон. Эдгээр нь мөн Синьхуа агентлаг хууль ёсны мэт харагдахад тусалж, бодитой, чанартай сэтгүүл зүй явуулдаг гэсэн нэр хүнд олгож, улмаар удирдагчид нь олон улсын хэвлэл мэдээллийнхэнтэй ижил нөхцөлөөр мэтгэлцэх боломж нээж өгсөн.

Хятад улс 2016 оноос хойш BRICS хэмээх хөгжиж буй эдийн засагтай таван орны (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) мэдээ мэдээллийн байгууллагад зориулан BRICS-ийн Хэвлэл мэдээллийн дээд хэмжээний уулзалтыг жил бүр зохион байгуулсаар ирсэн. Эдгээр орнууд Хятадад бусад дөрвөн орныхоо хэвлэл мэдээллийн зохицуулалт, практикт нөлөөлөх, улмаар барууны хэвлэл мэдээллийн давамгайллыг буруушаах, “тэнцвэргүй байдлыг” засч залруулахыг уриалах боломж, бололцоо бүрдүүлж өгсөн.

АНХААРЛЫН ТӨВД

Хятадын төрийн мэдлийн хэвлэл мэдээлэл дэлхий даяар тархсан нь

Сүүлийн арваад жилийн турш Хятад улс олон улсын тавцанд гарахын тулд ХМХ хөгжүүлэхэд асар их хөрөнгө оруулалт хийсэн нь амжилтад хүрч: Төрийн мэдлийн төв агентлаг CGTN бэлтгэсэн телевизийн нэвтрүүлэг 160 гаруй оронд гардаг ба Хятадын олон улсын радио 44 хэлээр нэвтрүүлгээ хүргэдэг.

Орчин үеийн тайз засал, мэргэжлийн сэтгэл татам хэв маяг, өө сэвгүй үг хэллэгтэй (CGTN) Африк ТВ-ийн төв Кени улсын Найроби хотод байрладаг ба CNN Интернэшнлтэй дүйцэхүйц, төгс төгөлдөр дүр төрх бүрдүүлдэг. CGTN Africa нь Африкийн үнэн нүүр царайг дэлхий дахинд таниулах зорилготой гэж мэдэгддэг ч үнэн хэрэгтээ Хятадын төрийн мэдэлд бүрэн харьяалагдаж, Африк дахь Хятадын нэр хүндийг бэхжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулдаг.

2018 оны 12 дугаар сард CGTN орон нутгийн хөлсний 90 ажилтнаас бүрдсэн ижил төстэй үйл ажиллагаа явуулах офисоо Лондонд нээсэн. Энэ салбар нь Африк, Америк тивд 2012 онд нэгэн зэрэг нээсэн Найроби ба Вашингтон дахь салбартай адил Европын үзэгчдэд тусгайлан зориулсан хөтөлбөр бэлтгэн явуулах болно. CGTN Европ нь Хятадын Медиа Групп, албан бусаар “Хятадын дуу хоолой” хэмээн нэрлэгддэг, төрийн мэдлийн CCTV ба CGTN, мөн Хятадын үндэсний радио ба Хятадын олон улсын радио зэргийг нэг дээвэр дор багтаасан байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх болно.

Сүүлийн арван жилийн хугацаанд дэлхий даяар Хятадын олон улсын хэвлэл мэдээллийн оролцоо эрс нэмэгдсэн. Хятадын Глобал телевизийн сүлжээ одоо зургаан сувагтай - 24 цагийн мэдээллийн таван суваг (англи, франц, араб, орос, хятад хэлээр), англи хэл дээрх баримтат киноны сувагтай. CGTN өнөөгийн байдлаар Лондон, Вашингтон, Найроби дахь нэвтрүүлэг бэлтгэх төв зэрэг нийт 70 салбарт 10,000 орчим ажилтантай бөгөөд 160 гаруй улс орон, бүс нутагт нэвтрүүлгээ цацдаг. Хятадын Олон улсын радио (CRI) ч мөн адил дэлхийн хэмжээнд хүрч чадсан ба гадаад орнуудын 70 гаруй станцаас 44 хэлээр дамжуулж, дээд амжилт тогтоосон юм.

Хятадын хэвлэмэл ХМХ ч бас өнөө цагт том лигийн тоглогчид болжээ. Америк, Европ, Ази тивийн уншигчдад зориулсан тусгай дугаар гаргадаг англи хэл дээрх *China Daily* сонин өдөр бүр 900,000 хувиар (*Нью-Йорк Таймс* сонины хэвлэлтийн бараг тал хувьд хүрсэн) хэвлэгддэг, нийтдээ 45 сая уншигчтай гэж мэдэгдсэн. *Глобал Таймс* сонины англи хэл дээрх дугаар 2009 оноос хойш “зөвхөн” 100,000 хувь хэвлэгддэг болсон ч арван хэл дээр гардаг цахим хуудаст өдөртөө 15 сая орчим хүн зочилдог хэмээн мэдэгджээ. Хэмнэлтийн зарчмаар ажилладаг гэж инээдэм наргианд өртөж байсан төрийн мэдлийн Синьхуа агентлаг хүртэл гадаадад мэдэгдэхүйц өсөлтөд хүрсэн.

© CGTN Africa / YouTube Screenshot





Хятадын Коммунист нам үзэл суртал шингээсэн түүхээ хилийн чанадад, түүн дотроо засгийн газрыг дэмжигч шар хэвлэл нь "том ах Ши Жиньпин" талархаж буй Сербид ч түгээхээр чармайж байна.

© Andrej Isakovic / AFP

“Хятадын түүх”-ийг албадан тулгасан нь

Шинжааны өөртөө засах бүс нутгийн хэлмэгдүүлэлтийн тухай шүүмжлэл дэлхий даяар өрнөх энэ үед Бээжингийн дэглэм, ялангуяа нийгмийн сүлжээний үйл явцад нөлөөлөхийн тулд [нөөц бололцоогоо дайчилж](#) байна. 2021 оны 6 дугаар сард Нью Йорк Таймс, ProPublica сонины хамтарсан [эрэн сурвалжилгаар](#) Коммунист нам суртал ухуулгын аян зохион байгуулж, Шинжааны өөртөө засах оронд уйгур хүмүүс хэрхэн амьдарч байгааг гоёчлон харуулсан зохиол, найруулгын хувьд адил төстэй 3000 гаруй видео бичлэг YouTube суваг дээр байршуулсныг илчилсэн.

Бээжингийн дэглэмийн хувьд, суртал шингээсэн [түүхээ](#) сурталчлахаар чармайх, Ши Жиньпин даргын дэвшүүлсэн “Хятадын түүхийг сайн талаас нь харуулах” ажлын нэг хэсэг нь юм. Төрийн мэдлийн Синьхуа агентлагийн тэргүүн асан Ли Конжун 2013 онд өдөр тутмын Ардын өдрийн сонин (*People's Daily*)-д өгсөн ярилцлагадаа “дэлхийд барууны ХМХ-үүд давамгайлсан хэвээр” байгааг онцлоод, тэнцвэргүй байдлыг өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилж, “дэлхийн хэвлэл мэдээллийн шинэ дэг журам”-ыг дэмжихийг уриалсан.

Дотроос нь эзлэх “Троян морь” стратеги

Олон улсын тавцанд илүү өргөн хүрээнд ажиллахын тулд Бээжин гадаадын орнуудын ХМХ-ийг стратегийн хувьд худалдан авах далд санаархалтай томоохон хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Худалдан авах бодлогыг Хятадын Коммунист намын салбар болох Нэгдсэн фронтын ажлын алба зохицуулж, гадны орны ХМХ-рүү шилжүүлэх санхүүгийн шилжүүлгийг хянадаг. 2018 оны 4 дүгээр сард *Bloomberg News* агентлагийн мэдээлснээр, Хятад улс сүүлийн арваад жилд Европын орнуудын ХМХ-ийн хувьцааг худалдан авахад 3,3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь тус тивд оруулсан нийт хөрөнгө оруулалтын 1 орчим хувийг эзэлж байна.

Мөн тус дэглэм олон улсын томоохон сонинуудад редакцын тусгай нэмэлт дугаар хэвлүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна. *Wall Street Journal* (АНУ), *Daily Telegraph* (Их Британи), *Le Figaro* (Франц), *Handelsblatt* (Герман), *Российская газета* (Орос), *Мейничи Шимбун* (Япон) зэрэг сонины уншигчид амтархан уншдаг сонины үнэгүй дагалт болох тогтмол хугацаанд хэвлэгддэг Хятадын судалгааны төв хэвлэл “China Watch”-ын нэмэлт материалуудад аажмаар дасаж, хэвшил болжээ. *China Daily* сонины эрхлэн гаргадаг, уншихад таатай эдгээр нэмэлт материалууд дээдсийн зочны өрөөнд Бээжингийн дэглэм суртал ухуулгаа явуулах боломж олгодог “Троян морь” юм. Хятад улс тухайн улсын өдөр тутмын тэргүүлэгч сонинд ийм нэмэлт оруулга хийсний төлөө ойролцоогоор 250,000 ам.доллар төлдөг тул эдгээр ХМХ санхүүгийн ашиг орлогоороо Бээжингийн дарамтад өртөх өндөр магадлалтайг харуулж байна.

Хилийн чанадад ажиллаж амьдарч буй Хятадуудыг хянах нь

Бээжингийн нөлөө хилийн чанад дахь хятад хэлээр гардаг ХМХ-д хүчтэй тусах болжээ. Үнэхээр, тал хувь нь Ази тивд амьдардаг, хилийн чанадад орших 50 сая хятад хүмүүс Хятадын коммунист дэглэмийг ихээхэн шүүмжилдэг байсан. 1989 оны 6 дугаар сарын 4-ний Тяньаньмэний хядлагын дараа хилийн чанад дахь хятадуудын ХМХ-ээр эгдүүцлийн давалгаа үүсэхэд, Бээжингийн дүр төрхөө хянах стратегид тэд саад болохыг ойлгож, эдгээр ХМХ нэг нэгээр нь худалдаж авах, тэнд өөрийн нөлөөний шинэ цэгүүдийг хөгжүүлэхээр шийдсэн.

Нэгэн цагт хятадын коммунистуудыг эрс шүүмжилдэг байсан, дэлхийн хамгийн том хятад хотхон оршдог (9 сая хүн амтай) Тайландад хятад хэл дээрх ХМХ одоо мөн өнгө аясаа өөрчилжээ. 1950 онд үүсгэн байгуулагдсан, *Син Сян Ер Пао* “*Sing Sian Yer Pao*” нь өнөөгийн байдлаар Тайландын Хятад хэл дээрх тэргүүлэгч өдөр тутмын хэвлэл ба тэд хэвлэлтээ уламжлалт хятад үсгээс одоо Хятадад ашиглах болсон хялбаршуулсан үсэг рүү шилжүүлж, Хятадын Нанфан медиа групптэй хамтран ажиллах болсон.

Хятад хэлээрээ ярьдаг, цагаачдын эхний давалгааныхны дунд түгээмэл байдаг Хятадын мессежийн WeChat програм нь хятад хэлээр мэдээ түгээх гол сувгийн нэг болохыг Британийн *The Economist* сонины 2021 оны 9 дүгээр сарын 23-нд нийтэлсэн тайланд дурджээ. АНУ-д Колумбын Их Сургуулийн Сэтгүүл зүйн сургуулиас 2018 оны 4 дүгээр сард хийсэн [судалгаагаар](#) хэт барууны үзлийг сурталчилсан хуурамч мэдээлэл, хуйвалдааны онолын номлол WeChat-ын америк аппликейшн дээр тархсан байсныг илрүүлсэн. Хилийн чанадад олон улсын хэрэглэгчдийн яриа, намын зүгээс эмзэгт тооцсон сэдвийн агуулгыг [мөрдөн мөшгөдөг](#) ч үнэндээ бол хилийн дээс доторхоос арай бага байдаг.

Хятад хэв маягийн “хурц хүч”

Ардчилсан орнууд дахь мэдээллийн эрх чөлөөний эсрэг дарамт шахалтын бас нэгэн эх үүсвэр нь хилийн чанад дахь Хятадын дипломат төлөөлөгчийн газрууд юм. Хятадын зарим Элчин сайд нар аливаа нэг сонины нийтлэл “1.4 тэрбум Хятад иргэдийн сэтгэлийг шархлуулсан” гэж үзсэн үедээ огтхон ч санаа зовсон шинжгүй сэтгүүлчдийг гутаан доромжилж, хариу өгөхийг шаардах нь түгээмэл тохиолддог болсон. Цагдан хяналтын улмаас Хятадын ихэнх интернэт хэрэглэгчид гадаадын ХМХ-д нэвтрэх боломжгүй тул Хятадын иргэдийн сэтгэл хөдлөлийн талаарх иймэрхүү мэдэгдэл нь үнэндээ дэгсдүүлсэн хэтрүүлэг юм.

2021 оны 10 дугаар сарын 25-нд Хятадын ЭСЯ-ны цахим хуудсанд нийтлэгдсэн нэгэн шинэ нийтлэлд, сэтгүүлчид, ХМХ рүү давшлан дайрдаг зангаараа олноо алдаршсан Парист суугаа Элчин сайд Лу Шай, өдөр тутмын *Le Figaro* сонины Ази дахь сурвалжлагч **Себастьян Фаллеттид** хандан 10 дугаар сарын 19-нд нийтлэгдсэн түүний нийтлэл “худал хуурмагийг хөөргөн дэвэргэсэн”, “бодит байдлыг илт мушгин гуйвуулсан” ба Тайваний засгийн газарт “илт найрсаг хандсан” байсан гэх зэргээр дайрчээ. Элчин сайд мөн *Le Monde* сэтгүүлийн Бээжин дэх сурвалжлагч **Фредерик Леметрийг** гутааж, түүний нийтлэл ихэвчлэн зохиомол байдаг гээд Францын ХМХ-д хандан “ёс зүйг дээдлэн сахиж”, “бодит баримтад хүндэтгэлтэй хандах”-ыг ичгүүр сонжуургүйгээр уриалсан байна.

Чонон дайчин хэмээх дипломат ажиллагаа

Мөн Элчин сайдын яамд нь Хятад дахь цагдан хяналтад аюул учруулах арга хэмжээг цуцлахыг шаардан дарамталдаг. Германы Дуйсбург-Эссений их сургуулийн Күнзийн хүрээлэнд 2021 оны 10 дугаар сарын 27-нд зохиогдох байсан Германы хоёр сэтгүүлч **Стефан Ауст, Адриан Гейгес** нарын бичсэн Ши Жиньпиний тухай номын нээлт [лекцийг](#) Хятадаас Дюссельдорф хотод суугаа Ерөнхий консул өөрийн биеэр ирж цуцлахыг шаардсан. Ромд суугаа Хятадын Элчин сайдын яам 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 2 дугаар сарын хооронд Брешиа хотод (Италийн хойд хэсэг) болж буй Хятад гаралтай Австралийн шог зураач **Бадиуцаогийн** үзэсгэлэнг цуцлахыг оролдсон. Хотын захиргаа Хятадын дарамт шахалтад бууж өгөлгүй арга хэмжээг үргэлжлүүлэхээр шийдсэн.

Хятадад хориглосон хэдий ч хятадын дипломатууд 2019 онд Хонконгд ардчиллын төлөөх эсэргүүцлийн жагсаал эхэлснээс хойш гадаад орнуудын нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцох болсон ба: Ассошиэйтед пресс болон АНУ-ын Цахим шүүх эмнэлгийн судалгааны лаборатори, Атлант Зөвлөлийн хамтарсан [судалгаагаар](#) Хятадын дипломатуудын данс энэ хугацаанд Твиттерт гурав дахин, Facebook дээр хоёр дахин нэмэгдсэн байна. Гадаад иргэдийн шүүмжлэлд дайрч давшилсан, бүр доромжилсон хариу өгдөг энэ хандлага өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд үүнийг гадаадын “өөдгүй залуусыг” гол баатар нь ялдаг эх оронч Хятадын тулаант кинотой зүйрлэн “чонон-дайчин дипломат ажиллагаа” гэж нэрлэх болсон.

Хуурамч мэдээллийн аян

Гадаад орнуудын нийгмийн сүлжээг ашиглах шинэ хандлага нь Хятадуудад хуурамч мэдээлэл өргөн хүрээнд түгээх боломж олгосон. Хэдийгээр Тайвань ба хятад үндэстэн их бага хэмжээгээр оршин суудаг улс орнуудыг гол байгаа болгон онилж байсан ч 2020 онд дэлхий нийт Ковид-19 цар тахалтай тэмцэж эхэлсэн үед Хятад хуурамч мэдээллийн аянаа дэлхий даяар өрнүүлсэн. Давтан түгээх болсон хуурамч мэдээллийн эх сурвалжид дурдсанаар, энэ вирус нь АНУ-ын цэргийнхэн Мэрилэнд мужийн Форт Детрик дэх лабораторид бүтээсэн био зэвсэг бөгөөд 2019 оны 10 дугаар сард Ухань хотод болсон Дэлхийн цэргийн наадмын үеэр танилцуулсан гэж мэдэгджээ.

2020 оны 3 дугаар сарын 11-нд Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Жао Лижиан Ковид-19 цар тахал Америкаас гаралтай болохыг нотолсон хэд хэдэн жиргээ нийтэлжээ. Өмнө дурдсан Ассошиэйтед пресс болон АНУ-ын Цахим шүүх эмнэлгийн судалгааны лабораторийн хамтарсан судалгаагаар Жао-гийн жиргээг дараагийн зургаан долоо хоногийн турш дэлхийн дор хаяж 54 хэлээр 100000 удаа эш татжээ. Ингэхдээ, хуурамч, халдлагад өртсөн данснуудыг автоматаар ашигласныг кибер аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг Графика фирм "спам илгээх" гэж нэрлэсэн нь Хятадын хуурамч мэдээллийг ихэсгэхэд тусалсан.

Ийнхүү харилцан тусалсан явдалд Орос, Иран, Филиппин зэрэг орнууд шүүмжлэлтэй хандаагүй ч улс төрчид энэ мэдэгдлийг өлгөн авч хэлэлцэх үед, Япон, Европын Холбоо зэрэг бүс нутгийн байгууллагууд ба бусад улс орнууд хуурамч мэдээллийн эх сурвалж нь Хятад улс хэмээн цохон тэмдэглэж байв. 2020 оны 6 дугаар сард Твиттер 170,000 орчим хятад хүмүүсийн бүртгэл хаягийг Бээжингийн төрийн суртал ухуулгын аянтай холбоотой болохыг олж тогтоон, устгасан тухай зарласан.

Троллууд ба цахим нөлөөлөгчид

"Бяцхан ягаанууд" гэгдэх Хятадыг шүүмжилсэн бүхэн рүү дайрдаг, үндсэрхэг үзэлтэй сайн дурын троллууд гадаадын нийгмийн сүлжээнд ч үйл ажиллагаа явуулдаг. Тэдний цахим хүчирхийллийн анхны томоохон аяны нэг нь 2016 оны 1 дүгээр сард Цай Ин Вэнийг Тайваний ерөнхийлөгчөөр сонгогдох үед болж, Хятадын олон интернэт хэрэглэгчид шинээр сонгогдсон ерөнхийлөгчийн фэйсбүүк хуудас дээр дайрч доромжилсон сэтгэгдэл, мемуүүдийг нийтэлсэн байна.

Суртал ухуулгаа түгээхийн тулд Хятадын дэглэм мөн цахим орчинд нөлөөлөгчдөд ханддаг. Глобал таймс сонинд бичсэнээр, Египетэд оршин суудаг, цахим орчинд нөлөө бүхий Файха Ван гэгч нь Хятадын Медиа Групптэй хамтран ажиллаж, Шинжааны өөртөө засах оронд явуулж буй Төв засгийн газрын бодлогыг хамгаалахын тулд намаас гаргасан хэлэлцүүлгийн сэдэв ба хуурамч мэдээллийг ашигладаг. 2020 онд гадаадын бусад влог хөтлөгчид, тэр дундаа Британийн цагаач иргэд Барри Жонс, Жейсон Лайтфут, Ли, Оли Барретт нар Шинжааны өөртөө засах орон дахь Бээжингийн бодлого, Хятад улс Ковид-19 цар тахалтай "сайн тэмцэж" байгааг хамгаалах зорилгоор YouTube суваг дээр видео бичлэг байршуулж эхэлсэн. Өөрсдийгөө "Хятадад элэгтэй хүмүүс" гэж тодорхойлсон эдгээр влог хөтлөгчид барууны ХМХ-ийг "Хятад улсын тогтвортой байдлыг бусниулахыг оролдсон" хэмээн буруутгасан.



Хятадыг дэмжигч, Британийн влог хөтлөгч Жейсон Лайтфут барууны ХМХ-ээр бичиж байгаа Шинжааны өөртөө засах оронд болж буй хэлмэгдүүлэлт "худал хуурмаг зүйл" гэж зарлав.

© CGTN / YouTube Screenshot

АНХААРЛЫН ТӨВД

Бээжин санаачилсан ч Хятадад хориглосон TikTok

Дэлхий даяар тэрбум хэрэглэгчтэй болсон хэдий ч Хятадад хориглон хаасан видео хуваалцагч Хятадын TikTok програмыг Бээжингийн дэглэмийн цагдан хяналт, мөрдөн тагнах ажиллагааны нэг хэмээн сэжиглэдэг.

Хятадын ByteDance компанийн 2017 онд эхлүүлсэн богино хэмжээний дүрс бичлэг хуваалцах чиглэлээр мэргэшсэн TikTok нийгмийн сүлжээ нь дэлхий даяар асар их алдаршиж, 2021 оны 9 дүгээр сар гэхэд сард хоёр тэрбум гаруй татан авалт, нэг тэрбум идэвхтэй хэрэглэгчдийг дагуулж чадсан. Дэлхийн 150 гаруй орны хэрэглэгчид зочлох боломжтой, 18-25 насны залууст зориулсан уг програм харин Хятадын залууст л хаалттай. Тэд тус орны нутаг дэвсгэрт ашиглах боломжтой түүнтэй төстэй Доуин платформ ашиглахаас өөр аргагүйд хүрсэн.

2021 оны 6 дугаар сарын 25-нд CNBC телевизийн сувгаар дамжуулсан эрэн сурвалжилгын явцад уг платформын хэрэглэгчдийн мэдээлэл АНУ, Сингапурт хадгалагддаг хэдий ч Хятад дахь толгой компани мэдээллийг үзэх боломжтойг програмын нууцлалын заалтуудаар нотлогдож байгааг харуулсан. ByteDance компани Хятадын хуулийн тогтолцоонд захирагддаг тул, хэдийгээр мэдээлэл гаргаж өгөх хүсэлт хэзээ ч хүлээж аваагүй гэж мэдэгдэж байгаа ч, хятадын эрх баригчид шаардсан тохиолдолд гаргаж өгөхөөс өөр аргагүй болно.

2019 оны 9 дүгээр сард уг платформ Хонконг дахь ардчиллыг дэмжих жагсаалын тухай хэлэлцүүлгийг цагдан хянасан хэмээн буруутгагдаж байсан. Британийн *The Guardian* Тяньаньмэний хядлага, Түвдийн тусгаар тогтнол, Фалун Гун хөдөлгөөн зэрэг Бээжингийн дэглэмийн эмзэг гэж үздэг сэдэвтэй агуулгыг цагдан хянах удирдамж байдгийг илчилсэн. Сонинд гарсан мэдээллийн дагуу нийгмийн сүлжээний хэрэглэгчид дээрх удирдамж өөрчлөгдсөн, одоо илүү орон нутгийн байршилд түшиглэсэн хандлагатай болсныг мэдэгдсэн.

Мөн оны арваннэгдүгээр сард Афган гаралтай Америк өсвөр насны охин **Фероза Азиз** нүүр будалтын зааварчилгаа байршуулахдаа Хятад дахь Уйгур үндэстний цөөнхийг хэлмэгдүүлж байгааг шүүмжилж, дагагчдаа хандан энэ тухай мэдээлэл дамжуулахыг уриалсны дараа TikTok түүний бүртгэл хаягийг хаасан. Фероза Азизаас уучлал гуйж, алдаагаа хүлээн зөвшөөрөхийн өмнө платформ эхэндээ түүнийг терроризмтэй холбоотой агуулга байршуулж, дүрэм зөрчсөн гэж мэдэгдэж байв.

Хэрвээ уг аппликейшн АНУ-д худалдан авах хэрэглэгч олж чадахгүй бол, "үндэстний аюулгүй байдалд" эрсдэл учруулж болзошгүй гэж сэжиглэн АНУ-ын ерөнхийлөгч асан Доналд Трампын засаг захиргаа 2020 онд хориглохыг тушаасан. Хэдийгээр шинэ ерөнхийлөгч Жо Байден уг шийдвэрийг цуцалсан ч TikTok гэх мэт гадаадын програмуудад аюулгүй байдлын эрсдэлийг үнэлгээ хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ мэдэгдсэн.



© Olivier Douliery / AFP

Ардчилсан орнууд суртал ухуулгын эсрэг тэмцэл өрнүүлсэн нь

Ардчилсан орнуудад ХМХ нь хараат бус, олон ургальч байх, засгийн газрын хөндлөнгийн оролцоогүй нэвтрүүлгээ түгээх зарчмыг удирдлага болгон ажиллаж, өөрийн орны хэвлэл мэдээллийн талбарыг гадаадын ХМХ-д нээлттэй байлгадаг. Дарангуйлал тогтсон Хятад зэрэг орны засгийн газар, сэтгүүл зүйн гол үндсэн зарчмыг зөрчсөн, цагдан хянасан агуулгатай нэвтрүүлгээ түгээхийн тулд энэ системийг тогтмол ашигладаг нь харамсалтай хэрэг юм.

Чөлөөт сэтгүүл зүй хөгжсөн, нээлттэй, ардчилсан улс орнууд болон суртал ухуулгаа сэтгүүл зүй гэж тооцдог, мэдээллийг цагдан хянадаг, хаалттай, дарангуйллын дэглэмтэй орнуудын хоорондох тэгш бус байдал нь сэтгүүл зүйн мөн чанарыг өргөн хүрээнд алдагдуулж, эрх чөлөө, хараат бус байдал, олон ургальч үзэл шаарддаг сэтгүүл зүйн мэдээллийн бодит байдлыг үгүйсгэж байна. Ардчилсан оронтой өрсөлдөхөд, энэхүү тэгш бус байдал нь сэтгүүл зүйг жинхэнэ утгаар нь хөгжүүлэхгүй, улс орондоо цагдан хянах мөртөө суртал ухуулгаа хилийн чанадад түгээх дарангуйлагч дэглэмд давуу тал болдог.

Хууль бус үйлдлийг шийтгэх нь

Ардчилсан орнууд өөрсдийгөө хамгаалахын тулд өргөн нэвтрүүлгийн дүрмийг зөрчсөн тохиолдолд хориг арга хэмжээ авахыг хичээдэг. Тайваний хараат бус зохицуулах алба, Үндэсний харилцаа холбооны комисс (ҮХХК) 2020 оны 11 дүгээр сарын 18-нд сэтгүүл зүйн салбарын ёс зүйг хүндэтгэн сахих үүргээ удаа дараа зөрчсөн CTTV мэдээллийн сувгийн нэвтрүүлгийн лицензийг сунгахаас [татгалзсан](#). Хятадыг дэмжигч Want Want China Times Медиа группын эзэмшдэг уг сувагт 2014 оноос эхлэн удаа дараа сануулж, сэрэмжлүүлсэн ч үйл ажиллагаандаа дорвитой өөрчлөлт оруулаагүй.

2021 оны 2 дугаар сард Британийн хэвлэл мэдээллийн зохицуулах алба (Ofcom) [дээрхтэй ижил шалтгаанаар](#) CGTN сувгийн лицензийг цуцалсан боловч тус групп Францын Eutelsat хиймэл дагуулаас Европт нэвтрүүлгээ цацсаар байна.

Тэгш хандлагыг баталгаажуулах нь

Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллага (RSF) дээрх тохиолдлын дараа ардчилсан орнуудад хандан, ХМХ-ийн зах зээл дээр харьяалагдах улс орон, өргөн нэвтрүүлгийн дамжуулах суваг (хиймэл дагуулын, тоон гэх мэт) зэргээс үл хамааран бүх ХМХ ижил үүрэг, хариуцлага хүлээхэд [тэгш хандан, баталгаажуулахыг](#) уриалав. ХМХ нь шударга, хараат бус, мэдээллийн олон ургальч үзэл, хүний нэр төрийг хүндэтгэх тал дээр ижил үүрэг хариуцлага хүлээдэг ба эс бөгөөс өргөн нэвтрүүлэг хийх зөвшөөрөл өгөхөөс татгалзах, цуцлах хүртэл шийтгэл ногдуулдаг. Системийг үр дүнтэй ажиллуулахын тулд хиймэл дагуулын болон тоон сувгийн операторууд хариуцлага хүлээх ёстой ба дамжуулж буй сувгууд нь эдгээр хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах ёстой.

RSF мөн үзэл бодол, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нийтлэг зарчимд суурилсан, олон улсын харилцан үйлчлэлийн тогтолцоог бий болгохыг уриалсан ба энэ нь ардчилсан орнуудын дотоодын хэвлэл мэдээллийн орон зайг нээхэд цахим орон зайг харилцан нээх, хандахад саад бэрхшээл, цагдан хяналтгүй байх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг хүндэтгэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

АНХААРЛЫН ТӨВД

Ёс зүй зөрчсөн CGTN Их Британи дахь сувгийн зөвшөөрлөө алдав

Британийн харилцаа холбооны зохицуулах алба (Ofcom) Хятадын төрийн өмчит дуу, дүрс бичлэгийн CGTN групп дөрвөн удаа ёс зүйн зөрчил гаргасны дараа 2021 онд сувгийн зөвшөөрлийг цуцалсан ч тус групп Европын болон дэлхийн бусад орнуудад суртал ухуулгаа хийсээр байна.

Нэгдсэн Вант Улсын харилцаа холбооны албан ёсны зохицуулагч, Харилцаа холбооны алба (Ofcom) 2021 оны 2 дугаар сард Хятадын төрийн өмчит, дуу, дүрс бичлэгийн групп болох Хятадын Дэлхий нийтийн телевизийн сүлжээ (CGTN) Их Британи дахь нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг, түүний бэлтгэсэн нэвтрүүлэг "Хятадын Коммунист намын бүрэн хяналтад байдаг" гэсэн үндэслэлээр цуцалсан болохоо мэдэгдсэн. Мөн оны сүүлээр тус группт Ofcom дөрвөн удаа хориг тавьж "ноцтой, удаа дараагийн зөрчил" нь Ofcom-ын өргөн нэвтрүүлгийн дүрмийг зөрчсөн учраас 570,000 ам.доллартай тэнцэх мөнгөн торгууль ногдуулсан.

Өмнөх жилүүдэд буюу 2019 онд Хонконгийн эсэргүүцлийн жагсаалыг сурвалжлахдаа "шударга байх" зарчмыг зөрчсөн, 2013-2019 оны хооронд Шведийн хэвлэн нийтлэгч асан **Гуй Минхай**, сэтгүүлч асан **Петер Хамфри** болон Хонконгд суугаа Их Британийн консулын газрын ажилтан **Саймон Чэн** нарыг [албадан хэргээ хүлээхийг тулгасан](#) нэвтрүүлэг явуулсаныг "шударга бус", "хувийн нууцад халдсан" гэж тодорхойлон, Ofcom олон дараа ёс зүйн зөрчил гаргасанд CGTN-г буруутгасан. Үүний хариуд Бээжингийн дэглэм "Хятадын үндэсний ашиг сонирхолд халдсан" гэж үзэж буйгаа зарлан, [Их Британийн олон нийтийн BBC телевизийг Хятадад нэвтрүүлэхийг хориглосон](#) ч олон улсын телевизийн сувгийг зөвхөн олон улсын зочид буудал, гадаадын иргэдэд зориулсан барилгад үзэх зөвшөөрөлтэй тул энэ нь хязгаарлагдмал хүрээнд үйлчлэх төдий зүйл юм.

Европын Зөвлөлийн Хил хязгааргүй телевизийн тухай Европын конвенцийн дагуу Францын Өргөн нэвтрүүлгийн дээд зөвлөл (CSA) уг сувгийг "урьдчилан албан ёсны зөвшөөрөл авалгүй, чөлөөтэй нэвтрүүлж болно" гэж үзсэн тул CGTN Европт нэвтрүүлгээ үргэлжлүүлэн цацаж байна. Энэ мэдэгдлийн дараа Их Британийн шийдвэрийн дагуу CGTN-г хориглоод байсан Германы зохицуулах алба шийдвэрээ цуцлахад хүрсэн. Франц улсын шийдвэрийг далимдуулан CGTN Их Британид хүртэл нэвтрүүлгээ дахин цацах боломжтой болов.

Ардчилсан орнууд дахь Хятадын суртал ухуулгын эсрэг хууль ёсны тэмцэл дөнгөж эхэлж байна. ХХА-ны мэдэгдлээс хэдхэн хоногийн дараа албадан хэргээ хүлээсэн хохирогчид Eutelsat хиймэл дагуулын оператороос CGTN-ийн нэвтрүүлгийг зогсоохыг шаардаж, 2021 оны 3 дугаар сард CGTN телевизээр гарсан уйгур хүүхдийг албадан хэргээ хүлээхийг тулгасан нэвтрүүлгийн талаар тус сувгийн эсрэг 2021 оны 4 дүгээр сарын 5-нд Харилцаа холбооны алба ба түүний АНУ дахь түнш Холбооны харилцаа холбооны комисст шинэ гомдол гаргасан. Австралийн SBS телевизийн холбоо мөн 2021 оны 5 дугаар сард Аюулгүй байдлын хамгаалагчид (Safeguard Defenders) ТББ-аас албадан хэрэг хүлээлгэсэн нэвтрүүлгийн тухай гомдол хүлээн авсны дараа CGTN нэвтрүүлгийг зогсоох шийдвэр гаргасан.

© Safeguard Defenders



4

RSF-ИЙН УРИАЛГА, ЗӨВЛӨМЖ



- RSF нь Хятадын эрх баригчдад хандан, БНХАУ-ын Үндсэн хуульд заасанчлан хэвлэлийн эрх чөлөөг хүндэтгэж, баривчлагдсан бүх сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний хамгаалагчдыг суллахыг уриалж байна.
- RSF нь улс орнуудын засгийн газарт хандан, тэдний газар нутагт үйл ажиллагаа явуулж буй Хятадын ХМХ нь бусад ХМХ-тэй ижил дүрэм журамд захирагдах, Хятадын ХМХ-ийн тухайн орны олон нийтийн орон зайд нэвтрэх боломжийг Хятадын хэвлэл мэдээллийн зах зээл, цахим орон зайд саад тотгоргүй, цагдан хяналтгүй харилцан нэвтрэх нөхцөлтэйгээр нээхийг уриалж байна.
- RSF нь сэтгүүлчдэд хандан, Хятадын эрх баригчдын хяналтад өртөхгүйн тулд тандан хяналт хийх боломжтой програмыг татаж авахаас зайлсхийх, Хятадын суртал ухуулгад ашигладаг язгуур үгс, нэр томъёог мэдээлэлдээ санамсаргүй оруулахаас болгоомжлохыг зөвлөж байна.
- RSF нь ХМХ, хэвлэн нийтлэгчид, нийгмийн сүлжээнд хандан, мөрдөн тагналт мөн цагдан хяналтад өртөх, суртал ухуулгын нэвтрүүлэг хийхээс татгалзахын тулд редакцын хараат бус байдалд хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэх Хятадын дэглэмийг буруушааж, хэвлэлийн эрх чөлөөний эсрэг Бээжингийн халдлагыг эрэн сурвалжлахаа үргэлжлүүлэхийг зөвлөж байна.

Хятадын эрх баригчдад хандсан уриалга

- БНХАУ-ын Үндсэн хуулийн (37, 38, 39 дүгээр зүйл) “хууль бусаар баривчлах”-ыг хориглосон, хүний “нэр төр, алдар хүндийг” баталгаажуулсан, иргэдийн орон байрны “халдашгүй” гэж тунхагласан заалтын дагуу сэтгүүлчийн үүрэгт ажлаа гүйцэтгэж яваад хоригдсон мэргэжлийн болон мэргэжлийн бус сэтгүүлчдийг нэн даруй суллах, мөн чөлөөт мэдээ, мэдээлэл түгээсэн сэтгүүлчдийг хулгайлах, баривчлах, хорих, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах, мөшгөн хайх, сүрдүүлэн дарамтлахаа зогсоох.
- Хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг улс дотроо болон олон улсын хэмжээнд сахин хүндэтгэ.
- Үзэл бодол, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг 19 дүгээр зүйлдээ тусган баталгаажуулсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон батлах.
- БНХАУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд “үг хэлэх [болон] хэвлэн нийтлэх эрх чөлөөг” баталгаажуулсан заалтын дагуу төрийн мэдлийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлыг хангах.
- БНХАУ-ын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлээр хамгаалсан хятад иргэдийн захидал харилцааны эрх чөлөө болон хувийн нууцаа хамгаалах эрхийг бүдүүлгээр зөрчсөн цахим орчинд сэтгүүлчдийг цагдан хянадаг, мөшгөн танддаг тогтолцоог таслан зогсоох.
- Хятадад гадаадын хэвлэл мэдээллийн агуулгыг цагдан хянах, түгээхийг хориглодог үйлдлээ зогсоох.
- БНХАУ-д ажиллаж байгаа гадаадын сэтгүүлчдийн үйл ажиллагаанд саад учруулахгүй, тэдэнд хэвлэлийн магадлан итгэмжлэлийг нээлттэй, ил тод зарчмын дагуу олгохыг уриалж байна.

Засгийн газрууд, институциудад хандсан уриалга

- Дээр дурдсан зөвлөмжийг Хятадын эрх баригчдад уламжлах.
- Хилийн чанадад ажиллаж байгаа ХМХ, сэтгүүлчид, хэвлэн нийтлэгчид, шинжлэх ухааны ажилтнуудыг сүрдүүлэн дарамтлахаа зогсоохыг Хятадын эрх баригчдаас шаардах.
- Гуравдагч оронд ажиллаж байгаа Хятадын өргөн нэвтрүүлгийн байгууллагаас санхүүжилтийн эх үүсвэр, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, түүнчлэн зар сурталчилгааны талаар ил тод, бүрэн мэдээлэхийг шаардах.
- Харьяалагдах улс, өргөн нэвтрүүлгийн дамжуулах сувгаас үл хамааран дуу, дүрс бичлэгийн бүх ХМХ-д тэгш хандах, улмаар ардчилсан орнууд дахь ХМХ-г зохицуулах дүрэм журам нь тухайн орнуудад өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулж байгаа Хятадын дуу, дүрс бичлэгийн ХМХ (ялангуяа, хиймэл дагуулын телевиз)-д ижил үйлчилж, тэр тусмаа шударга, хараат бус, мэдээллийн олон ургальч үзлийг дээдлэх, хүний нэр төрийг хүндэтгэх тал дээр ижил үүрэг хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг баталгаажуулах.
- Хятад хэл дээр үйл ажиллагаа явуулдаг, ялангуяа Хятад иргэд олноор оршин суудаг орнууд дахь хараат бус ХМХ-ийг хөхиүлэн дэмжиж, дэмжлэг үзүүлэх.
- Хараат бус, олон ургальч сэтгүүл зүйн эх сурвалжаас мэдээлэл авах, хуурамч мэдээллийн аяныг таньж илрүүлэхэд туслах, хэвлэл мэдээллийн мөн чанарын талаар иргэдэд мэдлэг олгох үүднээс сургалтын хөтөлбөр боловсруулахыг уриалж байна.

Сэтгүүлчдэд өгөх зөвлөмж

- Өгөгдлийг хадгалах явцад Хятадын эрх баригчидын хандах боломжтой үйлчилгээ эрхлэгч компаниуд (тухайлбал, Хятадын iCloud) эс бөгөөс Хятадын засаг захиргааны хуулинд захирагддаг Хятадын компаниуд (тухайлбал, WeChat, Байду, ТiкТок гэх мэт) үүсгэн хөгжүүлсэн, үйл ажиллагааг нь удирддаг учраас Хятадын эрх баригчдын зүгээс цагдан хянах, мөрдөн тагнах эрсдэл дагуулдаг технологийн эх сурвалж ашиглахаас боломжийн хэрээр зайлсхийх.
- Хэрвээ эдгээр эх сурвалжийг зайлшгүй ашиглах шаардлагатай бол өдөр тутам ажилладаг орчноосоо гадуур тусгай зориулалтын компьютер эсвэл ухаалаг гар утаснаас холбогдохыг сануулж байна. Таны мэдээллийн эх сурвалж эсвэл танд өөрт чинь аюул учруулж болзошгүй нууц үг, мэдээллийг түр хугацаагаар ч болов бүү хадгал. Үйлчилгээ эрхлэгч оператор компанийн Хятад дахь үйлчилгээний компаниар дамжуулж буй өгөгдөл шифрлэсэн эсвэл шууд устгасан гэх мэдэгдэлд бүү итгэ. Хятадаас гаралтай эх сурвалжаа хамгаалахын тулд утасны дугаарын өгөгдөл хадгалах шаардлагагүй, хоёр талаасаа шууд харилцдаг, шифртэй мессенжер холбоо ашиглахыг (Threema гэх мэт) зөвлөж байна.
- Хятадын платформоор дамжуулан харилцах, нийтлэл байршуулахдаа залилан мэхлэлтэд өртөж болзошгүй тул техникийн өгөгдлөө хянахын зэрэгцээ олон улсын платформ дээр давхар байршуулахыг зөвлөж байна.
- Хятадад судлагаа хийхдээ, явахын өмнө, тохирох VPN, жишээ нь, компанийн эзэмшлийн VPN эсвэл найдвартай төлбөрт хувилбар суулгах хэрэгтэй. VPN сүлжээний хонгил нь блоклосон үйлчилгээнд нэвтрэх боломж олгож, цахим судалгааны явцад өгөгдлийн нууцлалыг тодорхой хүрээнд хамгаалах чадвартай. Гэхдээ, VPN нь үйлчилгээ эрхлэгч Хятадын платформ дээр харилцан солилцсон мэдээллийн агуулгыг хамгаалж чадахгүй. Цахим аюулгүй байдлын мэргэжилтэнтэй уулзаж, ганцаарчилсан зөвлөгөө авахыг зөвлөж байна.
- Сэтгүүлч, сурвалжлагчид оршин суугаа орныхоо Хятад гаралтай ХМХ -ийн өнөөгийн байдал, хөгжил, ялангуяа хэвлэн нийтлэл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд анхаарал хандуулахыг зөвлөж байна. Орон нутгийн ХМХ-д Хятадтай холбоотой редакцын бодлогод гарсан аливаа өөрчлөлтийг RSF-д мэдэгдэнэ үү.
- Мэдээ, сурвалжилга бэлтгэх явцадаа болон өөрийн орны ХМХ-ээр олж харсан хүчирхийллийн аливаа хэлбэрийг (дарамт шахалт, заналхийлэл, мөрдлөг, өөрийн цагдан хяналт болон авлигын сэжигтэй хэлбэрүүд) RSF-д мэдэгдэхийг хүсье. Шаардлагатай тохиолдолд бид эрэн сурвалжлах боломжтой.
- Хятадын тухай дурдахдаа үнэн бодит байдлыг өнгөлөн далдлах зорилготой үг хэллэг ашиглахаас зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал, Шинжаан дахь хэлмэгдүүлэлтийг эш татахдаа “терроризмын эсрэг тэмцэл”, Тяньаньмэний хядлагыг дурдахдаа Тяньаньмэний “үйл явдал” гэх мэт.
- Хятадын Коммунист намын суртал ухуулгыг нэвтрүүлдэг ХМХ-үүдтэй хамтран ажиллахаас татгалзахыг, хэрвээ сэтгүүлчийн хувиар Хятадад урьсан бол хариуд нь танаас юу шаардахыг бодож үзэхийг зөвлөж байна.
- Хятадын талаас зохион байгуулж буй хэвлэлийн бага хурал гэх арга хэмжээнд оролцохдоо, Хятадын төлөөлөгчид болон албаны хүмүүс эдгээр арга хэмжээг суртал ухуулгын талбар болгон ашиглаж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Хятадын талын бэлтгэсэн суурь болон танилцуулах мэдээллийг урьдчилан судалснаар суртал ухуулгын стратегийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, шүүмжлэлтэй хэлэлцүүлэгт бэлтгэх боломжтойг зөвлөж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийтлэлчид, нийгмийн сүлжээнийхэнд өгөх зөвлөмж

- Гадны хүчин зүйлээс үүдэлтэй улс төр, эдийн засгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийх, үйл ажиллагааны явцад редакцын бодлогод хөндлөнгөөс оролцох аливаа үйлдлийг буруушаах.
- Цагдан хянах ба мөрдөн тагнахыг хүссэн аливаа хүсэлтээс татгалзах.
- Суртал ухуулгын агуулгатай аливаа мэдээллийг түгээхээс татгалзах.
- Бээжингийн дэглэмийн цагдан хяналт, суртал ухуулга, ХМХ -ийн хууль бус өмчлөл, сэтгүүлчдийг дарамтлах үйлдлийг илчлэх, эрэн сурвалжилгаа үргэлжлүүлэх.
- Цахим платформ нь мэдээлэл, харилцаа холбооны орон зайн бүтцийн талбар болохыг тодорхойлсон [Мэдээлэл ба ардчиллын төлөөх олон улсын тунхаглалд](#) заасан зарчмуудыг дагаж мөрдөн, хариуцлага ба эгэх хариуцлагын зарчмыг баримтлан, төвийг сахих, үнэн бодит мэдээллийг сурталчлах, олон ургальч үзлийг баримтлах, хяналт шалгалтад ил тод байх, сонор сэрэмжтэй байхыг зөвлөж байна.

АНХААРЛЫН ТӨВД

“Барьцаалагдсан эрх чөлөө”, цагдан хяналтаас бултсан толин ойлт бүхий цахим хуудсууд

RSF-ийн [#CollateralFreedom](#) (барьцаалагдсан эрх чөлөө) санаачилга үйл ажиллагааг нь хориглосон цахим хуудсуудыг дэлхийн интернэтийн аваргуудын харьяа олон улсын серверууд дээр “толин ойлт” буюу хуулбарлах стратеги ашиглах аргаар интернэтийн цагдан хяналтаас бултаж байна.


Аливаа улс орны зүгээс толин ойлтод хандах хандалтыг блоклох оролдлого хийх аваас тухайн сервер дээр байрлах бүх сайт, үйлчилгээнээс татгалзах ёстой болж, эдийн засагтаа томоохон хохирол учруулах эрсдэлтэй.

Хятадын хувьд дээрх төсөл нь *Tibet Post International*, *Mingjing News*, *China Digital Times*, *Миншэн Гуанча*, *Вэйчуанван* зэрэг цахим хуудаст толин ойлт хийх боломж олгодог.



© Reporters Without Borders (RSF)

RSF сэтгүүлчдийн аюулгүй байдлын



© Reporters Without Borders (RSF)

Хил хязгааргүй сурвалжлагчид нь (RSF) сэтгүүлчдэд зориулан бие махбодийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, мэргэжлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл бүхий нөөц платформ ажиллуулж эхэлсэн.

Пегасусыг илчилсэн шуугианаас үүдэн сэтгүүлчдийн өмнө өөрсдийгөө хамгаалах, эх сурвалжаа хамгаалах асуудал хурцаар тавигдав. RSF тэдэнд туслахын тулд, сэтгүүлчдэд зориулан бие махбодийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, мэргэжлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл бүхий нөөц платформ өөрийн цахим хуудаст байршуулсан. RSF Ковид-19-ийн талаар мэдээлэх, бие махбодийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, хууль эрх зүйн мэдээлэл, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан мэдээлэл авах болон бие даан суралцах платформыг сэтгүүлчдэд зориулан эхлүүлсэн ба мэдээллийг Англи болон Хятад хэлээр training.rsf.org цахим хуудаснаас авах боломжтой.

Платформ нь 50,000 гар утсыг тагнаж, тэр дундаа 180 орчим сэтгүүлчийн гар утсыг тагнаж байсан гэгдэх Израилийн тагнуулын програм Pegasus-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан. Мөн RSF-ийн зохион байгуулсан цуврал сургалтын дүрс бичлэг, ЮНЕСКО-той хамтран хэвлүүлсэн сэтгүүлчдэд зориулан RSF Аюулгүй байдлын гарын авлагын цахим хувилбарыг багтаасан болно.

RSF аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрөө арав орчим жил хэрэгжүүлж, үүнд дэлхийн өнцөг булан бүрээс 1800 гаруй сэтгүүлч хамрагдсан. Сургалтаас гадна RSF заналхийлэлд өртсөн ХМХ, дарамтлуулсан, баривчлагдсан сэтгүүлчдэд хамгаалалт, дэмжлэг үзүүлэх шуурхай тусламжийн арга хэмжээг санал болгодог.

RSF-ийн сэтгүүлчдэд зориулсан аюулгүй байдлын гарын авлага

RSF-ийн сурвалжлагын бүх үе шатанд практик зөвлөгөө өгөх зорилготой, эрсдэл өндөртэй орчинд ажилладаг Сэтгүүлчдэд зориулсан аюулгүй байдлын гарын авлагыг training.rsf.org-оос татаж авна уу. Энэ гарын авлагыг ашигласнаар, сурвалжлагчид эрсдэлийг үнэлж, ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэнэтийн нөхцөл байдалд илүү бэлтгэлтэй байх болно. Үүнд:

- Эрсдэлийн үнэлгээ хийх
- Эм, эмийн зүйлс ба вакцинууд бэлдэх
- Аялалд зориулсан иж бүрдлээ бэлтгэх
- Дайн тулаантай бүс эсвэл эрсдэл өндөртэй нутагт аялах
- Халдлага, отолт, бусад аюул заналхийлэлд бэлтгэлтэй байх
- Цахим аюулгүй байдлын шилдэг туршлагаууд
- Сэтгэцийн болон бие махбодийн хувьд өөрийгөө арчлах



RSF-ийн тайлан

Дэлхийд хэвлэл мэдээллийн шинэ дэг журам тогтоох Хятадын санаархал

2019 онд хэвлэгдсэн “Дэлхийд хэвлэл мэдээллийн шинэ дэг журам тогтоох Хятадын санаархал” нэртэй өмнөх тайландаа RSF Бээжингийн дэглэм мэдээллийн дарангуйлал тогтоох үзлээ хилийн чанадад түгээхээр оролдсон алхмуудыг буруушаасан юм.

Сэтгүүл зүйг төрийн суртал ухуулгатай адилтгасан “хэвлэл мэдээллийн шинэ дэг журмаа” тулгахын тулд Хятад улс олон улсын өргөн нэвтрүүлгийн бүтцээ орчин үед нийцүүлэн шинэчлэхээр ихээхэн мөнгө зарцуулах, гадаадын ХМХ-д хөрөнгө оруулалт хийх, хөгжиж буй орнуудын сэтгүүлчдийг Хятадад “сургах”-аар урих болов.

Тус дэглэм өөрийн санаачилсан “Бүс ба зам” олон улсын хөгжлийн төслөөр дамжуулан дарангуйлагч засаглалтай орнууд хэвлэл мэдээлэл, интернэтэд тавих хяналтаа чангатгахыг хөхиүлэн дэмжиж, шаардлагатай техник хэрэгслээр хангах болон зохицуулалт хийхэд тусалдаг. Хамрах хүрээг нь тооцоход өнөө хэр нь хэцүү байгаа энэ өсөлт дэлхийн ардчилал, хараат бус сэтгүүл зүйд шууд заналхийлж байна.



© Reporters Without Borders (RSF)

Энэ тайланг (франц, англи, уламжлалт хятад болон хялбаршуулсан хятад хэлээр дээр) RSF-ийн цахим хуудаснаас татан авах боломжтой. Эсвэл энэ линкээр: <https://bit.ly/3BxFH2N> орж үзэж болно.

Тайлбар толь

Хятад дахь мэдээллийг хянах аппарат




Ши Жиньпин

Хятадын Коммунист намын ерөнхий нарийн бичгийн дарга, 2012 оны 11 дүгээр сараас Цэргийн төв зөвлөлийн дарга, 2013 оны 3 дугаар сараас БНХАУ-ын даргаар ажиллаж байгаа. Ши Жиньпин Хятадын үндсэн хуульд өөрийн “үзэл санааг” тусгасан нэмэлт өөрчлөлт оруулж, тус улсыг бүх насаараа удирдах болсон.




Кэрри Лам

Лам нь 2017 оны 7 дугаар сард Хонконгийн захирагчаар томилогдсон цагаас хойш “эх оронч үзэл” нэрийн дор Хятадын дэглэмийн цагдан хяналтыг байнга хамгаалсаар ирсэн. 2019 оны ардчиллыг дэмжигч жагсаалын үеэр цагдаагийн алба хаагчид сурвалжлагчдад халдсаныг санаатайгаар үл хайхарсан. Түүний бүрэн эрхийн хугацаанд 12 орчим сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр яллагдагчаар татагдсаны арав нь өнөөг хүртэл хоригдсоор байна.



Суртал ухуулгын газар

Зарим үед “Сурталчилгааны хэлтэс” гэж орчуулдаг Хятадын Коммунист намын энэ байгууллага Төв Хорооны Суртал ухуулга, үзэл суртлын ажлын тэргүүлэгч бүлгийн баталсан суртал ухуулгын удирдамжийг хэрэгжүүлдэг. 2018 оноос хэвлэл мэдээлэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг шууд хариуцах эрх мэдэлтэй болсон.



Төрийн зөвлөлийн мэдээллийн алба

Суртал ухуулгын газрын шууд удирдлагад ажилладаг энэ захиргааны алба нь ХМХ-үүд дагаж мөрдөх ёстой үйл явдлын албан ёсны “эерэг хувилбар”-ын төслийг боловсруулж, олон улсын ХМХ-ээр нэвтрүүлж буй Хятадын дэглэмийн албан ёсны суртал ухуулгын шугамтай зөрчилдсөн мэдээ, мэдээллийг няцаахын тулд ямар эсрэг санаа оноо гаргахыг хянадаг.



Нэгдсэн Фронтын ажлын алба

Хятадын Коммунист намын энэ нууцлаг салбар гадаадын ХМХ-рүү гадаад мөнгөн гуйвуулга хийхдээ (хятад хэлээр явдаг ХМХ-ийг оролцуулан), тухайн ХМХ-ийн хувьцааг худалдан авах эсвэл зар сурталчилгаа явуулах эсэхээ шийддэг.



Хятадын Цахим орчны захиргаа

Ши Жиньпиний өөрөө тэргүүлдэг энэ агентлаг 2014 онд байгуулагдсан ба Кибер орон зайн асуудал эрхэлсэн төв комиссийн интернэтийн асуудлаар гаргасан бодлогыг хэрэгжүүлдэг. Цахим орчны захиргаа нь интернэт орчин дахь цагдан хяналт, мөрдөн тагналт, суртал ухуулгын арга хэмжээг хянадаг.



Синьхуа мэдээллийн агентлаг

Намын хатуу хяналтад ажилладаг төрийн мэдээллийн агентлаг нь 10,000 гаруй ажилтантай, арван хэл дээр (хятад, япон, солонгос, араб, орос, англи, герман, франц, испани, португал) нийтлэл, нэвтрүүлэг явуулдаг бөгөөд олон улсын 162 товчоотой ба Хонконг, Каир, Найроби, Нью-Йорк, Мехико, Брюссель зэрэг хотод бүсийн төв салбартай.



Хятадын хэвлэл мэдээллийн групп (CMG)

2018 оны 3 дугаар сард албан ёсны нээлтээ хийсэн, албан бусаар “Хятадын дуу хоолой” гэгддэг энэ олон улсын байгууллага дэлхий дахинд суртал ухуулгын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд Хятад улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн бүх бүтцийн бүтээмж, сурталчилгааны чадавхийг нэгтгэх зорилготой.



Хятадын Глобал Телевизийн сүлжээ (CGTN)

Өмнө нь CCTV-9, CCTV-ийн мэдээний алба гэгддэг байсан төрийн мэдлийн кабелийн телевизийн мэдээний алба нь дэлхийн 160 онд нэвтрүүлэг бэлтгэж, таван хэлээр (Хятад, Англи, Араб, Франц, Орос) цацдаг. CGTN нь 70 товчоо, гурван нэвтрүүлгийн төвд (Лондон, Вашингтон, Найроби) нийтдээ 10,000 гаруй ажилтантай.



Хятадын олон улсын радио (CRI)

1941 онд үүсгэн байгуулагдсан төрийн өмчит олон улсын радио станц нь Хятадын үндэсний радиотой хамтран ажиллаж, мөн бүх талын дэмжлэг авдаг тул нөөц боллоцоо сайтай. CRI нь Хятадын олон улсын өргөн нэвтрүүлгийн сүлжээний (CIBN) гадаадын 70 гаруй орон дахь радио станцаас 44 хэлээр нэвтрүүлгээ цацдаг.



China Daily

1981 онд үүсгэн байгуулагдахдаа зөвхөн англи хэл дээр хэвлэгдсэн, төрийн мэдлийн өдөр тутмын энэ сонин өдөртөө 900,000 хувиар хэвлэгддэг (хэвлэмэл болон цахим хувилбараар) бөгөөд нийтдээ 150 сая уншигчтай гэж мэдэгдсэн. Олон улсын удирдагчдын үзэл бодолд нөлөөлөхөд чиглэсэн тусгай дугаар нь дэлхийн нэр хүндтэй сонинуудын хавсралтаар өдөрт 4 сая гаруй хувиар хэвлэгддэг.



Өдөр тутмын Ард түмний сонин

1948 онд үүсгэн байгуулагдсан, өдөр тутмын энэ сонин нь Намын суртал ухуулгын албан ёсны хэвлэл ба редакцын нийтлэлийг Суртал ухуулгын төв газар бэлтгэдэг. Өдөрт 3 сая хувиар хэвлэгддэг хэмээн мэдэгдсэн тус сонины цахим хуудас хятад хэлний мандариан аялгуунаас гадна гадаадын болон Хятадын үндэстний цөөнхийн 16 хэл дээр үйл ажиллагаа явуулдаг.



Глобал Таймс (Global Times)

1993 онд олон улсын мэдээ, мэдээлэлд тайлбар хийхэд зориулан Ардын өдрийн сонины хавсралтаар анх гарсан хэт үндсэрхэг үзэлтэй шар хэвлэл. Хятад хэл дээрх хувилбар нь 1 сая хувь, 2009 оноос хойш гарах болсон англи хэл дээрх хувилбар нь 100,000 хувь хэвлэгддэг ба тус сонины 10 хэл дээр үйл ажиллагаа явуулдаг цахим хуудаст өдөртөө 15 сая хүн нэвтэрдэг гэж мэдэгдсэн.



Хятадын олон улсын хэвлэлийн групп

1949 онд үүсгэн байгуулагдсан, Хятадын олон улсын хэвлэлийн групп нь гадаад хэл дээрх хамгийн том хэвлэлийн газар. 10 гаруй хэл дээр хэвлэдэг уг групп олон улсад 20 төлөөлөгчийн газартай. 1958 оноос эхлэн хэвлэсэн Бээжингийн тойм хэмээх Хятадын цорын ганц англи хэл дээрх сэтгүүлийг энэ хэвлэлийн газар эрхлэн гаргадаг.



Хонконгийн тэргүүлэх хэвлэл мэдээлэл

Та Кун Пао, Вэн Вэй По, Финикс ТВ зэрэг Бээжингийн нөлөөнд автсан эсвэл бүрэн хяналтад байдаг Хонконгийн хятад хэл дээрх зарим ХМХ нь хилийн чанад дахь Хятад иргэдийн дунд Хятадын суртал ухуулгын сурталчилгааг түгээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хятадын цахим худалдааны тэргүүлэгч том компани Алибаба 2016 онд англи хэл дээр гардаг Өмнөд Хятадын өглөөний шуудан (South China Morning Post) сонинг худалдаж авахад олон хүн энэ худалдан авалтын цаана Бээжингийн нөлөө нуугдаж байгааг олж харсан.



Хилийн чанад дахь Хятадын ХМХ

Бээжингийн дэглэм хилийн чанад дахь Хятадын тэргүүлэгч үүрэгтэй ХМХ-ийн дийлэнх хэсгийг хяналтандаа авчээ. Хятадын дэглэмээс хараат бус, сөрөг шүүмжлэл өрнүүлдэг байсан Шинэ Зеландийн *Chinese Herald*, Австралийн *Pacific Times* сонинууд одоо дэглэмийн суртал ухуулгын хэлтэс болж хувирсан. Хятад улс суртал ухуулгын үзэл бодлоо хилийн чанад дахь Хятад иргэдийн дунд түгээх зорилгоор АНУ-д *Чяобас* (*China Press*) нэртэй өөрийн эзэмшлийн ХМХ-ийг үүсгэн байгуулсан.



Хятадын ЭСЯ-дууд

Хятадын ЭСЯ-амд тэдний сэтгэлд нийцээгүй үйлдэл хийсэн сэтгүүлчид, эрдэмтэн судлаачдыг айлган сүрдүүлэх гэж оролддог нь гэм биш зан болсон. Элчин сайд нар нь өөрсдөө Хятадын аливаа үйлдлийг “сөргөөр тайлбарлаж” байна хэмээн олон нийтийн өмнө буруутгаж, мэдээлэл тараасан хүнийг сүрдүүлэх, гадаад орны нийгмийн сүлжээг дарамтлахаас буцааггүй.




Күнзийн хүрээлэн

2004 онд Хятадын Соёл, боловсролын яам, намын Суртал ухуулгын төв газрын санхүүжилтээр байгуулагдсан Күнзийн хүрээлэнгийн сүлжээ нь Хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй ба дэлхийн 154 орны 500 гаруй их сургуультай хамтран ажилладаг. Хятадын Коммунист намын түүх, улс төрийн бодлогын талаарх суртал шингээсэн хувилбараа тулгахыг оролддог тул эдгээр хүрээлэнтэй хамтын ажиллагаагаа цуцлах их дээд сургуулиудын тоо улам бүр нэмэгдэж байна.




“50-центийн арми”

Анх бичсэн сэтгэгдэл бүрийн тоогоор цалинждаг байснаас ийнхүү нэрлэгдэх болсон цахим орчинд сэтгэгдэл бичдэг хүмүүс нь хятадын жирийн иргэдийн дүр эсгэн бусдыг төөрөгдүүлж, дэглэмийн суртал ухуулгыг сурталчлах үүрэгтэй.




“Бяцхан ягаанууд”

Дэглэмийг дэмжигч, аль болох олон сэтгэгдэл бичүүлэхээр хөлслөдөг байсан “50 центийн арми”-ийн троллуудаас ялгаатай нь хэт үндсэрхэг үзэлтэй эдгээр троллууд өөрсдөө сайн дураараа дотоод, гадаадын нийгмийн сүлжээнд Хятадыг шүүмжилсэн хүн бүхэн рүү дайрч давшилдаг. Эдгээр троллуудын ихэнх нь залуу эмэгтэйчүүд байдаг, тэдний ихэнх нь ийм өнгийн хувцас өмсдөг гэж андуурснаас ийнхүү нэрших болсон.



WeChat (мессежний апп)

Хятадын технологийн тэргүүлэгч компани Tencent-ийн 2011 онд бүтээн хөгжүүлсэн, дэлхий даяар 1 тэрбум гаруй байнгын хэрэглэгчтэй Хятадын хамгийн том нийгмийн сүлжээний платформ юм. WeChat-ын цуглуулсан шифрлэсэнээс бусад бүх өгөгдлүүдийг Хятад дахь сервер хянан зохицуулдаг ба энэ нь Хятадын дэглэмд цагдан хяналт, мөрдөн тагналт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чухал эх сурвалж болдог.



Сина Вейбо (богино хэмжээний блог хөтлөгчдийн сайт)

нээгдсэн “Хятадын твиттер” нь 550 сая гаруй идэвхтэй хэрэглэгчтэй ба Хятадын хоёр дахь том нийгмийн сүлжээ юм. Тус компани цагдан хянах замаар намын зүгээс “хор хөнөөлтэй” гэж үзэж болзошгүй агуулга, түлхүүр үгсийг блоклох, хаах зэрэг арга хэмжээ авдаг.



Байду (хайлтын систем)

1999 онд бүтээн хөгжүүлсэн энэхүү хайлтын систем нь Хятадын хайлтын системийн зах зээлд ноёрхож, олон улсад Google-ийн дараа хоёрдугаарт орохын зэрэгцээ Википедиа цахим нэвтэрхий толь бичигтэй төстэй хуулбар зэрэг олон үйлчилгээг санал болгодог. Хэдийгээр төрийн цагдан хяналт, суртал ухуулгатай хамтран ажилладаг гэдгээрээ нэрд гарсан ч сүүлийн арваад жилийн турш олон улсын зах зээлд гарч хөгжихийг чармайсан ч төдийлөн амжилт олоогүй.



Huawei (харилцаа холбооны групп)

Энэ нь 1987 онд Хятадын армийн цэргийн алба хаагч асны үүсгэн байгуулсан дэлхийд харилцаа холбооны тэргүүлэгч компанийн нэгд тооцогддог. Хятадын технологийн бусад компанийн нэгэн адил Хятадын цагдан хяналт, мөрдөн тагналтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд оролцож, дарангуйлагч дэглэмтэй орнуудад өөрийн технологийг нэвтрүүлэхэд тусалдаг.



Дэлхийн Интернет бага хурал (WIC)

2014 оноос Жэжян мужийн Вужэн хотод жил бүр зохион байгуулдаг энэ арга хэмжээ нь олон улсын хамтын нийгэмлэгийг “кибер орон зайд хамтын ирээдүй” байгуулахад нэгдэхийг уриалдаг. Хятад улс “кибер бүрэн эрхт байдал” хэмээх үзэл баримтлалыг сурталчлах замаар эдгээр бага хурлыг цагдан хяналт, мөрдөн тагналтын арга барилаа нэвтрүүлэхэд ашигладаг.




Дэлхийн хэвлэл мэдээллийн дээд хэмжээний уулзалт (WMS)

2009 онд Хятад улсын эхлүүлсэн эдгээр дээд хэмжээний уулзалт нь дэлхийн бүх ХМХ-ийг “21 дүгээр зууны сорилтыг даван туулах”-д нэгдэхийг уриалдаг. Дээд хэмжээний эдгээр уулзалтыг Хятад улс барууны хэвлэл мэдээллийн ноёрхлыг буруушааж, мэдээллийн тэнцвэргүй байдлыг арилгахыг уриалахдаа ашигладаг.



BRICS-ийн Хэвлэл мэдээллийн форум (BMF)

2016 оноос хөгжиж байгаа эдийн засагтай таван орон, BRICS нэрийн дор (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) нэгдсэн. Эдгээр орнуудын ХМХ-ийн төлөөлөгчид жил бүр тус форумд цуглардаг. Энэ форум нь Хятадад бусад дөрвөн орны хэвлэл мэдээллийн зохицуулалт, үйл ажиллагаанд нөлөөлөх боломж олгодог.



Бадиуцаогийн зурсан нүүр хуудасны зураг

Тайлангийн хавтасны зургийг Хятадын нийгэм, улс төрийн хурцадмал олон асуудлыг уран бүтээлдээ тусган, цагдан хяналтын дэглэмийг эсэргүүцэн тэмцсэн Хятадын зураач [Бадиуцао](#) бүтээсэн юм. Бадиуцао нь BBC, CNN, China Digital Times, Freedom House зэрэг агентлагуудтай олон төсөл дээр хамтран ажиллаж байсан ба түүний уран бүтээл Австрали, Итали, АНУ-д үзэсгэлэнд тавигдсан. 2018 онд түүний Хонконгд гаргах үзэсгэлэн эцсийн мөчид Бээжингийн сүрдүүлэг, дарамтаас болж цуцлагдсан. 2021 онд Италийн Брешиа хотод Хятадын Элчин сайдын яамнаас хотын захиргаанд шахалт үзүүлсэн хэдий ч тэрээр бие даасан үзэсгэлэнгээ гаргаж чадсан.



ХИЛ ХЯЗГААРГҮЙ СУРВАЛЖЛАГЧИД (RSF) нь дэлхий дахинд чөлөөт сэтгүүл зүйн хараат бус байдал, олон ургалч үзлийг таниулан сурталчилж, хамгаалдаг. Парист төвтэй тус байгууллага нь НҮБ болон ЮНЕСКО-д зөвлөх статустай ба олон улсын арван дөрвөн товчоотой, дэлхийн 130 оронд сурвалжлагч нар нь ажилладаг.

Ерөнхий нарийн бичгийн дарга: **Кристоф Делуар**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Катерине Моннет**

Зохиогч: **Седрик Алвиани / RSF-ийн Зүүн Ази хариуцсан товчоо**

Зохицуулалтын алба: **Александра Вилаковска**

Редактор: **Кароле Коен**

Нүүр хуудасны зургийг: **[Бадиуцао](#)**

График дизайныг: **[Модулар агентлаг](#)**

ОЛОН УЛСЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР - CS 90247 - 75083 PARIS CEDEX 02

УТАС: +33 1 44 83 84 84

WWW.RSF.ORG